



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ЭРҮҮГИЙН ХЭРЭГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2024

IX сар

Улаанбаатар хот

Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааны багийн гишүүд:

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан

Х.Санчир

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан

М.Энхжин

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан

Э.Энхжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	7
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	7
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	8
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	8
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	11
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	12
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	12
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	13
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	16
3.1. “ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	16
3.1.1. АВЛИГЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	16
3.1.2. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22.10 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	27
3.1.3. ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	32
3.1.4. ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА	39
3.1.5. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	52
3.2. “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	60
3.2.1. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ОЛСОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХ ТУХАЙ ОЙЛГОЛТ	60
3.2.2. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ	68
3.2.3. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХТАЙ ХОЛБООТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	73
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	75
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ	79
ХАВСРАЛТ	81
Гадаадын улс, орнууд дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа	81



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТИ	Авлигын төсөөллийн индекс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МУГХУСАЗЗ	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
УДШ	Улсын Дээд Шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1.** Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд
- Хүснэгт 2.** “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт
- Хүснэгт 3.** Монгол Улсын авлигын индекс өгсөн үнэлгээ
- Хүснэгт 4.** Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт
- Хүснэгт 5.** Шалгасан хэрэг
- Хүснэгт 6.** Шалгасан хэрэг /төрлөөр/
- Хүснэгт 7.** Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал
- Хүснэгт 8.** Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалт
- Хүснэгт 9.** Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал
- Хүснэгт 10.** Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа
- Хүснэгт 11.** Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа
- Хүснэгт 12.** Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл
- Хүснэгт 13.** Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хөнгөн, хүнд гэмт хэрэгт ижил тоолохоор хуульчлагдсан жишээ
- Хүснэгт 14.** 2022, 2023 онд нэмэлтээр оруулсан зохицуулалт
- Хүснэгт 15.** Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа
- Хүснэгт 16.** Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан



УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “...Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно...” гэж, мөн 4.2.1-д “...Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно...” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “...нийгмийн хор аюул, үйлдэгдэж байгаа арга, хэлбэрээс хамаарч зарим гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ...” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6 дахь хэсгийн “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.” гэж тус тус заажээ.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан зохицуулалтууд нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, ялын бодлогыг чангатгах, гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох гэх мэт олон асуудлыг хөндөж байна. Энэхүү зохицуулалтуудыг хэрэгжүүлэхийн тулд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-ийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, зарим гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, эрүүгийн хариуцлагыг чангатгах асуудал нэн тэргүүнд тавигдаж байсан. Иймээс ч УИХ-аас 2022 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, тус хуулиар Авлигын гэмт хэрэгтэй холбоотой хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

Иймд энэхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болон авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тус гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураахтай холбоотойгоор Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтыг сонгон хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тогтов.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийх энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-ийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой хууль юм. Энэ ч утгаараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хариуцлагын хэлбэр билээ. Хүн бүр тэгш эрхтэй ч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэн эрүүгийн хариуцлага хүлээж буй хүний эрхийг хуулиар хязгаарлах нь зүйн хэрэг. Нөгөөтээгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладаг Эрүүгийн хууль нь эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал энэ нь эргээд нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож, хүний эрхийг хязгаарлах гол хэрэгсэл болж хувирахыг ч үгүйсгэх аргагүй юм.


Хууль шударга ёсыг тогтоох хэрэгсэл гэтэл эсрэгээрээ шударга бус зүйлийг бий болгох эх уурхай болж болохгүй гэдгийг санах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж¹ улмаар Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Хэдийгээр шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд долоон жилийн хугацаа өнгөрч байгаа боловч Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгааг салбарын эрдэмтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид хөндсөөр ирсэн.

Тэр дундаа сүүлийн жилүүдэд авлигын гэмт хэрэгтэй холбоотой асуудлууд олон нийтийн анхаарлын төвд ороод байна. Тухайлбал, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа бага байгаа нь тухайн гэмт хэргийг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болж байна, мөн тус гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ бага атлаа

¹ Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, УБ., 2013 он.



нийгмийн хор аюулын шинж их, зарим гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн ч үндсэн бүрэлдэхүүнтэйгээ ижил хэмжээний ял оногдуулахаар хуульчилсан гэх мэт олон асуудалд үүсээд байсан билээ.

Иймд УИХ-аас 2022 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн батлан авлигатай холбоотойгоор тус хуульд нэлээн хэдэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан билээ. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч одоо ч зарим зохицуулалтын хувьд практикт маргаан дагуулсан хэвээр байна. Иймд практикт маргаан дагуулаад байгаа авлигын гэмт хэргийн зарим зохицуулалт болон холбогдох бусад зохицуулалтын хэрэгжилт үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн хэмээн үзэж энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Мөн авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураахтай холбоотойгоор Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан зарим зохицуулалтын хэрэгжилтийг судлан үзнэ. Учир нь авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах асуудал нь практикт түгээмэл үйлдэгддэг зарим гэмт хэрэгтэй харьцуулахад ээдрээ төвөгтэй, цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, хамтын ажиллагаа гэх мэт олон талын асуудлаас шалтгаалж байдаг. Иймд авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураахад тус зохицуулалтын хэрэгжилтийг тус тус судална.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх нь чухал. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай. Иймээс дээр дурдсан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага, шалтгаанд тулгуурлан Эрүүгийн хуулийн 22 бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, түүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүй хөрөнгөжих” гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт, тус гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалтуудад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр тогтлоо.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;

2. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл, заалтын нэг болох Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг /Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүй хөрөнгөжих/ болон Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийг тус тус сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүй хөрөнгөжих	22.10 дугаар зүйл.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих 1.Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно. 2.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл.	1.10 дугаар зүйл.Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа 1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: 1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн; 1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;

		1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн. 1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн. 2.Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно. 3.Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно. 4.Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. 5.Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна. 6.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно. 7.Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ. 8.Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. 10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.
--	--	--

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Иймд судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, мөн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр бүлэгт заасан хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зарим зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.
2.	Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.	1.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.
3.	ЭХХШТХ-ийн 21 дүгээр бүлэг.	21.1 дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах 1.Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна. 3.Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна. 4.Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно. 21.2 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх 1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ. 2.Шүүх, прокурорын шийдвэрээр хураан авсан эд мөрийн баримт овор хэмжээ ихтэй, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол мөрдөгч байгаа газарт нь битүүмжилнэ. 3.Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ. 5.Эд хөрөнгө битүүмжлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хүний өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй. 6.Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, нэгжлэг хийх ажиллагаатай хамт явуулж болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох



Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Эрүүгийн хууль, ЭХХШтХ-ийн дээр дурдсан зүйл, заалтад хамаарах агуулга тус бүр дээр байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг харьцуулан судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Эрүүгийн хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг зорилгодоо хүрсэн эсэх?, /Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дэлгэрүүлэн судална./

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх? Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хураахад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор тухайн асуудлын хүрээнд гаргасан ном, сурах бичиг, гарын авлага, судалгааны тайлан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, шүүхийн шийдвэр уншиж судлах, түүхчилсэн, харьцуулсан судалгаа хийх, холбогдох байгууллагаас судалгаа мэдээлэл авах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;

- 
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүлээ;

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Эрүүгийн хууль, ЭХХШтХ холбогдох сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, шүүхийн шийдвэр, статистик мэдээ зэргийг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд Авлигын гэмт хэрэг, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд хуульч, өмгөөлөгчдөөс ярилцлагын аргаар судалгаа авч, холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хууль, ЭХХШтХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, 2003 он
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006, №35;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012, №8;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017, №24;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”;
- Улсын Дээд Шүүхийн тогтоол, 2022.03.09, Дугаар 11;

НОМ, СУРАХ БИЧИГ, СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЭМХЭТГЭЛ

- Авлига болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж практик /гарын авлага/, УДШ, 2022 он;
- АТГ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;
- Б.Мөнгөнсүвд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, 2024он
- Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, 2020 он;
- Г.Халиунаа, Б.Ариунжаргал, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа: Тулгамдаж буй асуудал, 2021 он;
- Д.Бадам, “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй(Тайлбар толь)” 2018 он;
- Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 2012 он;
- Ж.Батмөнх, Хууль бусаар баяжих гэмт хэргийг Монгол улсын Эрүүгийн хуульд хуульчлах шаардлага, 2011 он;
- Жан-Пьер Бран, Анастасия Сотиропаолу нар, Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага /Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл/, АТГ, УЕПГ, Дэлхийн банк, 2020 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСА33, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСА33, 2018 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2018, МУГХУСА33, 2019 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2019, МУГХУСА33, 2020 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2020, МУГХУСА33, 2021он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2021, МУГХУСА33, 2022 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2022, МУГХУСА33, 2023 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, 1999 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он;
- Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, 2019 он;
- Э.Зууннасан, Б.Батзориг, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, 2006 он;
- Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2022 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он;

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ ЭХ СУРВАЛЖ

- 
- Criminal Law of the People's Republic of China
<https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm>
 - German Criminal Code https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html
 - Уголовный кодекс российской федерации
http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/

БУСАД ЭХ СУРВАЛЖ

- Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.
- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- Авлигатай тэмцэх газар, <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim>
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1011 дугаар магадлал.
- УДШ-ийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 121 дугаар тогтоол
- ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 13-ны өдрийн 377 дугаар цагаатгах тогтоол.
- ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 2021/ШЦТ/516 дугаартай шийтгэх тогтоол.



ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн сонгосон зүйл, заалтуудыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. “ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улс авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийг судлан үзэж, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн зохицуулалтын зорилгодоо хүрсэн эсэх, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн талаарх ойлголт, гадаад улс орны туршлагыг судлан үзнэ.

Мөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал, гадаад орны туршлагыг тус тус судална.

3.1.1. АВЛИГЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Монгол Улсын Их Хурал 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан.² Улмаар 2005 онд манай улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орж, улмаар 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Сүүлийн жилүүдэд манай улсад авлигын асуудал ихээхэн анхаарал татсан, зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг болоод байна.

2023 онд Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн дүнгээр Монгол Улс 33 оноо авч, 180 улс орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн. Уг индексээр Монгол Улс 2012-2023 онд дунджаар 36.17 оноо авсан. Сүүлийн 12 жилийн хугацаанд АТИ-ийн дэлхийн дундаж оноо өөрчлөгдөөгүй буюу 43 оноо байна (боломжит 100 онооноос). Дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан нь эдгээр улс орнуудад авлига ноцтой асуудал болсныг илтгэж байна. Мөн шүүхийн тогтолцоо суларч буй дэлхий нийтийн чиг хандлага нь нийтийн албан тушаалтны хариуцлагыг бууруулж, улмаар авлига цэцэглэх боломжийг олгож байгааг Транспэрэнси Интернэшнл байгууллага онцлон тэмдэглэжээ.

² Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhenzarchim>

Сүүлийн 4 жилд авлигын индекс оноо өгдөг судалгааны байгууллагууд манай улсад дор дурдсан оноог өгсөн байна.

Хүснэгт 3. Монгол Улсын авлигын индекс өгсөн үнэлгээ³

№	Байгууллага-судалгаа	2020	2021	2022	2023
1	Пи Ар Эс групп – Эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	41	37	32	33
2	Ай Эм Ди – Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл, Үзэл бодлын судалгаа 2020, 2021	32	29	30	33
3	Ардчилалын олон талт байдлын төсөл 2020, 2021	34	34	28	25
4	Дэлхийн эдийн засгийн форум – Үзэл бодлын судалгаа	28	34	30	-
5	Бертелсман сан – Шилжилтийн индекс 2020, 2022	37	37	37	37
6	Дэлхийн банк – Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2019, 2020	35	-	-	-
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж – Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	33	33	37	37
8	Дэлхийн эрх зүйн төсөл – Хууль дээдлэх ёсны индекс	33	35	35	33
9	Глобал инсайт байгууллага – Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019, 2020	35	35	35	35
Дундаж оноо		35	35	33	33

Манай улс авлигын төсөөллийн индексийн дундаж оноогоор:


- 2020 онд 35 оноо авч 180 орноос 111 дүгээр байр;
- 2021 онд 35 оноо авч 180 орноос 110 дугаар байр;
- 2022 онд 33 оноо авч 180 орноос 116 дугаар байр;
- 2023 онд 33 оноо авч 180 улсаас 121 дүгээр байрт тус тус эрэмбэлэгджээ.

Дээрх тоон мэдээнээс харвал, 2022, 2023 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад авлигын төсөөллийн индексийн оноо 2-оор буурч, 6-11 байр ухарсан үзүүлэлттэй байна. Авлигын индекс буурч, хэлбэлзэж байгаа нь ардчилсан тогтолцоо бэхжээгүй, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг улс төрийн намуудын төлөвшил муу байгааг шууд харуулж байна.

Тус судалгаанд Ази номхон далайн бүс нутгаас хамрагдсан 31 орны дундаж оноо нь 45 байхад Монгол Улс бүс нутгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Энэхүү судалгаанд хамрагдсан 180 орноос дундаас доогуур орлоготой 50 улсын авлигын төсөөллийн индексийн дундаж оноо нь 33 байна. Харин манай улсын хувьд сүүлийн 2 жил 33 оноо нь авсан нь энэ ангилалд багтах үндэслэл болж байна.

Тиймээс ч төрийн бодлогын баримт бичгүүдэд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тусгайлан тусгах болсон. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2.7-д "...хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх..." гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан "...нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах..." бүрэн эрхийнхээ хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын "Засаглал"-ын зорилт, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Төрийн бүтээмжийн сэргэлт"-ийн

³ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номын тоон мэдээнээс, /2020, 2021, 2022 он/



зорилтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан.

Монгол Улсын хэмжээнд авлигатай тэмцэхэд зорилгоор төрөөс баталсан эрх зүйн баримт бичгүүдээс дурдвал:

1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол

Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан.

2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулж “Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа”-г хавсралтаар баталсан. Үүнд:

Нэг.Шүгэл ажиллагаа

- Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар нийтийн эрх ашгийн төлөө мэдээлж байгаа шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар батлуулах;
- Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;
- Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.

Хоёр.Шүүр ажиллагаа

- Улс төрд нөлөө бүхий этгээдийн хууль ёсны орлогоос давсан хэрэглээг таслан зогсоох, нийтийн албанд танилын хүрээгээр томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх, холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэх;
- Төрийн алба, төрийн өмчийг "шимэгчид"-ээс салгах;
- Авлига, албан тушаалын гэмт хэргийг хуулийн хүрээнд бүрэн гүйцэд, шуурхай шалган шийдвэрлүүлэх.

Гурав.Шувуу ажиллагаа

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улс руу оргон зайлсан этгээдийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд эргүүлэн авчрах, хариуцлага хүлээлгэх;
- Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах.

Дөрөв.Шилжүүлэн авах ажиллагаа

- Оффшор бүс болон гадаад улсад нуун дарагдуулсан хууль бус хөрөнгийг илрүүлэн буцаан авчрах;
- Гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг хураах үйл ажиллагааг ил тод болгох, сан бүрдүүлж, олон нийтийн оролцоотойгоор зарцуулах тогтолцоог бүрдүүлэх.

Тав.Шил ажиллагаа

- Цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох;
- Төрийн өмчит компаниудыг олон нийтийн хяналттай, нээлттэй компани болгох, ур чадвар бүхий менежментийн багийг ажиллуулах;

- Улс төрийн намын хууль, эрх зүйн орчныг сайжруулж, улс төрийн болон улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, олон намын оролцоотой шударга өрсөлдөөнтэй, ардчилсан парламентын засаглалыг төгөлдөржүүлэх;
- Ёс зүйтэй, шударга өрсөлдөх орчныг бүрдүүлж, цэвэр, тунгалаг бизнесийг дэмжин хөгжүүлэх.

2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030 он/

Тус хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- Сонгуулийн үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглож, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Сонгуулийн бус үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглоно.
- Намын санхүүжилт, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх замаар намын хариуцлага, ёс зүй, ил тод байдлыг сайжруулна.
- Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахуйц эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх, сонгуулийн болон сонгуулийн бус үеийн санхүүжилтийг ил тод болгож, сонгуулийн зардлыг бууруулан иргэний сонгох, сонгогдох эрхийг хамгаалах, нэр дэвшигчийг өрсөлдөх тэгш боломжоор хангана.
- Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэн оролцох, нөлөөлөх /лоббидох/ эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн, тогтвортой байдлыг бэхжүүлнэ.
- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоно.
- Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.
- Төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.
- Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.
- Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ, бүтцийг олон улсын жишиг, сайн туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжийг үндэслэн оновчтой тодорхойлж, олон нийтийг төлөөлөх боломж, нөхцөлийг хангасан эрх зүйн орчныг боловсронгуй болгоно
- Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.
- Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.
- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Бизнесийн ёс зүй, Компаенсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа авлигын хүчин зүйлсийг арилгана.
- Авлигын улмаас олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.
- Авлигатай тэмцэх газрын төсөв, санхүү, хүний нөөцийн чадавхыг сайжруулах цогц арга хэмжээг авч олон улсын жишигт хүргэнэ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид үнэлгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар иргэдийн итгэл хүлээсэн шүүхийн тогтолцоог бэхжүүлнэ.
- Прокурорын байгууллагын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хараат бус байдлыг нэмэгдүүлнэ.
- Авлигын эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлнэ.
- Авлигатай тэмцэхэд төрийн аудитын байгууллагын үр нөлөөтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг бүрэн хангана.
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.
- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бүрдүүлнэ.
- Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.
- Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, төлөвлөлт, ашиглалт, зарцуулалт, дуудлага худалдааг нээлттэй, боловсронгуй болгож, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.
- Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Төрийн аудит, дотоод аудитын тогтолцооны хараат бус, ил тод, бие даасан байдлыг бэхжүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын томилгоог ил тод болгож, олон улсын хөрөнгийн зах зээлийн нээлттэй компанийн жишигт нийцсэн хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг завших, үрэгдүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг холбогдох тооцоо, судалгаа, зардал, үр ашгийн тооцоонд үндэслэн үүсгэн байгуулах, татан буулгах, бүтцэд өөрчлөлт оруулах шалгуур, шаардлага, журмыг боловсронгуй болгоно.

- Байгалийн баялгийн орлого, үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, иргэнд тэгш, шударга хүртээнэ.
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологийн дэвшил, судалгаанд суурилсан байдлаар төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээнэ.
- Ёс суртахуун, хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрийг олон улсын туршлагад тулгуурлан шинэчлэлт, үнэлгээ хийж хэвшүүлнэ.
- Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.
- Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.
- Авлигын эрсдэлтэй үйл ажиллагаа, салбарын онцлог, нөхцөл байдалд чиглэгдсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тооцож хэвшинэ.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах тусгайлсан бодлого, хөтөлбөр, тогтолцоог бий болгоно.
- Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хариу арга хэмжээний санхүүжилт, хандив, тусламжийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэлийн мөрөөр авч хэрэгжүүлэх хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Ирээдүйд тулгарч болзошгүй нөхцөл байдлын үеийн авлигын эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

3. Авлигын эсрэг хууль /2006 он/

Авлигын эсрэг хуулийн зорилго нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хууль нь олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, авлигатай тэмцэх байгууллага, түүний бүрэн эрх, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны баталгааны талаар зохицуулдаг. Энэ хуулийн зарим зохицуулалт “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” судалгааны ажил хийгдэж байгаа учир дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

2012 онд батлагдсан тус хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино. Тус хууль ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хуулийн хэрэгжилтийг хянах талаар зохицуулалтыг агуулдаг. Энэ хуулийн зарим

зохицуулалт “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” судалгааны ажил хийгдэж байгаа учир дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

5. Эрүүгийн хууль /2015 он/

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт Авлигын гэмт хэргийг тусгайлан хуульчилсан. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/,
- Эрүүгийн хуулийн 22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/,
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хахууль авах/,
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/,
- Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/,
- Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/,
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/,
- Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/,
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/,
- Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/,
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/,
- Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйл /Хахууль авах/ гэмт хэргийг тус тус хуульчилжээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тэдгээрээс 2022 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн нэг нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг юм. Тус зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулахдаа авлигын гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, өршөөл үзүүлэхгүй байх гэх мэт хэд хэдэн асуудлыг хөнджээ.

Тухайн үеийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “...Манай улс авлигатай тэмцэх эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн ч Авлигын индексийн үзүүлэлт 2016 оноос тогтмол, огцом буурч байгаа нь авлигатай тэмцэх тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулж байна. Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2017 онд 658, 2018 онд 858, 2019 онд 894, 2020 онд 1020, 2021 онд 1144, шалгасан эрүүгийн хэрэг 2017 онд 427, 2018 онд 1138, 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 2017 онд 44, 2018 онд 84, 2019 онд 68, 2020 онд 114, 2021 онд 160 байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг өсөж байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь адил хэмжээний ял хариуцлага оногдуулахаар заасан байгааг ялгамжтай байхаар өөрчлөх, энэ бүлгийн зарим төрлийн гэмт хэргийн шинжийг тодорхой болгох, зарим гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, Хахууль авах, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектийг зөвхөн нийтийн албан тушаалтнаар хязгаарлахгүй нийтийн албан

тушаалтнаас бусад этгээд хамаарахаар өргөжүүлэх, оногдуулах ялын бодлогыг чангатгах зэрэг өөрчлөлтийг хийж авлигатай тэмцэх төрийн бодлогыг чангатгах шаардлагатай байна...”⁴ гэж үзжээ. Ийнхүү 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

Судалгааны энэ хэсэгт дээрх хууль тогтоомж, хөтөлбөр арга хэмжээнээс Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-ийг судлан үзнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Авлигатай тэмцэх байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хэргийн тусгасан. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/,
- Эрүүгийн хуулийн 22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/,
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хахууль авах/,
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/,
- Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/,
- Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/,
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/,
- Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/,
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/,
- Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/,
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/,
- Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйл /Хахууль авах/,
- Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар хуульчилжээ.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-т Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байна.

Авлигатай тэмцэх газрын сүүлийн дөрвөн жилийн тайлангаас үзвэл:

Хүснэгт 4. Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт⁵

№	Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	487	594	684	870

⁴ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2022 он.

⁵ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номын тоон мэдээнээс, /2020, 2021, 2022 он/

2	Харьяаллын дагуу шилжүүлсэн	27	44	52	44
3	Эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	462	460	621	701
4	Ажиллагаанд	44	46	56	55
Нийт шалгасан гомдол, мэдээлэл		1020	1144	1413	1670

Хүснэгт 5. Шалгасан хэрэг

Он	Хэргийн тоо	Өссөн, буурсан хувь	Холбогдогчийн тоо	Өссөн, буурсан
2020	1331	-	696	-
2021	1307	-1.8	909	+30.6
2022	1520	+16.2	1184	+30.2
2023	1837	+21.0	1402	+18.4

Дээрх 2 хүснэгтээс харвал, авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийн тоо жил ирэх тусам өсөж байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг зүйл, ангиар задлан үзвэл:

Хүснэгт 6. Шалгасан хэрэг /төрлөөр/⁶

№	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Он			
		2020	2021	2022	2023 ⁷
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	799	820	1011	1011
2	22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах	-	-	-	-
3	22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах	-	-	-	-
4	22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	108	134	138	138
5	22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах	-	-	-	-
6	22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх	1	-	-	-
7	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	23	20	22	22
8	22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	-	-	-	-
9	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	41	36	52	52
10	22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах	3	-	-	-
11	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	21	26	34	-
12	22.13 дугаар зүйл. Хахууль авах	207	225	239	239
13	Бусад	50	225	258	258
Нийт		1331	1543	1806	1806

Дээрх хүснэгтээс үзвэл, Авлигын гэмт хэргүүдээс Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн байна.

⁶ Мөн тэнд.

⁷ Авлигатай тэмцэх газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 28 дахь тал.



Хүснэгт 7. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Өмнөх онтой харьцуулахад өссөн, буурсан хувь
2020	114	-
2021	160	+40.3
2022	188	+17.5
2023	192	+2.1

Дээрхээс хүснэгтээс үзвэл, Авлигатай тэмцэх газраас тухайн жилд мөрдөн шалгасан нийт хэргийн 10 орчим хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж байна.

2022 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Энэ хуульд заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй. Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй...” гэж нэмэлт оруулсан. Мөн тус хуулийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй...” гэж заасан нь төрөөс авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан ялыг бүрэн бодитой эдлүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 12 төрлийн авлигын хэргийг бүхэлд нь судлан үзэхэд цаг хугацаа, хөрөнгө санхүү ихээхэн орох учир энэхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн талаар дэлгэрүүлэн судалсан болно.

3.1.2. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22.10 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг зорилгодоо хүрсэн эсэх?, /Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дэлгэрүүлэн судална./

Үнэлгээ:

Монгол улс 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, 2005 онд НҮБ-ийн Авлигын эсрэг конвенцийг нэгдэн орж, 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2007 онд Авлигатай тэмцэх газрыг байгуулсан.

ЭХХШТХ-ийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт АТГ-ын харьяалан шалгах хэргийг тусгайлан хуульчилсан бөгөөд үүнд Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт хамаарч байна. Манай улс анх 2002 оны Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлд “Хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэргийг 2012 онд тусгасан бөгөөд 2015 шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болгон хуульчилжээ.

Тус зүйлд 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт, өөрчлөлтийг харьцуулан үзвэл:

Хүснэгт 8. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалт

Зүйл, заалт	2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт	2022 оны нэмэлт, өөрчлөлт
22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.
22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа “Үндэслэлгүй хөрөнгөжих” гэмт хэргийн ялыг бодлогыг чангатгасан байна.


2022 онд Прокурорын байгууллагаас Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын нийт 1684 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” 75 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулжээ. Үүнээс 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 3 хэрэг шүүхэд шилжүүлж, 6 хэргийг нэгтгэн, 17 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн бөгөөд тухайн жилд шинээр 28 хэрэг үүсгэсэн байна.

2023 онд Прокурорын байгууллагаас Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын нийт 1687 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” 84 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулжээ. Үүнээс 26 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, 69 хэрэгт хэрэг бүртгэлт явуулжээ. Дээрхээс тоон мэдээнээс үзвэл, 2023 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн тоо 2022 оноос 11-ээр өссөн үзүүлэлттэй байна.

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүй хөрөнгөжих” гэмт хэрэг 2020 онд 41 хэрэгт, 2021 онд 36, 2022 онд 52, 2023 онд 52 хэрэг, 2024 оны эхний хагас жилд 54 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.⁸

График 1. АТГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан “Үндэслэлгүй хөрөнгөжих” гэмт хэрэг



Манай улс 2012 онд “Хууль бусаар хөрөнгөжих” үйлдлийг Эрүүгийн хуульдаа гэмт хэрэг болгон тусгаснаар албан тушаалтны хууль бус орлогын цаана буй үйлдэл, эс үйлдэхүйг нотолж чадахгүйгээс албан тушаалаа урвуулан ашиг орлого олох гэмт явдалд эрүүгийн хариуцлага тооцох боломжгүй байсан нөхцөл байдал өөрчлөгдөж, Авлигын гэмт хэргийн хамгийн далд, нууц хэлбэрүүдтэй хийх тэмцэлд мэдэгдэхүйц ахиц гэж үзэж байсан боловч УДШ-ийн Практик судлалын хэлтэс, Судалгааны хүрээлэнгээс хийсэн удаа дараагийн харьцангуй цөөн тооны хэргийг 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлд зааснаар зүйлчлэгдэж мөрдөн

⁸ АТГ-ын 2020, 2021, 2022, 2023, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаас.

шалгах ажиллагаа явагдсан байх бөгөөд шүүхээр ял шийтгүүлсэн хэрэг цөөн байгаа нь хүлээсэн үр дүнгийн хувьд чамлалттай хэвээр байна⁹ гэж үзжээ.

Нөгөөтээгүүр, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн шинжийг зөв тодорхойлж нотлох ажиллагааг энэ гэмт хэргийн өөрийн онцлогт тулгуурлан явуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт энэ төрлийн гэмт хэргийн хувьд хангагдах урьдач нөхцөл болно.

Shuukh.mn-д 2024 оны 09 дүгээр дугаар сарын 17-ны өдрийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” 13 хэрэг шийдвэрлэсэн байна. Үүнээс:

Хүснэгт 9. Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал

№	Зүйл, заалт	Шийдвэрлэсэн хэргийн тоо
1	Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	12
2	Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	1
Нийт		13

Тохиолдол 1.¹⁰

Хэргийн товч утга: “Ш.Н” нь Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокуророор ажиллаж байхдаа байгууллагын жолооч “Э.С”-ээр дамжуулан 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр Зайсангийн гүүр орчмоос 50,000,000 төгрөгийг, 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Блю Скай /Blue Sky/ төвийн орчмоос 49,000,000 төгрөгийг тус тус бусдаас авсан, 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Блю Скай /Blue Sky/ төвийн орчим –“Э.С”-д 50,000,000 төгрөг өгсөн, 2021 оны 6 дугаар сард Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, 8/8 дугаар байрны 37 тоот гэрээсээ 50,000,000 төгрөгийг “Э.С”-ээр авхуулж, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Найман шарга” валют арилжааны төвд ам.доллараар солиулж авсан зэргээр өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр буюу 199,000,000 төгрөгөөр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэх хэрэгт холбогджээ.

ЧД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүгдэгч “Ш.Н”-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Ш.Н-ийн нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилийн хугацаагаар хасаж, арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу арван дөрвөн сая төгрөгийн торгуулийн ял оногдуулах прокурорын саналыг шүүгдэгч хүлээн зөвшөөрсөн, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд хуульд заасан журам зөрчигдөөгүй гэж үзэн торгох ял оногдуулж шийдвэрлэжээ.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиас өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 270¹ дугаар зүйлд заасан хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс заримыг нь дурдвал:

⁹ Авлига болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж практик /гарын авлага/, УДШ, УБ., 2022 он, 154 дэх тал.

¹⁰ ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 2021/ШЦТ/516 дугаартай шийтгэх тогтоол.

Тохиолдол 2:

Хэргийн товч утга: “Р.Э” нь 2012 оноос 2015 оны хооронд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн нарийн бичгийн дарга, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга буюу нийтийн албан тушаалтнаар тус тус ажиллах үедээ 1,141,800,000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, “Ривер гарден” хотхоны 302 дугаар байрны 6 давхрын 602 тоот, 344.8 м.кв талбайтай орон сууц, 2 ширхэг автомашины зогсоолын хамт худалдан авч, хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэн боловч уг хөрөнгө хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэх гэмт хэрэгт, “Ж.Г” нь найз “Р.Э”-г үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг үйлдэхэд учрах саадыг арилган дэмжлэг үзүүлж хамтран оролцсон гэх гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ХУД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс¹¹ “Р.Э”-д холбогдох хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэсэн байна.

“Р.Э”-д холбогдох “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг цагаатгаж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор “Ж.Г”-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн байна. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх¹², Улсын дээд шүүхээс¹³ тус хэргийг хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шалгах, улмаар шүүх дээр албан тушаалтны гэм бурууг нотлоход энэ гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүний элементүүдийг хууль сахиулагч, прокурор, шүүгч нарийвчлан мэддэг, бусад төстэй гэмт хэрэг эсхүл зөрчлүүдээс ялгах нь нэн чухал.¹⁴

Манай улсын хувьд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан боловч тус хэргийн илрүүлэлт, шүүхээр шийдвэрлэгдэж буй байдал хангалттай түвшинд хүрээгүй байна.


Түүнчлэн, хууль хоорондын уялдаа холбоог хангах нь нэн чухал юм. Ялангуяа Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн хувьд практикт үйлдэгдэж буй тоо шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоотой харьцуулахад маш бага байх магадлалтай. Учир нь авлигын гэмт хэрэг нь нуугдмал гэмт хэрэг төдийгүй, тухайн хэргийн илрүүлэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэнийг нотлох, олж тогтоох ажиллагаа нарийн ээдрээ төвөгтэй байдаг. Иймд зөвхөн Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийн ялын бодлогыг

¹¹ ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 13-ны өдрийн 377 дугаар цагаатгах тогтоол.

¹² Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1011 дугаар магадлал.

¹³ Улсын дээд шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 121 дугаар тогтоол.

¹⁴ Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик /гарын авлага/, 2022 он, УДШ, 131 дэх тал.



чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, авлигын зарим гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялыг хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохгүй байх гэх мэт зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар тухайн асуудал шийдэгдэхгүй.

Харин авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй АТГ-ын албан хаагчдыг чадавхжуулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг өөр хоорондын уялдаа холбоог сайжруулах, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг оновчтойгоор тодорхойлох гэх мэт илүү үр дүнтэй аргуудыг хэрэглэх нь зүйтэй.

Нөгөөтээгүүр, манай улсын хувьд хуулийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрт ашигтай хуулийн зохицуулалтыг баримталж, ял завших явдал цөөнгүй байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн тухайд гэхэд Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Нийтийн албан тушаалтны **хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн** нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...” гэж заасан. Энэхүү зохицуулалтын тайлбар хэсэгт “...их хэмжээгээр гэдгийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно...” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, 100.000.000 төгрөгөөс дээш хэмжээгээр нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого нэмэгдсэн бол Эрүүгийн хуульд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох үндэслэл болох юм.

Гэтэл Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд хориглох зүйлийг тусгасан бөгөөд тус зүйлийн 1.8-д “Үндэслэлгүй хөрөнгөжих” гэж заажээ. Энэ зүйлийн тайлбар хэсэгт “...Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ...” гэж тодорхойлжээ.

Энэхүү тодорхойлолт нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэх мөнгөн дүнг Эрүүгийн хууль шиг нарийвчлан тусгаагүй боловч 6 сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэхээр байна. Монгол Улсын хувьд албан тушаалтны дундаж цалин орлогыг 3 сая гэж бодвол 18 сая төгрөгийн хөрөнгө орлогоо хууль ёсны дагуу олсон болохоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол Авлигын эсрэг хуульд зааснаар “Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн” гэж үзнэ.

Энэ нь Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн зохицуулалттай уялдахгүй байна.

Энэ мэтчилэн хууль хоорондын уялдаа холбоогүй байдлаас үүдэн авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завших боломж байсаар байна. Иймд Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалт зорилгодоо хангалттай хүрсэн гэж үзэх боломжгүй байна.

3.1.3. ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Авлигын эсрэг олон улсын бүс нутгийн гурван том конвенц үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцсон нь энэ үйлдлийг эрүүжүүлэх процесст шууд нөлөө үзүүлсэн гэж үздэг.

Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц (IACAC-1996) анх үндэслэлгүй хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг гэж зарласан бөгөөд Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх Африкийн Холбооны конвенц (AUCPCC-2003), Авлигын эсрэг НҮБ-ын конвенц (UNCAC-2003) тус тус үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрсөн.¹⁵

Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцож үндэсний хууль тогтоомждоо өөрчлөлт оруулахыг гишүүн улсуудад үүрэг болгосон бөгөөд бусад хоёр конвенц нь зөвлөмжийн чанартай байна.¹⁶ Гэвч АНУ, Канад улс Авлигын эсрэг Америкийн улсуудын Конвенцийн үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох тухай заалтад тайлбар гаргаж нэгдсэн байдаг.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх Африкийн холбооны конвенцийн үг хэллэгийн томъёолол нь улс орнуудад үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулийг хэрэглэх эсэхийг өөрсдөө шийдэх боломж олгодог бол Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенцод нэгдсэн улс орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох нь Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй зөрчилдөж байна гэж үзвэл гэмт хэргийн зүйл ангийг хууль тогтоомждоо нэвтрүүлэхээс татгалзаж болдог байна. Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц болон Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх Африкийн холбооны конвенц нь гэмт хэргийг харилцан зөвшөөрөх асуудлыг шууд авч үздэггүй ч аль алинд нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нэвтрүүлээгүй оролцогч улсаас тус төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд үзүүлэх тусламжийн талаар бараг ижил заалтууд байдаг.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 20 дугаар зүйлд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг тусгасан бөгөөд тус зохицуулалтыг манай улс Хууль бусаар баяжих буюу “Хууль бусаар баяжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ” гэж орчуулжээ.

Түүнчлэн, дэлхийн улс орон болгон “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэх ойлголтыг харилцан адилгүй тодорхойлдог учир “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэх нэр томъёог олон улсад нэг мөр ойлгон хэрэглэдэггүй. Энэхүү ойлголтыг “хууль бусаар хөрөнгөжих”,

¹⁵ Мөн тэнд, 129 дэх тал.

¹⁶ Мөн тэнд, 130 дахь тал.

“үндэслэлгүйгээр ашиг хонжоо олох”, “шударга бусаар хөрөнгөжих”, “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ”, “тайлбарлагдаагүй өмч” олж авах гэх мэтээр нэрлэн хэрэглэж байна.¹⁷

“Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” үйлдлийн олон улсын нэгдмэл тодорхойлолтыг бий болгохыг зорьсон зорилго нь нэг ижил ухагдахуунтай холбоотой ашиглагдаж байгаа олон төрлийн тодорхойлолт, үг хэллэгийг нэг мөр тодорхой болгох явдал байсан. Тухайлбал, “үндэслэлгүй хөрөнгөжих” (illicit enrichment), “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ” (unexplained wealth), “шударга бусаар хөрөнгөжих” (unjust enrichment) гэсэн нэр томъёонуудыг яг ижил, эсхүл тун төстэй нөхцөл байдлыг тодорхойлоход ижил утгаар хэрэглэсээр байна.¹⁸ Тус нэр томъёоны ойлголтыг нэг мөр тодорхойлон хэрэглэхэд ээдрээ төвөгтэй учир хамгийн оновчтой байдлаар тодорхойлон хуульчлах нь нэн чухал юм.

Ихэнх улс орнуудад гэмт хэргийн хөрөнгийг мэдсэн атал шилжүүлсэн эсхүл үндэслэлгүйгээр олсон хөрөнгийг хүлээн авах нь иргэний эсхүл эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээхээр заагдсан бөгөөд үүнд хамтран оролцох, хуйвалдаан, санаатайгаар үл тоомсорлох, хайхрамжгүй байдал, хуурамчаар түдгэлзэх эсхүл орхигдуулсан залилангийн үйлдэл хамаардаг.¹⁹

Түүнчлэн, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих (нийтийн албан тушаалтан нь тухайн хөрөнгийг хэрхэн олж авсан талаарх үндэслэлтэй тайлбарыг өгч чадахгүй тохиолдолд хууль бусаар олсон гэж үздэг), гадаад улсын нийтийн албан тушаалтны авлигын гэмт хэрэг хэд хэдэн улс оронд хуульчлагдаагүй байдаг. Шууд нэр томъёог нь орчуулбал, харилцан гэмт хэрэгт тооцогдохгүй нөхцөл байдал үүснэ. Энэ нь тухайн улсаас эрх зүйн туслалцааны хүсэлт хүсэх боломжгүй²⁰ байдлыг бий болгож байдаг. Иймд үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдэл нь гэмт хэрэгт тооцогддоггүй тохиолдолд тус үйлдлийг мөнгө угаах гэх мэт бусад гэмт хэрэгтэй холбон тайлбарлах шаардлагатай.²¹

Нөгөөтээгүүр, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа гэмт хэрэг нь хүсэлт хүлээн авагч улсад өөр өөр нэршилтэй гэмт хэрэгт тооцдог байх боломжтой. Тухайлбал, нэг улсад үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хамаарч байгаа үйлдлийг нөгөө улсад хахууль авах гэмт хэрэгт тооцдог байх боломжтой. Гадаад улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч улс оронд тухай улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэрэг нэр томъёотойгоор хэрэглэдэг байх боломжтой. Тиймээс ч үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэргийг яллах нь зарим улсын хууль эрх зүйн зохицуулалтын давхар гэмт хэргийн шаардлагыг хангахад хүндрэл учруулж болзошгүй.

Эдүгээ дэлхийн 98 улсад Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжтой улс орнууд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хууль, Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Иргэний хууль, Шалгуур тогтоосон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хууль, Шалгуур тогтоосон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Иргэний хууль болон


¹⁷ Б.Мөнгөнсүвд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, 2024 он, 5 дахь тал.

¹⁸ Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он, 16 дахь тал.

¹⁹ Жан-Пьер Бран, Анастасия Сотирополу нар, Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага /Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл/, АТГ, УЕПГ, Дэлхийн банк, 2020 он, 65 дахь тал.

²⁰ Мөн тэнд, 254 дэх тал.

²¹ Мөн тэнд, 51-52 дахь тал.



Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Захиргааны хуулийг хэрэглэж байна. Үүнээс Ази-Номхон далайн бүс нутагт 36, Африк тивд 25, Америк тивд 25, Европ тивд 2 байна.

Энэ хууль нь эх газрын болон Ром-Германы эрх зүйн бүлд харьяалагдах улсуудын аль алинд нь тархсан байх бөгөөд 47 нь Ром-Германы эрх зүйн бүл давамгайлсан улсад харьяалагдаж байгаа бол, 35 нь эх газрын бүл давамгайлсан улсад, 18 нь холимог тогтолцоотой байна. Эдгээр хууль тогтоомжийн ихэнх нь эрүүгийн эрх зүйд харьяалагдаж байгаа нь дэлхийн улс орнууд үндэслэлгүй хөрөнгөжилтийг гэмт хэрэг гэж үзэж байгааг харуулж байна. Тодруулбал, тус 98 хуулийн 78 хууль нь эрүүгийн эсхүл шалгуур тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжих Эрүүгийн хуулийн ангилалд, 18 нь иргэний эсхүл шалгуур тогтоосон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Иргэний хуулийн ангилалд багтаж байна. Үлдсэн 2 нь захиргааны эрх зүйн ангилалд хамаарч байна.²² Манай улсын хувьд энэхүү ангиллын үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хуультай улсад хамаарч байна.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг Франц, АНУ, Сингапур, Ирланд, Хонконгод хэрхэн хуульчилсан талаар судлан үзвэл:

ФРАНЦ УЛС

Франц улсын Эрүүгийн хуулийн 321-326 дугаар зүйлд дараах нөхцөл байдал тогтоогдсон бол тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж тооцно гэжээ. Үүнд:

- Хорих ялын доод хэмжээ 5 жил түүнээс дээш хорих ялтай гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нэг буюу түүнээс дээш этгээдтэй байнгын харилцаа холбоотой байдаг;
- Өөрийн амьжиргааны түвшин эсхүл эзэмшиж байгаа эд хөрөнгө худалдан авахад ашигласан эх үүсвэрээ үндэслэлтэйгээр тайлбарлаж, нотолж чадахгүй байгаа.

Өөрөөр хэлбэл, хэрэв сэжигтэн нь хөрөнгийн эх үүсвэрээ зөвтгөн тайлбарлаж чадахгүй байгаа эсхүл хууль ёсны орлогынхоо хүрээнд хөрөнгөө зөвтгөн тайлбарлаж чадахгүй байгаа бөгөөд ял шийтгэл авсан этгээдтэй тогтмол харилцаа холбоотой болохыг төр нотолбол түүнд ял шийтгэл оногдуулахаар хуульчилжээ.²³

Энэ утгаараа прокурор нь хэрэгт холбогдож байгаа хөрөнгө чинээ нь салангид гэмт хэрэг эсхүл яллагдагч тухайн гэмт хэргийг үйлдсэн гэж нотлох шаардлагагүй байдгаараа үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай тун төстэй байна.

Түүнчлэн, хариуцагч нь өөрийн хөрөнгийн гарал үүсэл эсхүл хөрөнгөө хууль ёсны орлогын эх үүсвэрийн хүрээнд зөвтгөн тайлбарлаж чадаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг. Эдгээр ижил төстэй шинж байгаа ч үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулиас ялгагдах шинж нь прокурор тухайн гэмт хэргийг өөр этгээд үйлдсэн болон 321-326 дугаар зүйлээр шийтгэгдсэн этгээд тус яллагдагчтай байнгын харилцаа холбоотойг нотлох шаардлага тавигддаг асуудал юм. Түүний улмаас эд хөрөнгийг хууль бус эх үүсвэртэй гэж үзэх таамаг нь яллагдагч нь эд хөрөнгийн эх үүсвэрээ зөвтгөн тайлбарлаж чадаагүй дээр зөвхөн үндэслэхгүй бөгөөд тухайн этгээд энэхүү гэмт хэргийг үйлдэл шийтгүүлсэн этгээдтэй харилцаа холбоотой гэсэн факт дээр мөн үндэслэдэг байна.²⁴

²² Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он, 45 дахь тал.

²³ Мөн тэнд, 90 дэх тал.

²⁴ Мөн тэнд, 87 дахь тал.



Ял шийтгэл оногдуулах процесс хуулийн 321-6 дугаар зүйлд хэн нэгэн хүн “нэг буюу хэд хэдэн хүн өөрийн амьдралын хэв маягтай нийцүүлэн орлого, эсхүл хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарлаж чадаагүй бөгөөд энэ хэргийн улмаас, эсхүл хохирогчоос шууд болон шууд бусаар ашиг олсон тохиолдолд хүнд, эсхүл хүндэвтэр гэмт хэргийг байнга үйлдсэн гэж үзэж 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан. Энэ гэмт хэрэгт гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх ба шийтгүүлсэн хүний хөрөнгийг бүхэлд нь хураах боломжтой. Хөрөнгө хураах процесс хуулийн 131-21 дүгээр зүйлд шүүгдэгч хөрөнгийнхөө хууль ёсны эх үүсвэрийг баталж чадаагүй бол түүний хөрөнгийг бүхэлд нь хурааж болох талаар заасан. Энэ гэмт хэргийн улмаас шууд болон шууд бусаар ашиг олсон бол хамгийн багадаа таван жилийн хорих ял шийтгэгдэх ёстой.

Францын Эрүүгийн хуульд тухайн гэмт хэрэгт хариуцлага оногдуулахдаа зөвхөн тэр хөрөнгийг хууль бусаар олж авсан этгээдэд төдийгүй, түүнийг олж авахад тусалсан, хамжсан, энэ үйлдлийг нь хамгаалсан этгээдэд мөн хариуцлага хүлээлгэдэг. Гэхдээ өөрийн амьдралын амьжиргааны түвшин нь олж буй орлоготой харьцуулахад жирийн, тохирсон хэмжээнд байвал тэр хүний данс тооцоог шалгах боломжгүй гэж заасан²⁵ байдаг.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-ын Эрүүгийн хууль тогтоомж нь жишгийн эрх зүйн тогтолцоотой улсын хувьд гол төлөв шүүгчийн урьд гаргасан шийдвэрийн үндсэн дээр бүрэлддэг жишгийн хууль, мөн зарим талаар хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан хуулиуд зэрэг олон тооны эрх зүйн хэм хэмжээнээс бүрдсэн байдаг.²⁶ Бараг муж улс бүр нь Эрүүгийн төрөлжсөн хуультай боловч эдгээр нь нийтлэг байдлаар жишгийн хуульд үндэслэж, түүнээс иш татсан байдаг.


АНУ-д хууль бусаар хөрөнгөжих/үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг тусдаа бие даасан гэмт хэрэг гэж тооцоход хүндрэлтэй байдаг. Учир нь үндэслэлгүй хөрөнгөжихийг бие даасан гэмт хэрэг гэж үзэх нь эрүүгийн эрх зүйн зарим зарчмуудтай зөрчилддөг. Тиймээс ч АНУ, Канад улс Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенцод үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох тухай заалтад тайлбар гаргаж нэгдсэн байдаг бөгөөд тус улсын Үндсэн хуулиар баталгаажсан “шүүгдэгч гэм буруутай эсэхээ нотлох үүрэггүй”, “гэм буруу нь шүүхээр тогтоогдох хүртэл хэн ч гэм буруугүй”, “шүүгдэгчийн гэм бурууг төр нотлох” зарчмуудад харш гэж тайлбарласнаас үзвэл нотлох ажиллагааны зарим хэсгийг шүүгдэгчид шилжүүлэх байдлаар хялбаршуулан тогтоосон энэ процедурыг шилжилтийн үеийн эдийн засгийн сөрөг нөлөөтэй тэмцэх цаг хугацааны шалгууртай түр арга хэмжээ бөгөөд эрүүгийн эрх зүйн суурь үзэл баримтлалд цаашид оршин байх боломжгүй гэж үздэг бололтой.²⁷

АНУ энэхүү тайлбартаа үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нэвтрүүлэх нь АНУ-ын Үндсэн хууль болон эрх зүйн үндсэн зарчмуудтай (хариуцагчид шилжих нотлох үүргээс болж) зөрчилдөх тул тус гэмт хэргийг дотоодын хуульдаа тусгах шаардлагагүй гэж ойлгож байна гэсэн байдаг. Нөгөө талаас, АНУ дотоодын хууль тогтоомжоор олгогдсон

²⁵ Ж.Батмөнх, Хууль бусаар баяжих гэмт хэргийг Монгол улсын Эрүүгийн хуульд хуульчлах шаардлага, 2011 он, 7 дахь тал.

²⁶ Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик /гарын авлага/, УДШ, УБ., 2022 он, 26 дахь тал.

²⁷ Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, 2019 он, 11 дэх тал.



бүхий л боломжийг ашиглан үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг шалгаж буй бусад оролцогч орнуудад туслалцаа үзүүлж, хамтран ажиллана гэдгээ тодорхой илэрхийлжээ.²⁸

Түүнчлэн, АНУ нь олон улсын гэрээ хэлцэлд тусгагдсан үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай зүйл, заалтын хэрэгжилтийг түдгэлзүүлэх шийдвэрийг хэд хэдэн удаа гаргаад байгаа ч тухайн этгээдийн хууль ёсны хөрөнгө орлоготой нийцэхгүй байгаа хөрөнгийг татвараас зайлсхийсэн гэж ялласаар ирсэн байдаг. Тухайлбал, HOLLAND V UNITED STATES хэрэгт прокурор буруутгагдаж буй этгээдийн хөрөнгө чинээ нь гурван жилийн хугацаанд түүний мэдүүлсэн хууль ёсны орлоготой илт нийцэхгүйгээр нэмэгдсэн болохыг нотолсноор түүнийг АНУ-ын Орлогын албан татварын тухай хууль (US internal revenue code)-ийн дагуу татвараас зайлсхийх зүйл ангиар яллаж, ял оногдуулсан. Гэхдээ энэ төрлийн хэрэгт “хүсэл зориг/сэдэл”-ийг “бие даасан/тусдаа нотлох баримт”-аар нотлох шаардлагатай бөгөөд “хөрөнгө орлогоо бууруулан мэдүүлсэн” гэх асуудал дээр үндэслэн дүгнэх боломжгүй байдаг нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулиас ялгагдаж байгаа юм.²⁹

СИНГАПУР УЛС

Авлигын эсрэг амжилттай тэмцсэн улсад Сингапур, Хонконг зүй ёсоор нэрлэгддэг. Тус улсуудад авлигын эсрэг үйл ажиллагаанд тухайн улсын авлигатай тэмцэх байгууллага голлох үүрэгтэйгээр оролцож, маш богино хугацаанд эерэг үр дүнд хүрсэн байдаг.

Тухайлбал, 2018 онд Сингапур Авлига, мансууруулах бодис наймаалах, бусад онц ноцтой гэмт хэргийн (ашиг хонжоог хураан авах) тухай хуульдаа 47AA зүйлийг нэмж оруулсан нь зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн мөнгө хөрөнгийг зөөгч (money mule) нарыг уг хуульд хамруулах зорилготой байсан юм. Энэхүү заалтаар “мансууруулах бодис наймаалах эсхүл бусад гэмт явдлын ашиг хонжоо гэж сэжиглэгдэж байгаа эд хөрөнгийг шууд эсхүл шууд бусаар эзэмшиж эсхүл ашиглаж байгаа төлөөний этгээд” нь тухайн эд хөрөнгийг хэрхэн олж авснаа үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй бол гэм буруутайд тооцох зохицуулалтыг бий болгосон юм.

Сингапур нь Үндэслэлгүй хөрөнгөжилт /Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага/-д тодорхойлсон “Шалгуур үзүүлэлт тогтоосон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуультай” улсын жагсаалтад хамаарч байна.

ИРЛАНД УЛС

Ирландын 1996 оны Гэмт хэргийн гаралтай орлогын тухай хууль нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай тун төстэй бөгөөд хөрөнгө хураан авахтай холбоотой зохицуулалтуудыг агуулсан байдаг.

Тус хууль нь иргэний эрх зүйн процесст тулгуурлах бөгөөд “хэрэв хариуцагч нь шууд эсхүл шууд бусаар гэмт хэргийн гаралтай орлогыг бүрдүүлж байгаа” эсхүл “хэсэгчлэн эсхүл бүхэлдээ шууд эсхүл шууд бусаар гэмт хэргийн гаралтай орлогыг ашиглаж эсхүл үүнтэй холбогдож байгаа хөрөнгө ашиглаж худалдаж авсан эд хөрөнгийг эзэмшиж эсхүл хяналтдаа байлгаж байгаа” бол тус хөрөнгийг хураан авах боломжтой гэж тодорхойлжээ. Үүнийг тогтоохдоо хууль сахиулах байгууллагын алба хаагчаас бүрдүүлсэн нотлох баримтад

²⁸ Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он, 175-176 дахь тал.

²⁹ Мөн тэнд, 89 дэх тал.



үндэслэсэн “итгэл үнэмшил”-д тулгуурладаг байна. Үүнээс гадна, энэхүү хууль нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай адилаар нотолгооны үүргийг хариуцагчид шилжүүлэх заалт агуулдаг. Хэрэв хариуцагч нь “тухайн өмч нь шууд эсхүл шууд бусаар гэмт хэргийн гаралтай орлогоос үүсээгүй” болохыг үндэслэлтэйгээр нотолж чадахгүй бол шүүх нь хөрөнгө хураах шийдвэр гаргадаг байна.³⁰

Мөн энэхүү хуульд шүүх нь хариуцагчид холбогдох эд хөрөнгийн жагсаалт болон эдгээрийг эзэмших, худалдан авахтай холбоотой ашигласан орлогын эх үүсвэрээ тодорхойлох мэдүүлэг шүүхэд гаргаж өгөх захирамж гаргаж болох заалт байдаг.³¹

Ирландын Эрүүгийн (Авлигын гэмт хэрэг) хуулийн 16 дугаар зүйл үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай төстэй шинжийг агуулж байна. Тус зүйлийн дагуу, хэрэв тусдаа хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр төрийн албан хаагч нь “бүртгүүлэх ашиг сонирхлын мэдүүлэг”-тээ тусгаагүй хөрөнгө эзэмшиж байгаа нь мэдэгдвэл түүний эх үүсвэрийг “авлигажсан хөрөнгөжилт гэж үзэх таамаг” дэвшүүлэх боломж бүрддэг байна. Энэ тохиолдолд энэхүү таамгийг үндэслэлтэй няцааж чадаагүй бол тухайн хөрөнгө нь “албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосныг урамшуулж, шагнаж, эсхүл хүлээн зөвшөөрсний үндсэн дээр олж авсан бэлэг, шагнал, давуу байдлаас шууд эсхүл шууд бусаар олж авсан эд хөрөнгө” гэж дүгнэдэг байна. Гэхдээ энэ заалтыг хэрэглэхийн тулд авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх тусдаа ажиллагаа явагдсан байх шаардлагатай тул тус бүтээлд мөн л үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжуудын жагсаалтад оруулаагүй болно.³²

ХОНКОНГ³³

1950-аад оны эхээр, Хонконг албан ёсны цалин хөлс нь эзэмшиж байгаа хөрөнгө эсхүл амьдралын хэв маягтай нь нийцэхгүй байгаагаа үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа төрийн албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалтыг нэвтрүүлжээ. Энэ нь Хонконгийн 1971 онд хүчин төгөлдөр болсон Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулийн эхлэл болсон.³⁴ Авлигын түвшнээр Азид тэргүүлдэг байсан ХонКонг үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцсоноос хойш авлигагүй орнуудыг нэг болсон гэж зарим судлаачид үздэг.

Хонконгийн Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” –ийг тодорхойлохдоо:

Тайлбарлагдаагүй өмч эзэмших гүйцэтгэх захирлын эсхүл төрийн албан тушаалд ажиллаж байсан/ байгаа хувь хүн нь:

- (а) Одоо хашиж байгаа эсхүл өмнө нь хашиж байсан албан тушаалын цалин хөлстэй үл нийцэх амьжиргааны түвшинтэй;
- (b) Одоогийн эсхүл өмнөх албан ёсны цалин хөлстэй нийцээгүй мөнгөн хөрөнгө өмчийг хянаж байгаа бол;


³⁰ Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он, 84 дэх тал

³¹ Мөн тэнд.

³² Мөн тэнд, 85 дахь тал.

³³ Б.Мөнгөнсүвд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, 2024 он, 17 дахь тал.

³⁴ Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он, 22 дахь тал.



Уг амьжиргааны түвшинг хэрхэн хангаж байгаа, санхүүгийн эх үүсвэр эсхүл өмчийг хэрхэн эзэмших болсон тухай хангалттай тайлбарыг шүүхэд гаргаж чадахгүй бол түүнийг тус зохицуулалтаар гэм буруутайд тооцно.

Тухайн зохицуулалтаар гэм буруутайд тооцогдсон тохиолдол нэг сая Хонконг доллартой тэнцэх хэмжээгээр торгож, 10 жилийн хугацаагаар хорих; харин Тангарагтны шүүх эсхүл энгийн шүүхээр шийдвэрлэх шаардлагагүй хөнгөн хэргийн хувьд 10 дугаар зүйлд зааснаар 500.000 Хонконг доллартой тэнцэх хэмжээгээр торгож, 3 жилийн хугацаагаар хорих ял оногдуулна. 1 дүгээр дэд хэсэгт заасан ял шийтгэлээс гадна шүүхээс 10 дугаар зүйлийн 1(b)-д заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дараах дүнгээр Засгийн газарт торгууль төлөх үүрэг хүлээлгэж болно. Үүнд: Санхүүгийн эх үүсвэрээс нь хэтрэхгүй хэмжээтэй тэнцүү дүнгээр; эсхүл шүүхэд хангалттай тайлбарлаж чадаагүй өмчийн үнийн дүнгээс хэтрээгүй дүнгээр.

Хонконгийн Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт зааснаар хариуцагч өөрийн өнгөрсөн эсхүл одоогийн албан ёсны цалин хөлсөнд үл нийцэх амьжиргааны түвшин эсхүл эд хөрөнгө эзэмшиж, өмчлөх болсноо үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй бол түүнийг гэм буруутайд тооцдог байна.

Дээрхээс дүгнэвэл, Авлигын эсрэг олон улсын бүс нутгийн гурван том конвенц үндэслэлгүй хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцсон нь энэ үйлдлийг эрүүжүүлэх процесст шууд нөлөө үзүүлсэн. Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц (1996) анх үндэслэлгүй хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг гэж зарласан бөгөөд Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх Африкийн холбооны конвенц (2003), Авлигын эсрэг НҮБ-ын конвенц (2003) тус тус үндэслэлгүй хөрөнгөжих нь гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрсөн.

Энэхүү 3 конвенцоос Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц нь үндэслэлгүй хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцож үндэсний хууль тогтоомждоо өөрчлөлт оруулахыг гишүүн улсуудад үүрэг болгосон байхад бусад хоёр конвенцод зөвлөмжийн чанартай тусгагджээ.³⁵

Дээрхээс дүгнэвэл, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэх нэр томъёог улс орон бүр харилцан адилгүй байдлаар томъёолон хэрэглэж байна. Түүнчлэн, үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой харилцааг иргэн, эрүү, захиргааны журмаар өөр өөрөөр харьяалуулан шийдвэрлэж байгаа улс орнууд ч цөөнгүй байна. Харин улс хоорондын эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудалд нь тухайн улсад үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хуульчилсан эсэхээс хамаарч тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам өөр өөр байна. Учир нь улс орнууд нэг нэгэндээ эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нөхцөл нь давхар гэмт хэрэгт тооцох зарчим буюу хүсэлт гаргагч улсад мөрдөж буй гэмт хэрэг нь нөгөө улсад мөн гэмт хэрэгт тооцогдох асуудал байдаг. Нөгөөтээгүүр, үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэргийг шалгах олон улсын хамтын ажиллагаанд саад тотгор учруулдаг зүйл бол үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцдоггүй улс орнууд энэхүү зарчмыг баримталдаг явдалтай холбоотой байна.

³⁵ Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, 2019 он, 11 дэх тал.

3.1.4. ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх? Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал.

Үнэлгээ:

Эрх зүйн шинжлэх ухаанд хөөн хэлэлцэх хугацааны ойлголт Ромын эрх зүйн үеэс үүсэн бий болж хөгжиж байгаа боловч эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь иргэний эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны ойлголтоос хожуу бий болсон. Орчин үед эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалт нь эх газрын бүлийн улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг. Харин жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь маш хязгаарлагдмал байдаг бөгөөд хуулийн дагуу зөвхөн хүнд гэж тооцогддоггүй хэргүүдэд хэрэглэх боломжтой байдаг.³⁶

Эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн явцад Эрүүгийн хуульд тусгагдсан хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь харьцангуй тогтсон ойлголт юм. Хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа үндэслэлийн нэг болно. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэдэг нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд хуульд заасан үндэслэлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхыг ойлгодог. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа үндэслэл нь сонгох болон заавал чөлөөлөх гэсэн хоёр төрөлтэй бөгөөд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөх үндэслэл нь шүүхээс үл хамааран бий болдог. Улс орнуудын Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөхөөр заасан байна.³⁷

Улс орнууд эрүүгийн хуульдаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхлэх, түдгэлзэх, үргэлжлүүлэн тоолох, зогсох буюу тасрах, дуусгавар болох болон ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулж байна.³⁸ Мөн авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зориулалтаар зохицуулагдан хэрэгждэг.

Манай улсын хувьд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялын хэмжээнээс хамааруулан тоолохоор хуульчилсан. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсний дараагаар практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй байсан зохицуулалтуудын нэг нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт байсан. Учир нь:

1. Торгох ялтай буюу хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн яаж тоолох нь хуульчлагдаагүй орхигдсон;

2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилдөн эрх зүйн хийдлийг бий болгосон;

³⁶ Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он, 3-4 дэх тал.

³⁷ Мөн тэнд, 4 дэх тал.

³⁸ Мөн тэнд.

3. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллыг үл харгалзан тогтоосон нь зарим хийдэл, зөрчил, ойлгомжгүй байдлыг үүсгэсэн, гэмт хэргийн ангиллыг ач холбогдолгүй болгосон;

4. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тухайн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолох уу, эсхүл анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох уу гэдэг нь эргэлзээтэй;

5. Зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? Түдгэлзүүлсэн ял дээр хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь зөв эсэх асуудлууд үүсээд байсан билээ.

Иймд тус эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулсан. Гэвч энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр тус зохицуулалтын эрх зүйн хийдлийг бүрэн арилгаж чадаагүй гэж үзэж болохоор байгаа юм.

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас /хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд/ нь хамааруулан тоолдог байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн ялын доод болон ялын дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулсан нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нэлээдгүй ахиц дэвшлийг авчирсан нь сайшаалтай хэдий ч зарим гэмт хэргүүд дээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагджээ.

Шинэ батлагдсан Эрүүгийн хуульд 209 төрлийн гэмт хэрэг хуульчлагдсанаас 83³⁹-н гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй, ойлгомжгүй байдлыг үүсгээд байсан. Эрүүгийн хуульд хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн 5 төрлийн ялыг оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял бусад нь үндсэн ял.⁴⁰ Гэтэл хууль тогтоогч хорих болон зорчих эрхийг хязгаарлах гэсэн 2 төрлийн ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчлан өгчээ. Өөрөөр хэлбэл, энэ хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан торгох ялтай гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолохыг зохицуулаагүй байсан юм. Энэ мэтчилэн эргэлзээтэй, хийдэлтэй зохицуулалтын улмаас хүний эрхийг зөрчих нь хуулийн зорилго, ач холбогдлыг алдагдуулж байсан билээ.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан эрх зүйн хийдлийг арилгах, засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн томоохон алхам болсон гэж үзэж болох ч зарим хийдэлтэй зохицуулалт байсаар байна. Өөрөөр хэлбэл, тус зохицуулалттай холбоотой эрх зүйн хийдлийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр бүрэн арилгаж чадаагүй, харин эрх зүйн хийдлийг арилгах эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.

Одоогийн бидний дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтад дор дурдсан асуудлууд үүссэн хэвээр байна. Үүнийг өмнөх зохицуулалттай харьцуулан үзвэл:

³⁹ Дэлгэрэнгүйг хүснэгт 10, 11-ээс үзнэ үү.

⁴⁰ Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг хуульчилсан.

Асуудал 1. 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан /хүснэгт 10-т дурдсан/ хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргүүдийн хувьд ялын хэмжээгээр хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? гэсэн асуудал бий болж байсан.

Учир нь 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээ нь 1 жил, дээд хэмжээ нь 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 5 жил байхаар хуульчилсан боловч дээрх гэмт хэргүүдийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ **6 сараас** эхэлж байсан нь тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалт нь хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ болох 1 жилд хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл, хорих ялын доод хэмжээ нь 1 жил хүрэхгүй байгаа учраас энэхүү заалтаар хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байсан.

Мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаар хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 жил байхаар тогтоосон. Гэтэл зарим гэмт хэргийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сараас эхэлж байгаа ч ялын дээд хэмжээ нь 5 хүртэл жил байгаа нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 эсхүл 5 жилийн аль хугацаагаар тоолох нь эргэлзээтэй байдлыг бий болгож байлаа.

Энэхүү асуудал нь Эрүүгийн хуульд эрх зүйн хийдлийг бий болгож, зайлшгүй засаж сайжруулах шаардлагатай зохицуулалтын нэгд зүй ёсоор тооцогдох болсон. Тиймээс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. /Дэлгэрэнгүйг “Хүснэгт 10”-ийн тайлбар хэсгээс үзнэ үү/

Хүснэгт 10. Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт				Тайлбар
№	Зүйл, заалт	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй гэж нэмж хуульчилсан байна.
1.	10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
2.	11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
3.	11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
4.	11.4 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	3 жил	
5.	11.7 дугаар зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	2 жил	
6.	12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
7.	12.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил	
8.	13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
9.	14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
10.	15.1 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
11.	17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
12.	17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	

13.	17.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	Ийнхүү тус заалт Эрүүгийн хуульд нэмэгдсэнээр 1 эсхүл 5 жилийн алинаар нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь эргэлзээтэй байдал үүсгээд байсан 53 зохицуулалтаас 50 зохицуулалтад нь 3 жилийн хугацаагаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжийг бүрдүүлсэн юм. Энэхүү эрх зүйн хийдэл бүхий 53 хэргээс онцлог 1 хэргийг тусгайлан тайлбарлавал: 2015 оны Эрүүгийн хуульд заасан хорих ялгүй, зорчих эрхийг хязгаарлах ялтай нийт 48 хэрэг байснаас гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй нэг хэрэг байсан нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэрэг юм. Учир нь тус хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ...” гэж заасан. Өөрөөр хэлбэл энэхүү зохицуулалт нь 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 болон 1.2 дахь заалтад аль алинд нь хамаардаггүй байсан. Харин 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “... эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” гэсэн заалт нэмж хуульчилснаар тус зохицуулалтад тоолох хөөн хэлэлцэх хугацаа 3 жил болсон юм.
14.	17.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
15.	18.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
16.	18.4 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил	
17.	18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
18.	18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
19.	18.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
20.	18.16 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил	
21.	19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
22.	19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
23.	19.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
24.	19.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
25.	19.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
26.	19.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
27.	19.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
28.	20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
29.	21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
30.	21.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
31.	21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
32.	22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
33.	22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	6 сар	3 жил	
34.	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
35.	22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
36.	22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
37.	22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
38.	23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
39.	23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
40.	23.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
41.	23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
42.	25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
43.	25.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
44.	25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
45.	25.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
46.	26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
47.	27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
48.	27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт	6 сар	3 жил	
49.	28.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	

50.	13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	3 сар	2 жил	Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 сар байхаар хуульчилж өгсөн байсан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “... 6 сараас 20 жил хүртэл хугацаагаар хорих ялыг эдлүүлнэ” гэж заасантай зөрчилдөж байсныг 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж хорих ялын доод хэмжээг 6 сар болгон ЭХЕА-ийн зохицуулалтад нийцүүлсэн байна.
51.	17.1 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	Энэхүү 3 зохицуулалтын хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 1 эсхүл 5 жилийн аль алинд нь хамаарсан хэвээр байна.
52.	17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	
53.	17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан асуудлыг засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй хэвээр байгаа юм.

Учир нь тус зохицуулалтууд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад заасан “...хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээ найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон...” гэсэн заалтад мөн 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон,” гэж нэмж хуульчилсан заалтад ч хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх 3 зохицуулалт нь одоог хүртэл эрх зүйн хийдэлтэй хэвээр байна.

Асуудал 2. 2015 оны Эрүүгийн хуулийн 6 бүлгийн 30 зүйл, заалтад зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан байна. Гэтэл тус хуульд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчилж өгсөн учир торгох ял⁴¹ оногдуулахаар заасан хэргүүдэд хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь ойлгомжгүй байсан юм.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10 өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд

⁴¹ Зөвхөн торгох ялтай гэмт хэргүүдийн хувьд 10.000-80.000, 20.000-100.000, 20.000-120.000, 40.000-200.000, 120.000-400.000, 200.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох ял оногдуулахаар хуульчилсан байна.

эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно...” гэж нэмж хуульчилснаар зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан хэргүүд буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан заалтуудад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжийг бүрдүүлсэн.

Хүснэгт 11. Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

№	Зүйл, заалт	Торгох ялын хэмжээ	Хөөн хэлэлцэх хугацаа /2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт/	
			Тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар тогтоовол	Хуулийн этгээд хариуцлага хүлээлгэхээр заасан заалтын дээд хэсэгт заасан ижил хугацаагаар тогтоовол
1	18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	1 жил
2	18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	3 жил	5 жил
3	18.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	200.000-400.000 нэгж	1 жил	12 жил
4	18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	100.000-400.000 нэгж	1 жил	12 жил
5	18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	100.000-400.000 нэгж	5 жил	12 жил
6	18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	12 жил
7	18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	12 жил
8	18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	1 жил
9	18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	5 жил
10	20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	20 жил
11	20.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	12 жил
12	20.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
13	20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	200.000-400.000 нэгж	5 жил	5 жил
14	20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	5 жил	5 жил
15	20.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
16	20.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
17	20.14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	20.000-120.000 нэгж	3 жил	5 жил
18	20.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	200.000-400.000 нэгж	3 жил	5 жил
19	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	3 жил	5 жил
20	24.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
21	24.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	5 жил
22	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
23	24.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	120.000-400.000 нэгж	5 жил	5 жил
24	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
25	24.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	5 жил
26	24.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	12 жил	12 жил
27	24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	1 жил	5 жил

28	24.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	12 жил	12 жил
29	25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	5 жил
30	25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	5 жил

Гэсэн хэдий ч тус зохицуулалт нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна. Үүнд:

1. Тус хуулийн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно...” гэж заасан. Гэтэл энэхүү заалтыг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэж болохоор байгаа юм. Тухайлбал, тус хуулийн 22.5 дугаар зүйл гэхэд 3 хэсгээс бүрдэж байна. 22.5 дугаар зүйлийн 1, 2-т заасан зохицуулалтуудад зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар заасан буюу хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Тэгвэл хуулийн этгээд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боловч тухайн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 22.5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг яг аль хэсгээр нь тоолох нь ойлгомжгүй.

Хүснэгт 12. Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл

№	Зүйл, заалт	Хөөн хэлэлцэх хугацаа
1	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
2	22.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил

2. Хэрэв тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дараах асуудал үүсэж болохоор байна:
 - Торгох ялын хэмжээ ижил хэр нь хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8⁴²-н хэргийн хувьд 3 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 3 жил, 1 хэрэгт нь 5 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор байгаа юм.
 - Торгох ялын хэмжээ нь бага хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна.
 - Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм.
 - Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт тоолох гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа богино байх зэрэг асуудлыг үүсгэж болох юм.
3. Хэрэв 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан байвал 18.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолно буюу тухайн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх заалтын дээд талын

⁴² Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт, 20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг.



хэсэгт заасан хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дор дурдсан асуудлууд үүсэхээр байна:

- Торгох ялын хэмжээ ижил хэр нь хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8 хэргийн хувьд 2 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 5 жил, 2 хэрэгт нь 12 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх тоолохоор байгаа юм. Хэрвээ энэ хувилбараар зохицуулбал шударга ёсны зарчим алдагдах юм.
- Торгох ялын хэмжээ нь бага хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 40.000-120.000 нэгжээр торгох ялтай хэр нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 20 жил байгаа бол мөн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 200.000-400.000 нэгжээр торгохоор заасан боловч хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байна.
- Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг.

Асуудал 3. Нэр томьёог нэг мөр болгох.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд "...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа..." гэсэн нэр томьёог хэрэглэжээ. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд тус зохицуулалтыг "...гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа..." гэж хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, дээрх нэр томьёо нь нэг утга санааг илэрхийлж байгаа хэдий ч ялгамжтай байдлаар хуульчлагдсаныг нэг мөр болгох нь зүйтэй.

Асуудал 4.

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо гэмт хэргийн ангиллаас хамааруулан тоолдог байсан. Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих болон хорих ялын дээд, доод хэмжээнээс хамааруулан тоолохоор хуульчилсан билээ. Ийнхүү гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллыг үл харгалзан тогтоосон нь гэмт хэргийн ангиллыг ач холбогдолгүй болгосон гэж зарим талаар дүгнэж болохоор байна. Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлд:

1. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

2. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ" гэж зааснаас үзвэл гэмт хэргийг хөнгөн, хүнд гэсэн 2 ангиллаар ангилжээ. Хэдийгээр энэ хуульд гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилсан боловч гэмт хэргийг

хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хүнд, хөнгөн гэмт хэргийн хувьд адил тоологдохоор хэд хэдэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчлагдсан байна.

Учир нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад “....Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн...” гэж заасан нь хөнгөн, хүнд гэмт хэрэгт аль алинд нь хамаарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, хөнгөн гэмт хэрэг, хүнд гэмт хэрэгт ижил хугацаагаар хөөн хэлэлцэх хугацаа тоолж байгаа нь гэмт хэргийн ангиллыг үгүйсгэсэн байж болохоор байна. Хөнгөн, хүнд гэмт хэргийн ангиллыг үгүйсгэсэн нийт 175 гэмт хэрэг байна.

Хүснэгт 13. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хөнгөн, хүнд гэмт хэрэгт ижил тоолохоор хуульчлагдсан жишээ

Хөнгөн гэмт хэрэг	Хүнд гэмт хэрэг	Тайлбар
10.2 дугаар зүйл.Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах 1.Өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжлогдсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүнийг алсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	10.3 дугаар зүйл.Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүний,г алах 1.Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж; тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Эдгээр гэмт хэргийн хувьд хөнгөн болон хүнд гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацаа ижилхэн байна. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т заасны дагуу “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэсэн байдлаар хөөн хэлэлцэх хугацааг хуульчилж өгсөн нь хөнгөн болон хүнд гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нь адилхан таван жил байх нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.
10.6 дугаар зүйл.Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 2.Энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь насыг хохироосон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	10.4 дүгээр зүйл.Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 1.Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	

Асуудал 5.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан. Гэтэл тус хууль нь Үндсэн хуульд нийцээгүй, хүний эрхийг ноцтой зөрчсөн зэрэг үндэслэлээр Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн шийдвэрлүүлээд байна. Энэ хууль нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудлын хүрээнд Монгол Улсын түүхэнд урьд өмнө нь гарч байгаагүй асуудлыг хөндсөн буюу Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх тэр дундаа эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй гэсэн зарчмын заалтыг үгүйсгэн хуульчлагдсан нь асуудал дагуулаад байсан юм. Хэдийгээр уг хуулийг бүхэлд нь хүчингүй болгох шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргасан.

Түүнчлэн, УДШ-ийн нийт шүүгчдийн 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаас гаргасан Дугаар 11 тогтоолоор Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг гаргасан.

Тус тайлбарт, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйл нь материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээний аль алиныг агуулж байх боловч тус тусын агуулга, зорилгод нийцүүлэн ялгамжтай байдлаар хэрэглэх нь шүүхийн шийдвэр эрх зүйн үндэслэлтэй, хууль ёсны байх шаардлагад нийцнэ. Эрүүгийн эрх зүйн аливаа хэм хэмжээг аль хуульд тусгагдсан байдлаар шалгуур болгож материаллаг эсхүл процессын хэм хэмжээнд хамааруулж дүгнэлт хийх нь цаашид хууль хэрэглээний алдаатай шийдвэр гаргах эрсдэл дагуулна. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор тухайн этгээдийг яллагдагчаар татсан бол хөөн хэлэлцэх хугацаа зогсох ба энэхүү процессын хэм хэмжээний мөн чанарыг агуулсан зохицуулалт нь хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлснээсээ хойш үйлчлэх бөгөөд уг заалт өөрчлөгдөхөөс өмнө мөрдөж байсан зохицуулалтыг буцааж хэрэглэхгүй гэж тайлбарлажээ.

Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“...Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно...”* гэж, мөн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“...Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ...”* гэж тус тус заасан.

Дээрх зохицуулалтуудаас үзвэл, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг буцаан хэрэглэх боломжтой байдлаар хуульд тусгасан гэж үзэж болох юм.

Учир нь практикт, Улсын дээд шүүхээс 2002 оны Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг буцаан хэрэглэж шийдвэрлэсэн шийдвэр байгаа эсэхийг судлан үзэхэд:

Улсын дээд шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 260 дугаар тогтоолд *“...анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэлийг тогтоохдоо шүүгдэгчийн эрх зүйн байдлыг зөвхөн тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын*

хэмжээнээс хамааруулан тодорхойлж буй нь учир дутагдалтай байна. Учир нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль гэдэгт өмнөх хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулж байсан ялын төрлийг Эрүүгийн шинэ хуулиар ялын төрлөөс хассан, хүчингүйд тооцсон, тодорхой төрлийн ял оногдуулах, эдлүүлэх, ял, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам, нөхцөлийг шинэ хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд ашигтай байдлаар хуульчилсан, оногдуулсан ялыг тэнсэх, хойшлуулах, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг оногдуулах, хэрэглэх үндэслэл журмыг хөнгөрүүлсэн зэрэг нөхцөл байдлыг хамааруулан ойлгох бөгөөд эдгээр бүх нөхцөл нь шүүгдэгчид ашигтайгаар хуульчлагдсан тохиолдолд хууль буцаан хэрэглэнэ. Хэдийгээр 2015 оны Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлсэн атлаа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх буюу хөөн хэлэлцэх хугацаа, оногдуулсан ялыг тэнсэх, хойшлуулах асуудлыг 2002 оны Эрүүгийн хуульд заасан хэмжээнээс хүндрүүлсэн тохиолдолд хууль буцаан хэрэглэхгүйгээр, гэмт хэрэг үйлдэгдэх үед мөрдөгдөж байсан хуулиар шийдвэрлэн, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, оногдуулсан ялыг тэнсэх, хойшлуулах нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг илүү дээрдүүлсэнд тооцогдоно...” гэж;

Мөн Улсын дээд шүүхийн 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 238 дугаар тогтоолд “...2015 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтээр түдгэлзүүлснээс гадна тухайн хууль нь 2002 оны Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг хөндөөгүй тул энэ талаар шүүгдэгчийн өмгөөлөгч нарын гомдолд дурдсан үндэслэлийг хүлээн авч, прокуророос “А”, “Б”, “Б.Б”, “Г” нарт 2002 оны Эрүүгийн хуулийн 263.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр нэр бүхий шүүгдэгч нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, энэ талаар шийтгэх тогтоол, магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн үзэв...” гэж хэргийг шийдвэрлэсэн тохиолдол байна. Мөн дээрх шийдвэрээс гадна гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн шийдвэрүүд ч байсныг дурдах нь зүйтэй.

Үүнээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх зохицуулалтад тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ багассан эсэхээс гадна гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа богино байх асуудал ч хамаарч байна хэмээн үзэж Улсын дээд шүүх зарим хэргүүдийг шийдвэрлэсэн байна. Гэтэл гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг дээр дурдсан байдлаар тайлбарласан хэр нь тус үндэслэлээсээ өөр буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал нь процессын хэм хэмжээ учир буцаан хэрэглэхгүй гэх утга бүхий тайлбар гаргасан нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн, 2022, 2023 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн дараах зохицуулалтыг нэмсэн.

Хүснэгт 14. 2022, 2023 онд нэмэлтээр оруулсан зохицуулалт

Зүйл, заалт	Агуулга
1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт

	хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ.
1.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг	Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.
1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.
1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсэг	Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.

2022, 2023 онд оруулсан дээрх өөрчлөлт нь олон талаар эерэг үр дагаврын бий болгосон зохицуулалт болсон. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "...Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ..." гэж нэмж хуульчилсан нь халдашгүй бүрэн эрхтэй байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтныг үйлдсэн гэмт хэрэгт нь хариуцлага хүлээлгэх боломжийг бий болгож байна. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь "...Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолно гэж заасны дагуу халдашгүй бүрэн эрхээр халхавчлан хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулдаг байдлыг халах зорилгоор энэхүү өөрчлөлтийг тусгалаа..."⁴³ гэжээ.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэг нь бусад гэмт хэргээс олон талаар ялгаатай, нийгмийн хор аюулын хэмжээ, хохирогчид учирсан сэтгэл зүйн цочрол, сэтгэгдэл учирсан гэм хорын асуудал зөвхөн тухайн үед үүсээд зогсохгүй насан туршид нь үргэлжлэх боломжтой байдаг. Иймээс ч хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу "Хүчиндэх" гэмт хэргийн хохирогч арван найман насанд хүрсний дараа тоолж эхлэхээр зохицуулжээ. Гэхдээ тус зохицуулалтад 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэг хамаарахгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Мөн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгохоор тусгасан нь эерэг нөлөөлөл бүхий зохицуулалт болсон байна. Гэхдээ энэхүү зохицуулалт практикт хэрэгжихэд зарим талаар маргаан дагуулах үндэслэлтэй.

Энэ мэт дээр дурдсан асуудал нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтад бүхэлд нь хамаарах бөгөөд авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нарийвчлан судлан үзвэл:

⁴³ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2022 он.

Хүснэгт 15. Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

Зүйл, заалт	Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	3 эсхүл 5 жил
Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил

Монгол Улсад авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихээхэн удаашралтай байгаагаас хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болж, хэргийг хэрэгсэхгүй болгох явдал түгээмэл байгаа нь олон нийтийн шүүмжлэл өртөж байна.⁴⁴

⁴⁴ Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он, 4 дэх тал.

3.1.5. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Гадаадын зарим орны Эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааны талаар хэрхэн тусгасан байдлыг авч үзэх нь нэг талаас гадаад орнуудын Эрүүгийн хуульд энэ талаар тогтоосон хэм хэмжээний нийтлэг болон ялгаатай талыг танин мэдэх, нөгөө талаасаа өөрийн орны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар тогтоосон хэм хэмжээг бусад орныхтой харьцуулан үзэх, туршлага судлах зэрэг олон талын ач холбогдолтой.

Эрүүгийн хууль нь тухайн улс орныхоо соёл иргэншил, түүхэн уламжлал, нийгэм, эдийн засаг, улс төрийн байгууламж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөр өөр байдаг. Англи-Америкийн эрүүгийн хууль тогтоомжид эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацааг заадаггүй, тэрчлэн хөөн хэлэлцэх хугацаа гэсэн институт байдаггүй.⁴⁵ Иймд энэхүү судалгааныхаа хүрээнд Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийн орнуудыг харьцуулан судлаагүй бөгөөд Ром Германы буюу эх газрын болон холимог эрх зүйн системийн улс орнуудаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид ХБНГУ гэх), Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид БНСУ гэх), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид БНХАУ гэх), Оросын Холбооны Улс (цаашид ОХУ гэх)-д гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан байдгийг судлан өөрийн орны зохицуулалттай харьцуулан үзэхийг зорилоо.

Мөн дээрх улсуудад авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн зохицуулсан судлан үзлээ.

Эх газрын (Ром-Германы) эрүүгийн эрх зүйн систем

Эх газрын эрх зүйн тогтолцоо нь XII-XIII зууны үед Европ тивд Ромын эрх зүйн агуулгаар үүссэн. Энэ тогтолцооны онцлог шинж нь бичмэл эрх зүйд тулгуурласан байдаг тул хуулийг эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж гэж үздэг. Эрүүгийн хуулиудыг төрөлжүүлэн нэгтгэсэн байдаг. Шүүхийн прецедентыг хүлээн зөвшөөрдөггүй. Эрүүгийн эрх зүйн хориглолтыг томъёолох өвөрмөц арга, түүнийг хуульд хийсвэрлэн тусгах замаар заасан, хэллэг нь туйлын тодорхой бөгөөд тэдгээрийг хамгийн түгээмэл тохиолдолд хэрэглэдэг нь энэхүү тогтолцооны онцлог юм.⁴⁶

Түүнчлэн, Эрүүгийн хууль тогтоомж нь бүрэн кодификацчилагдаагүй, хагас буюу хэсэгчилсэн байдлаар системчлэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хууль тогтоомж нь зөвхөн нэг хуулиас биш хэд хэдэн зэрэгцсэн Эрүүгийн хууль, хуульчилсан актаас бүрдэх ба ихэнхдээ ерөнхий анги нь хагас буюу хэсэгчилж хуваарилагдсан байх ба тусгай ангийн институт нь кодификацчилагдсан байдгаараа онцлогтой.⁴⁷ Эх газрын эрүүгийн эрх зүйн системийн тогтолцоотой улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсныг дор авч үзье.

⁴⁵ Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2012 он, 42 дахь тал.

⁴⁶ С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, УБ., 1999 он, 372 дахь тал.

⁴⁷ Мөн тэнд.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь 1949 оны ХБНГУ-ын Үндсэн хууль, 1998 оны 11 сарын 13-ны өдөр редакц хийсэн Эрүүгийн хууль (Энэхүү хуульд хамгийн сүүлд 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)⁴⁸, Холбооны тусгай хууль, мужийн Эрүүгийн хууль тогтоомжоос бүрддэг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хэзээ эхэлж, хэзээ зогсох, түдгэлзэх, дуусгавар болох үндэслэл, ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78а-д “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт үйлдэл, эс үйлдэхүй төгссөн үеэс эхэлнэ” гэжээ. Мөн ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78b-д гэмт хэргийн талаарх өргөдөл гомдол ирээгүй учраас хэргийг мөрдөн шалгах боломжгүй байх, гэмт этгээд нь Бундестагийн гишүүн учраас хэргийг мөрдөн шалгах боломжгүй болсон гэх мэт хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх олон үндэслэлүүдийг, Эрүүгийн хуулийн 78с-д гэмт этгээд нь яллагдагчаар татагдсан хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх болсон гэх мэт хөөн хэлэлцэх хугацаа зогсох олон үндэслэлүүдийг тус тус заажээ. Түүнээс гадна ХБНГУ-ын Эрүүгийн хуульд мөрдөн шалгах явцын болон шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх үеийн хөөн хэлэлцэх хугацааг ялгаж зааглан зохицуулсан байна.⁴⁹

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5-р хэсгийн 1-р бүлэгт "Хөөн хэлэлцэх хугацаа" гэсэн бүлгийг хуульчилсан байдаг ба уг бүлгийн 78 дугаар зүйлд:⁵⁰

а) Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн;

б) Арав буюу түүнээс дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;

в) Таваас доошгүй арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

г) Нэгээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

д) Нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу бусад төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар тогтоожээ.


Дээрхээс үзвэл, ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар тогтоосон эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа нь манай одоогийн дагаж мөрдөж байгаа хуулиас хүнд байгаа боловч гэмт

⁴⁸ German Criminal Code https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html

⁴⁹ Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он, 9 дэх тал.

⁵⁰ German Criminal Code, Section 78

https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html



хэргийг хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын төрөл хэмжээнээс хамаарч тоолохоор зохицуулж байгаа байдал нь манай улсын зохицуулалттай ижил. Харин "хор уршиг гэмт үйлдлээс хойш учирсан бол хор уршиг учирсан өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолно"⁵¹ гэж хуульчилсан нь манай эрүүгийн эрх зүйн зохицуулалтаас ялгаатай байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн нэг онцлог нь бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулсан нь манай Эрүүгийн хуулийн зохицуулалтаас ялгаатай. Монгол Улс 2015 оны Эрүүгийн хуульд ялын шинэ төрөл болох бүх насаар хорих ялыг шинээр хуульчилж, уг ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар тусгасан юм.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх хугацааг уг хуулийн ерөнхий ангийн 5 дугаар хэсгийн 2 дугаар бүлгийн 79 дүгээр зүйлд хуульчилсан байна.⁵²

“Шүүхийн ял болон бусад албадлагын арга хэмжээ оногдуулсан тогтоолыг дор дурдсан хугацаанд биелүүлээгүй бол түүнийг биелүүлэх хугацаа хүчингүй:

а) Бүх насаар нь хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй;

б) Арваас дээш жил хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 25 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

в) Таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 20 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

г) Нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 10 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;


д) Нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан эсхүл, 30 өдрийн орлогоос дээш хэмжээгээр торгох ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг 5 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

е) 30 өдөр хүртэлх орлогын хэмжээгээр торгох ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг 3 жилийн хугацаанд биелүүлээгүй бол” гэж заасан байна.

Мөн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацааг хүчин төгөлдөр болсон өдрөөс уг ялыг биелэгдэх хүртэл тоолно гэж заасан нь ихээхэн ач холбогдолтой юм. Учир нь тухайн шийтгэх тогтоолыг хуульд заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд биелүүлэхгүй байх боломжийг хуулиар олгож байна. Энэ нь тухайн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хэр хэмжээ, гэмт хэргийн хохирол, хор уршгаас шалтгаалан зарим төрлийн буюу хөнгөн гэмт хэрэгт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой

⁵¹ Мөн тэнд, 78а дугаар зүйл.

⁵² Мөн тэнд, 79 дүгээр зүйл.



зардал, цаг хугацаа, хүн хүч, ажлын ачаалал гэх мэт олон төрлийн зайлшгүй гарах зардлыг бууруулах ач холбогдолтой. Харин манай улсын хувьд шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх хугацааг хуульчилж өгөөгүй.

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хууль нь 1953 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд ерөнхий болон тусгай ангиас бүрдсэн 42 бүлэг, 372 зүйлтэй. Ерөнхий ангийн 1 дүгээр дэвтрийн 7 дугаар хэсгийн 77 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг үйлдсэн гэмт хэрэгт нь оногдуулж болох ялын төрөл хэмжээтэй нь харьцуулан дараах байдлаар хуульчилжээ.⁵³ Үүнд:

а) Цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн;

б) Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;

в) Арван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн;

г) Таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

д) Таван жил хүртэл хугацаагаар хорих буюу эд хөрөнгө хураах, торгох (500 воноос дээш) ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

е) Бага хэмжээгээр торгох (500 хүртэл вон) буюу баривчлах ял (1-30 хоног) оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар заасан байна.

БНСУ-д гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын төрөл, хэмжээнээс хамаарч тоолохоор хуульчилсан. Мөн цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолдог бөгөөд цаазаар авах, хорих, эд хөрөнгө хураах, торгох, баривчлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхээр зохицуулснаараа манай улсын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтаас илүү боловсронгуй буюу ялын бүх төрөлд хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой байдлаар хуульчилжээ. Харин манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах, торгох болон хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт л хөөн хэлэлцэх хугацааг тоолж байна.

Холимог эрүүгийн эрх зүйн систем

⁵³Criminal code <https://www.refworld.org/pdfid/3f49e3ed4.pdf?fbclid=IwAR18CNwc-G9McbrKQDE4FNcDdauNEd5mILyWy8Wsg3XtNL75nNoAvpXskYs>



Дэлхийн эрх зүйн системийн зонхилох гол загвар болох Англи-Америкийн болон Эх газрын системүүд нь хоорондоо зааг ялгаатай, онцлог хэв шинжийг тусгаж ирсэн боловч улс, үндэстнүүдийн соёл, түүхэн уламжлал тэдгээрийн өвөрмөц байдлаас хамаарч янз бүрийн тогтолцоо бүлүүдийг бий болгон хөгжүүлснийг харж болно. Ялангуяа хөгжингүй болон хөгжиж буй улс орнууд, тэрчлэн шинэ тутам болон хот улс, жижиг арлын орнуудад үндсэн ба зарим системийн хэв шинж, соёл, тогтолцооны хосолсон буюу холимог хэлбэр илэрч байна. Холимог эрүүгийн эрх зүй гэдэг нь түүхэн сонголтын болон түүхэн цаг үеийн нөхцөлд өөрийн орны сонгосон аль нэг системийг хөгжүүлэх явцад эх газрын болон Англи Америкийн системээс зээлдэн авсан буюу өмнөх системээ халж, өөр системд шилжихдээ системүүдийн хэв шинж холилдсон буюу аль нэг систем нь давамгайлсан хандлага бий болсон байдлыг хэлнэ.⁵⁴

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь эрүүгийн эрх зүйн маш өвөрмөц онцлогийг тусгасан байдгийн дээр хэд хэдэн системийн шинжийг өөртөө хослуулан хадгалахын сацуу өөрийн гэсэн бие даасан онол практикийг хослуулан хөгжүүлж байна. БНХАУ нь 1979 онд шинэ Эрүүгийн хуулиа баталсан бөгөөд 1997 онд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталжээ.⁵⁵ Хөөн хэлэлцэх хугацааг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн Наймдугаар хэсэгт Хүчинтэй хугацаа хэмээн хуульчилж өгчээ.⁵⁶

87 дугаар зүйл. Ял хийгээд доорх хугацаанаас хэтэрсэн байвал нэхэмжлэн заалдахгүй.

(Нэг) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жил үл хүрэх хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт таван жил өнгөрөн байвал;

(Хоёр) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жилээс дээш арван таван жил үл хүрэх хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт арван жил өнгөрсөн байвал;

(Гурав) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь арван жилээс дээш хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт арван таван жил өнгөрсөн байвал;

(Дөрөв) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь хугацаагүй хорих, алахаар шийтгэх ёстой байтал нэгэнт хорин жил өнгөрсөн байвал хэрвээ хорин жилийн хойно заавал нэхэмжлэн заалдах хэрэгтэй гэж үзвэл эрх биш Ардын дээд байцаах хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх хэрэгтэй.

88 дугаар зүйл. Ардын байцаах хороо, Дотоодын хамгаалах байгууллага, Улсын амар төвшнийг хамгаалах байгууллага хэрэг болгон туршин байцаах буюу Ардын шүүх

⁵⁴ Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2012 он, 55 дахь тал.

⁵⁵ Criminal Law of the People's Republic of China

<https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm>

⁵⁶ Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2012 он, 58 дахь тал.



хороо хэргийг хүлээн авсны дараа туршин байцаалт буюу шүүн таслалтаас зайлсан байвал нэхэмжлэн заалдах хугацааг хязгаарлахгүй.

Хорлогдогсод нэхэмжлэн заалдах хугацаан дотор илчлэн заалдсан байхад ардын шүүх хороо, ардын байцаах хороо, дотоодын хамгаалах байгууллага хэрэг болгох ёстой байтал үл болгосон байвал нэхэмжлэн заалдах хугацаанд хязгаарлагдахгүй.

89 дүгээр зүйл. Нэхэмжлэн заалдах хугацааг ял хийсэн өдрөөс эхлэн бодно. Ялт үйл ажиллагаа нь залгалдсан буюу үргэлжилсэн байдалтай байвал ялт үйл ажиллагааны илэрсэн өдрөөс эхлэн бодно. Нэхэмжлэн заалдах хугацаанд дахиж ял хийсэн байвал өмнөх ялын нэхэмжлэн заалдах хугацааг хойших ялыг хийсэн өдрөөс эхлэн бодно.⁵⁷

БНХАУ-ын хувьд 60 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулдаг буюу цаазаар авах ялыг маш өргөн хүрээнд хэрэглэдгээрээ онцлогтой.⁵⁸ Гэсэн хэдий ч бүх насаар хорих ял оногдуулах гэмт хэрэг болон алахаар заасан гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааг хорин жил байхаар тогтоож өгсөн нь өвөрмөц зохицуулалт болжээ. Мөн хөөн хэлэлцэх хугацаа зогсох, тасрах, түүнийг хэрхэн тоолох талаар зохицуулалтыг хуульчилсан байна.

Оросын Холбооны Улс

ОХУ-д төрийн ДУМ-аас 1995 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталж 1996 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсөн 4 дэх⁵⁹ Эрүүгийн хууль (тус хуульд хамгийн сүүлд 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)⁶⁰ үйлчилж байгаа бөгөөд уг хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр хэсгийн "Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх" хэмээх 11 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг доорх байдлаар тогтоожээ.

“Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.”⁶¹

а) Нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;

б) Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил өнгөрсөн;

в) Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

г) Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн” гэж заасан ба хугацааг тоолох журам, нөхцөлийг тогтоосон байна.

⁵⁷ Э.Зууннасан, Б.Батзориг, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, УБ., 2006 он.


⁵⁸ Б.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2012 он, 58 дахь тал.

⁵⁹ ОХУ-д 1922, 1923, 1960, 1995 онд тус тус Эрүүгийн хууль батлагдаж байжээ.

⁶⁰ Уголовный кодекс российской федерации

http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/

⁶¹ Мөн тэнд, ОХУ-ын Эрүүгийн хууль, 78 дугаар зүйл.



Мөн хугацааг тогтоосон үндэслэл (гэмт хэргийн ангиллаар) болон хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй гэж заасан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил юм.

Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр хэсгийн 12 дугаар бүлгийн 83 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилжээ:

“Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш доорх хугацаанд түүнийг биелүүлээгүй бол (биечлэн эдэлж дуусаагүй) биелүүлж болохгүй. Энэ тохиолдолд ялтанг уг ялыг эдлэхээс чөлөөлнө.

а) Нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг хоёр жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

б) Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг зургаан жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

в) Хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг арван жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

г) Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг арван таван жилийн хугацаанд биелүүлээгүй бол биелүүлж болохгүй” гэж эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаатайгаа ижил байдлаар тогтоожээ.

Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны тухай ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэм хэмжээ нь тухайлбал, хугацааг тоолох журам, нөхцөл нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ерөнхийдөө адил боловч ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасардаггүй, харин зогсдог байхаар хуульчилснаараа онцлогтой. Мөн хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байхаар тогтоожээ. ОХУ-ын хувьд Эрүүгийн хууль нь бүрэн системчлэгдсэн (кодификацилагдсан) байдаг бөгөөд нэгдмэл төрөлжсөн нэг Эрүүгийн хуультай гэдгээрээ манай улстай ижил. Үүнээс гадна гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамааруулан зохицуулсан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай адил байна.

Дээрх улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хоёр хэлбэрээр өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон оногдуулж болох ялын дээд хэмжээтэй нь харьцуулан, харин таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан ялын төрөл, хэмжээтэй нь харьцуулан тогтоосон байх ба хугацааг тоолох нөхцөл, журам нь ерөнхийдөө нийтлэг боловч хугацааны хязгаар нь харилцан адилгүй байна. Энэ нь тухайн улс орны эрүүгийн эрх зүйн бодлого, гэмт хэргийн гаралт, зан заншил, үндэсний онцлогтой холбоотойгоор тайлбарлагдах бөгөөд дэлхийн хөгжлийн чиг хандлага, гарч буй гэмт хэргийн нөхцөл байдалтай (терроризм, хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэг, үндэстэн дамнасан хэрэг) уялдан хөөн хэлэлцэх хугацааны



хязгаарыг багасгах биш нэмэгдүүлэх хандлага давамгайлж байгаа нь харагдлаа. Манай улсын хувьд хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн зорчих эрхийг хязгаарлах, торгох болон хорих ялтай гэмт хэрэгт тоолохоор зохицуулсан бөгөөд харин таслан шийтгэх тогтоол биелүүлэх хугацаан дээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар буюу хуулиар зохицуулж өгөөгүй. Харьцуулсан судалгаанаас үзэхэд улс орнууд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын бүх төрөл дээр тооцдог байхаар хуульчилсан нь харагдаж байна.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн төрлөөс үл хамаарч, гэмт хэргийн ангилал болон гэмт хэрэгт оногдуулж буй ялын дээд хэмжээгээр тодорхойлогддог түгээмэл жишиг байна. Иймд авлигын гэмт хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг хөндөж, нийгэмд учруулах хор аюул, хохирлын хэмжээ их байдаг тул түүнд оногдуулах ялын хэмжээг хүндрүүлэн тогтоодог. Дэлхийн ихэнх улс орнууд авлигын гэмт хэргийн эсрэг тэмцэл явуулж байгаа бөгөөд авлигын эсрэг тэмцэх Сингапурын болон Шведийн гэсэн хоёр загвар байдаг юм. Сингапурын загварын нэг гол асуудал нь авлигын гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах явдал болно. Авлигын эсрэг тэмцэх Сингапурын загварын дагуу зарим улс орнууд авлигын гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгахаас гадна авлигын гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлж, нарийвчлан хуульчлах болсон байна.⁶²

ХБНГУ, АНУ, Франц зэрэг улс орнууд авлигын гэмт хэргийн ойлголт, түүний мөн чанар, агуулга, хэлбэр, төрлийг нарийвчлан тодорхойлж хуульчилжээ. Тухайлбал, ихэнх улс орнуудын хувьд нийтийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах, хахууль авах, өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг авлигын гэмт хэрэгт тооцож байгаа боловч зарим улс орнуудад авлигын гэмт хэргийг нийтийн албан тушаалтнуудын үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчилсан байна. Тухайлбал, шүүх, гааль, банкны ажилтны авлигын гэмт хэрэг гэх мэт.⁶³

⁶² Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он, 10 дахь тал.

⁶³ Мөн тэнд.



3.2. “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Судалгааны энэ бүлэгт Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-д заасан хөрөнгө орлого хураахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар судлан үзнэ. Энэ хүрээнд авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураах холбоотой асуудлын дэлгэрүүлэн судалж, зарим улсын туршлагыг судлан үзнэ.

3.2.1. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ОЛСОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХ ТУХАЙ ОЙЛГОЛТ

“Хөрөнгө хураан авах” гэдэг нь шүүх болон эрх бүхий бусад байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авахыг хэлнэ. Хөрөнгийн эрх, гэрчилгээг улс өөрийн нэр дээр шилжүүлэн авах бөгөөд тэдгээрийг эзэмшиж байсан этгээдэд ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй. Хөрөнгийг хураан авахад хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурор, шүүгч, санхүүгийн шинжээч, хөрөнгийн менежер эсвэл хөрөнгийн удирдлагын агентлаг зэрэг төрөл бүрийн ур чадвартай хувь хүн, байгууллагууд харилцан уялдаа холбоотой, хамтран ажиллах шаардлагатай.


Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц ба ФАТФ-ын Зөвлөмжүүд (ФАТФ 2019) шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахыг дэмждэг бөгөөд хөрөнгө хураан авах талаар зохицуулалтыг өргөжүүлж, уг зарчмыг хүлээн зөвшөөрөн шинээр нэвтрүүлж буй улс орны тоо өсөн нэмэгдсээр байна. Хөрөнгө хураан авах үндэслэл нь:

Нэгдүгээрт, хууль бус орлого бий болгож буй авлига, бусад гэмт хэрэг нь төр, Засгийн газар, эсвэл хувь этгээдэд хохирол учруулдаг тул тэдгээрт нөхөн төлбөр олгогдох ёстой.

Хоёрдугаарт, эдгээр гэмт хэргийг үйлдэх үндсэн зорилго нь хууль бус орлого олох явдал байдаг тул хөрөнгийг хурааснаар ашиг шимийг нь хүртэх боломжгүй болгож улмаар урьдчилан сэргийлэх үр нөлөө үзүүлдэг. Тухайлбал, хөрөнгө хураан авах нь “гэмт хэрэг үйлдэж орлого олох боломжгүй” гэсэн ойлголтыг бий болгох зорилготой.

Хөрөнгө хураахтай холбоотой хууль тогтоомж, практикт ажиглагдаж буй томоохон ач холбогдол бүхий чиг хандлагын нэг нь няцаагдах боломжтой презумпци буюу үндэслэл бүхий таамаг, дүгнэлтийг илүү өргөнөөр ашиглах болсон явдал юм. Презумпци гэдэг нь бодит баталгаагүй нөхцөлд учир шалтгааныг магадлах, тунгаан бодох замаар тодорхой нөхцөл байдалд тулгуурлан баримт, таамаглалын үнэн болохыг тогтоосон гаргалгаа, дүгнэлтийг хэлнэ.

Төрийн албан хаагчдын авлигын хэргүүдэд гэмт үйлдэл болон шүүгдэгчийн өмчилж, эзэмшиж буй хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох бараг боломжгүй байдаг. Энэ тохиолдолд презумпци чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх хугацаанд олсон орлого, хөрөнгийнхөө гарал үүслийг өөрөө тайлбарлаж чадахгүй нөхцөлд прокурорын байгууллагаас уг хөрөнгийн эх үүсвэр хууль бус болохыг нотлох шаардлагагүй болсон нь яллах ба хөрөнгө хураах шийдвэр гарах магадлалыг ихээхэн нэмэгдүүлж өгсөн.



Мөн хөрөнгийн үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах хэлбэр буюу гэмт хэргийн улмаас олсон ашиг хонжооны дүнг шүүх болон эрх бүхий байгууллагууд тооцоолж тухайн дүнд дүйцэх хөрөнгийг шүүгдэгчээс хураах шийдвэр гаргадаг.

Хөрөнгө хураах авах ойлголтын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил ба сүүлийн үеийн чиг хандлага

Хөрөнгө хураах авах тухай ойлголт нь олон жил хэрэгжиж байгаа бөгөөд олон мянган жилийн өмнөх хуулийн баримт бичгүүдэд хөрөнгө хураах жишээнүүдийг дурдсан байдаг. Эдгээр эртний хуулиудаас өвлөгдөн ирсэн хөрөнгө хураах хуулиуд Английн хуулийн тогтолцоо, Эх газрын эрх зүйн тогтолцооны аль алинд нь шингэн тусгагдсан. 1980-аад онд мансууруулах бодисын наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлт нэмэгдэхийн хэрээр зарим улс оронд эрүүгийн журмаар хөрөнгө битүүмжлэх, мөн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

Сүүлийн жилүүдэд хууль бус хөрөнгө, орлогыг хураах нь илт ихэссэн, учир нь гэмт хэрэг үйлдэж олсон орлого маш өндөр байхад хураасан хөрөнгийн хэмжээ их биш байгаа юм. Үүнтэй холбоотойгоор хөрөнгө, орлогыг хураах хууль тогтоомжид шинээр дараах чиг хандлага бий болсон. Үүнд:

- Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах заалтыг нэвтрүүлсэн;
- Хөрөнгө хураах үнэлгээнд суурилсан аргачлалыг хөгжүүлсэн;
- Нотлох баримтын стандартыг бууруулсан;
- Зарим нөхцөлд нотлох шаардлагаас чөлөөлсөн;
- Презумпцийг илүү өргөнөөр ашиглах болсон;
- Гэмт хэргийн бэлэн мөнгө, бусад хэрэгслийг шүүхийн бус буюу захиргааны аргаар хураах тохиолдол нэмэгдсэн.

Хууль бус хөрөнгийг хураан авах журам


Авлигын хөрөнгө , орлогыг хураах гурван төрөл байна. Үүнд:

- эрүүгийн журмаар,
- яллах шийдвэргүйгээр,
- захиргааны журмаар.

Мөн зарим оронд холимог тогтолцоог хэрэглэж байна. Тухайлбал, шүүхэд нэхэмжлэл гаргах, тусгаарлах зэрэг иргэний процессийн арга хэмжээг эрүүгийн ажиллагаанд хэрэглэж хөрөнгө, орлогыг хураадаг.

Эрүүгийн журмаар хөрөнгө хураах

Эрүүгийн журмаар яллаж хөрөнгө хураахын тулд шүүхээр хэлэлцэж яллах шийдвэр гаргуулсан эсхүл шүүгдэгч гэм буруугаа хүлээж зөвшөөрсөн байх ёстой байдаг. Яллах дүгнэлт гарсан хойно шүүхээс хөрөнгө хураах эцсийн шийдвэр гаргадаг, ихэнх тохиолдолд энэ нь шүүгдэгчид оногдуулсан ялын нэг хэсэг байдаг. Зарим улс орнуудад хөрөнгө хураах нь шүүхийн шийдвэрт заавал ордог бол зарим улсад шүүх эсхүл тангарагтны шүүх уг



асуудлыг өөрийн үзэмжээр шийддэг. Эрүүгийн журмаар хөрөнгө хураах нь өмчид суурилсан, үнэлгээнд суурилсан, эсвэл хослуулсан байж болдог.

Зарим улс оронд (тухайлбал, яллах үйл явц, хөрөнгө хураах үйл явц гэх мэт) хэргийн хоёр үе шатанд эд мөрийн баримтын тухайд өөр өөр стандартууд ашиглаж болдог. Яллах ажиллагааны тухайд эрүүгийн стандартын дагуу тавигддаг нотолгоо, эд мөрийн баримтыг бүрдүүлж шүүгдэгчид яллах дүгнэлт гаргуулах нь прокурорын хувьд хамгийн чухал асуудал байдаг, үүнд нийтийн эрх зүйн тогтолцоотой улс оронд “үндэслэл бүхий сэжиг”, харин эх газрын эрх зүйн тогтолцоонд “бодит үнэнийг тогтоох” зарчмыг ашиглаж болно. Гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг нотлохын тулд эд мөрийн баримт, нотолгооны энэ стандартыг эхний ээлжид хангасан байх ёстой, үүний дараа хөрөнгө хураах асуудал яригдана.

Хөрөнгө хураах ажиллагааны тухайд эд мөрийн баримт, нотолгооны өөр стандарт мөрдөгдөж болох хэдий ч хөрөнгө хураах асуудлыг хэлэлцэх явцад үйлдсэн хэрэг, хураах хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох зэрэг нэмэлт шаардлагыг шүүхээс тавьж болно. Зарим улсад ийм хоёрдогч шаардлагыг хангахад нотлох баримтын стандартын “магадлалын тэнцвэр” доогуур байхыг зөвшөөрдөг бол заримд нь эрүүгийн яллах ажиллагаа, хөрөнгө хураах ажиллагаанд яг ижил түвшний нотлох баримт шаарддаг.


Яллах шийдвэр гарсан байх шаардлага үйлчилж байгаа нөхцөлд хэрэгтэн нас барсан, өөр орон руу зугтсан, эсхүл өөр ямар нэг шалтгаанаар шүүхээр орох боломжгүй болсон тохиолдлуудад хөрөнгө хураахад бэрхшээлтэй болдог. Хэрэгтэн оргон зайлсан гэдэг нь тогтоогдсон бол зарим улсад холбогдогчийн эзгүйд шүүх хурлыг явуулдаг, эсвэл хөрөнгө хураах зорилгоор хэрэгтэнг “яллагдсанд” тооцдог болсон.

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах (зарим тохиолдолд “иргэний журмаар” хөрөнгө хураах гэгддэг) нь ихэнх тохиолдолд хөрөнгийг эзэмшиж, өмчилж буй этгээдийн эсрэг бус өмчид суурилсан тухайн хөрөнгийн эсрэг ажиллагаа байдаг тул яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагаанд тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг нотлоход л хангалттай байдаг. Үүнд холбогдогч этгээдийн эсрэг яллах шийдвэр гарсан эсэх нь хамаагүй. Ийм төрлийн хөрөнгө хураалт хоёр арга замаар явагддаг.

Нэгд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд явагддаг, гэхдээ яллах шийдвэр гарах, гэм буруутайг нотолсон байх шаардлага тавигддаггүй. Энэ тохиолдолд яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хуулийг Эрүүгийн хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, эсхүл өөр бусад эрүүгийн хууль тогтоомжид нэгтгэн оруулдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг гэж үздэг.

Хоёрт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусдаа, бие даасан байдлаар эсвэл зэрэгцээ ажиллагаа явуулах боломжтой бие даасан хууль гаргаж хөрөнгө хураах нь яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах. Энэ нь эрүүгийн гэхээсээ илүүтэйгээр иргэний эсхүл захиргааны журмаар явагдах нь түгээмэл байдаг. Иргэний журмаар хөрөнгө



хураах зарчим ашигладаг улс орнуудад нотлох баримтын стандартын “магадлалын тэнцвэр” эсхүл “нотлох баримтын давамгай байдал” доогуур байхыг зөвшөөрдөг тул өмч, хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг прокурор нотлох үүрэг, шаардлагыг бууруулж өгдөг. Гэхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн, тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан гэдгийг нотлох шаардлага тавигдсан хэвээр байдаг. Нотлох баримт нь эрүүгийн журмаар яллах дүгнэлт гаргахад хангалтгүй нөхцөлд хөрөнгө хураах шийдвэр гаргаж болдог.

Захиргааны журмаар хөрөнгө хураах

Захиргааны журмаар хөрөнгө хураахад шүүхийн шийдвэр шаардлагагүй байж болдог. Гэхдээ улс орноос хамааран зарим тохиолдолд шүүхээр орох шаардлагатай байдаг. Аль нэг тал хөрөнгө хураахыг эсэргүүцээгүй, мөн тодорхой (жишээлбэл, талуудад мэдэгдэл хүргүүлсэн, хэвлэн нийтэлсэн, мөн сөрөг нэхэмжлэл ирээгүй гэх мэт) шаардлагууд хангагдсан нөхцөлд түгээмэл ашигладаг. Үүнээс гадна, захиргааны журмаар хураах хөрөнгийн үнийн дүнд дээд хэмжээ заах, эсхүл төрөл зүйлийн жагсаалт гаргах гэх мэтээр үйлчлэх цар хүрээг хязгаарлах заалтуудыг хуульд тусгадаг. Мөн захиргааны журмаар хөрөнгө хураах тухай хуулиудад зарим шийдвэрийг шүүхээс гаргах тухай зохицуулалт оруулах тохиолдол түгээмэл байдаг.


Хураан авах үйл ажиллагаа

Хөрөнгө хураахад 1/ хөрөнгөд суурилсан (тодорхой хөрөнгийг зааж өгдөг), эсхүл 2/ үнэлгээнд суурилсан (тодорхой этгээдийн төлөх ёстой үнийн дүнг зааж өгдөг) гэх хоёр аргачлалыг ашигладаг. Зарим улс оронд энэ хоёр аргачлалыг аль алийг нь хослуулан ашигладаг бөгөөд олж тогтоосон хөрөнгө, орлогыг хураах, мөн холбогдогч этгээдийн хууль ёсны өмч хөрөнгөөс хохирлыг барагдуулах шийдвэр гаргуулдаг. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд нийтлэг зүйл олон байдаг. Гэхдээ ашиглаж буй журам, үйл явц, хөрөнгө, орлогыг хураахад тавигддаг нотлох баримт, эд мөрийн баримтын шаардлага, стандартууд нь ялгаатай.

Авлигын замаар олсон орлогыг хураах нь дараах зорилготой.

1. Урьдчилан сэргийлэх: Авлига авсан албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах нь шинээр гэмт хэрэг үйлдэхээс сэргийлээд зогсохгүй ижил төрлийн гэмт хэрэгт өртөмтгий бусад хүмүүст сэрэмжлүүлэг болдог.
2. Хохирол нөхөн төлүүлэх/нөхөн сэргээх: авлигын гэмт хэргийн хохирогчдын хохирлыг нөхөн төлүүлэх, бусад эрх, ашиг сонирхлыг хамгаалах зэрэг үндсэн агуулгуудад багтана.

Зарим улс оронд авлигын гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, олсон орлогыг хураахаас гадна ял шийтгүүлсэн хүний бүх хөрөнгийг, тэр дундаа хууль ёсны дагуу, хууль ёсны эх сурвалжаас олж авсан эд хөрөнгийг ч хураан авдаг.



Хөрөнгө хураах нь шийтгэлийн үүрэг гүйцэтгэдэг CAN (Зүүн Европ ба Төв Азийн авлигын эсрэг сүлжээ)-ийн орнууд.

- Армени, Беларусь, Казахстан, Киргизстан, Тажикстан, Туркменистан, Украин зэрэг багтана.

Урьдчилсан сэргийлэх үүрэг гүйцэтгэдэг бүс нутгийн орнууд.

- Азарбайжан, Гүрж, Литва, Молдова, Румын, Серби, Словени, Хорват, Монтенегро, Эстони зэрэг.

Ихэнх улс оронд эд хөрөнгө хураах нь хохирогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, эсвэл хураагдсан эд хөрөнгийн зардлаар тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нөхөн сэргээх чиг үүрэгтэй байдаг.

Хөрөнгө хураах журмын 3 үе шат:


1. Мөрдөн шалгалтын үе. Энэ үе шатанд гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, байршлыг тогтоох, эзэмшигчийн талаарх нотлох баримт (мөн эд хөрөнгийн талаарх мэдээлэл)-ыг цуглуулах санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хийнэ. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд шүүхийн шийдвэрээр хожим хураан авах зорилгоор түр зуурын арга хэмжээ (битүүмжлэх) авч болно.
2. Шүүхийн үе шат. Энэ үе шатанд ял шийтгэл оногдуулах (эсвэл, цагаатгах), эсвэл эд хөрөнгийг хураах талаарх эцсийн шийдвэрийг шүүхээс гаргана.
3. Удирдах үе шат. Төрөөс тухайн эд хөрөнгийг бодитоор хураан авч олон улсад хөрөнгө хуваарилах, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах үе шат.

Манай улсын хувьд хөрөнгө, орлогыг хураах эрх зүйн зохицуулалтыг ерөнхийд нь:

1. Эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа
2. Иргэний журмаар хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа
3. Захиргааны журмаар хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа гэж хувааж байна.

Үүнээс эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь in personam буюу шүүгдэгчийн эсрэг биечлэн хийх үйлдэл байдаг ба яллах дүгнэлтэд эд хөрөнгийг хураах саналтай байгаа тухай тусгадаг. Ингэхдээ ял шийтгэл заавал оногдуулах шаардлагатай ба эд хөрөнгө хураах нь тухайн ялын нэг хэсэг болдог. Эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн ашиг сонирхлоор хязгаарлагддаг бөгөөд үүнд шүүгдэгчийн хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг хамаатуулан ойлгодог. Өөрөөр хэлбэл, яллагдагчийг ялласан тодорхой тооллогод хамаарах эд хөрөнгөөр хязгаарлагддаг.

Түүнчлэн, Монгол Улсын хувьд хөрөнгө орлогыг хураах нь Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ялаас гадна ялтанд тусгай үүрэг хүлээлгэж



эрхийн хязгаарлалт тогтоохыг хэлнэ гэж тодорхойлсон.⁶⁴ Мөн үүнээс гадна албадлагын арга хэмжээг гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулдаг, ялын бус шинжтэй, төрийн албадлагын арга хэмжээний төрлийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Албадлагын арга хэмжээг Эрүүгийн хууль тогтоомжид ялаас гадна аюулгүй байдлын арга хэмжээг оногдуулж болдог дуалист тогтолцоо бүхий улс орнуудад албадлагын гэхээс илүүтэйгээр тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн гэмт этгээдийн өөрийнх нь эрх ашигт нийцсэн арга хэмжээг давхар хэрэглэдэг бөгөөд энэ нь ял биш, гагцхүү гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж буй этгээдэд шүүхээс оногдуулсан ялтай хамтатган хэрэглэдэг жишиг гадаадын улс орнуудад тогтсон байна.

Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг хэлбэр боловч ялаас ялгагдах дараах онцлог шинжтэй⁶⁵. Үүнд:

- Албадлагын арга хэмжээ нь ял биш /ялын шинжийг агуулдаггүй/, ялын төрөл биш. Эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай болох нь нотлогдсон хүнтэй үр дүнтэй ажиллах, хувь хүнд нөлөөлөх шинжтэй арга хэмжээ юм.
- Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл бөгөөд бие даасан ойлголт, ухагдахуун юм.
- Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын төрөл, хэмжээг тухайн зүйлийн санкцад тогтоосон, шүүх тухайн төрөл, хэмжээний дотор ял оногдуулдаг бол тусгай ангийн санкцид албадлагын арга хэмжээ, түүний төрөл, хэмжээг хуульчилж өгөөгүй. Харин Эрүүгийн хууль дахь тусгай журмаар зохицуулдаг.


Албадлагын арга хэмжээний дээрх тодорхойлолт болон зорилгод хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь мөн хамаарна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулах ялын бус, өөрийн эрх ашигт нийцсэн тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоох үйл ажиллагаа юм.

Монгол Улсын хөрөнгө, орлогыг хураах эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд хөрөнгө, орлогыг хураах зохицуулалтыг хуульчилж ирсэн байна. 1926, 1929, 1934

⁶⁴ Д.Бадам “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй(Тайлбар толь)” 2018 он, 6 дахь тал.

⁶⁵ Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, УБ., 2020 он, 419-420 дахь тал.



оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд нэмэгдэл ял болон ялын шинжтэй хуульчилж ирсэн байна.

1926, 1929 оны Шүүх цаазын бичгүүдийн 5 дугаар зүйлд хөрөнгийг хураахыг албадан хураах, 1934 оны Шүүх цаазын бичгийн 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах, 1942 оны Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлд энэ ялыг хэвээр хуульчилсан. Эд хөрөнгө хураах ялыг 1926, 1929 оны хуулиар гол төлөв эд хахууль авах ба өгөх, хулгайлах, булаах, дээрэмдэх, контрабанд үйлдэх, хууль бус ан хийх, улсын ба ард олны эд хөрөнгийг сүйтгэх зэрэг шунахай сэдэлт бүхий гэмт хэргүүдэд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэж байсан. 1934, 1942 оны Шүүх цаазын бичгийн 1 дүгээр бүлэгт заасан “Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд”-эд буудан алж, хөрөнгийг бүрэн хураах ял шийтгэхээр хуульчилсан нь онцгой зохицуулалт болсон⁶⁶.

1961 оны Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлд “Шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр хурааж улсын санд нийлүүлэхийг хөрөнгө хураах ял гэнэ.” гэж анх удаа энэ ялын тодорхойлолтыг хуульчлагдсан бөгөөд шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгээс шийтгэгдсэн этгээд буюу түүний асрамжаар амьдарч байгаа хүмүүст зайлшгүй хэрэгцээтэй хурааж болохгүй эд зүйлийн жагсаалтыг хуульчлан заасан нь өмнөх хуулиудын зохицуулалттай харьцуулбал энэрэнгүй агуулгатай болсон. Энэ хуулийн төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүд болох эх орноосоо урвах /45 дугаар зүйл/, тагнуул үйлдэх /46 дугаар зүйл/, улс төрийн зорилгоор аллага хийх /47 дугаар зүйл/, хорлон сүйтгэх /48 дугаар зүйл/ гэмт хэргүүдэд цаазаар авч хөрөнгө хураах нэмэгдэл ял хуульчлагдсан⁶⁷.

1986 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр зааж байсныг хэвээр үлдээж, төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүдэд нэмэгдэл ял болгон хэрэглэхээр тусгажээ⁶⁸.

2002 оны Эрүүгийн хуульд эд хөрөнгө хураах ял хэмээн ялын нэг төрөл болгон хуульчилсан байна. Ингэхдээ 46.2-т зааснаар зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр зохицуулсан байна. Энэхүү ялыг тус хуулийн 49 дүгээр зүйлд дараах байдлаар зохицуулсан байна.


- Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.
- Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана.

2002 оны Эрүүгийн хуульд заасан 145 дугаар зүйл буюу Бусдын эд хөрөнгийг хулгайлах, 147 дугаар зүйл буюу Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 148 дугаар зүйл буюу

⁶⁶ С.Жанцан, “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол(ялын тухай сургааль) II боть”, УБ., 2014 он, 174 дэх тал

⁶⁷ Мөн тэнд.

⁶⁸ Мөн тэнд.



Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 149 дүгээр зүйл буюу Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх, 156 дугаар зүйл буюу Банкны тухай хууль тогтоомж зөрчих, 157 дугаар зүйл буюу Банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох, 161 дүгээр зүйл буюу Хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх, 166 дугаар зүйл буюу Татвар төлөхөөс зайлсхийх, 175 дугаар зүйл буюу Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, 176 дугаар зүйл буюу Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах гэсэн гэмт хэргүүдэд эд хөрөнгө хураах ялыг нэмэлтээр оногдуулж болохоор хуульчилсан байна.

Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хөрөнгө, орлогыг хураах зохицуулалтыг 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар албадлагын арга хэмжээ болгон хуульчилсан байна. Энэхүү албадлагын арга хэмжээг тус хуулийн 7.5 дугаар зүйлд тухайлан хуульчилж зохицуулсан байна.

2002 оны Эрүүгийн хуульд нэмэгдэл ялд хамаарч байсан эд хөрөнгө хураах ялыг 2015 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ болгон хуульчилсан нь дараах учир шалтгаантай. Үүнд:

1. Монгол Улсын олон улсын гэрээнд эд хөрөнгө хураах явдлыг гэмт хэрэгт оногдуулах ял байх нь зохисгүй гэж үздэг.
2. Монгол Улсын олон улсын гэрээнд гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг гэдгийг Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тэмцэх конвенцийн агуулгаар тодорхойлох шаардлагатай.
3. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгслийг 2002 оны Эрүүгийн хуульд /49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэг/ эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана гэж заасан нь хэрэглэхэд бэрхшээл учруулж байсан.⁶⁹

⁶⁹ Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он, 81 дэх тал.

3.2.2. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хураахад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Үнэлгээ:

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон. Тус хуулийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээний нэгэн төрөлд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хуульчилсан байна.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шүүх энэхүү арга хэмжээг хэрэглэхдээ хураах эд зүйл, түүний үнэ, эд хөрөнгө, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд оногдох эд хөрөнгө гэдгийг иргэний эрх зүйн агуулгаар ойлгоно. /Монгол Улсын Иргэний хуулийн 127 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө /хувьд оногдох/ өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй бөгөөд өөрөөр тохиролцоогүй бол гэр бүлийн гишүүд хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ өөрийн хуваарьт эд хөрөнгөөр хариуцдаг.⁷⁰

Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно...” гэж заажээ.

Мөн энэ хуульд хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлага болгож хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт хуульчилсан байна. Улмаар тус хуулийн 9.5, 9.6 дугаар зүйлд үүнийг тухайлан зохицуулсан байна.

Эрүүгийн хуулийн 9.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Хуулийн этгээдийг татан буулгасан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ...” гэж, 9.6 дугаар зүйлийн 1-д “...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө,

⁷⁰ Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он, 81 дэх тал.

орлогоос албадан гаргуулна...” гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт “...Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална...” гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүнд хамаараад зогсохгүй хуулийн этгээдэд оногдуулж болох эрүүгийн хариуцлагын төрөл юм.

Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хурааж, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлснээр уг арга хэмжээг биелүүлсэнд тооцно.

Монгол Улсын хувьд 2019-2022 онд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг гүйцэтгэсэн байдлыг харвал:

Хүснэгт 16. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан

Он	Гүйцэтгэвэл зохих этгээдийн тоо	Гүйцэтгэсэн этгээдийн тоо	Үлдэгдэл
2019	523	400	123
2020	961	641	320
2021	1316	808	508
2022	1640	1161	479

Дээрх хүснэгтээс харвал, жил ирэх тусам хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан тохиолдол нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд АТГ-аас хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд албан тушаалтны хөрөнгөжих, нуугдмал хөрөнгийг олж илрүүлсний үндсэн дээр битүүмжлэх болон хураан авсан эд хөрөнгийн нарийвчлан үзвэл:

2024 оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 428.213.259.053,06 (дөрвөн зуун хорин найман тэрбум хоёр зуун арван гурван сая хоёр зуун тавин есөн мянга тавин гурав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 213.721 956.513,75 (хоёр зуун арван гурван тэрбум долоон зуун хорин нэгэн сая есөн зуун тавин зургаан мянга таван зуун арван гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 20.756.341.909,00 (хорин тэрбум долоон зуун тавин зургаан сая гурван зуун дөчин нэгэн мянга есөн зуун ес) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

2023 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 845.797.805.525,00 (найман зуун дөчин таван тэрбум, долоон зуун ерэн долоон сая, найман зуун таван мянга таван зуун хорин тав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 238.689.979.559,00 (хоёр зуун гучин найман тэрбум, зургаан зуун наян есөн сая, есөн зуун далан есөн мянга таван зуун тавин ес) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 17.137.615.448,00 (арван долоон тэрбум, нэг зуун гучин долоон сая, зургаан зуун арван таван мянга, дөрвөн зуун дөчин найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.



Нийт учирсан хохирлын 28.2 хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, хахуулийн 8.680.730.871 (найман тэрбум зургаан зуун наян сая долоон зуун гучин мянга найман зуун далан нэг) төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

2022 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 5.024.895.829.317,00 (таван их наяд, хорин дөрвөн тэрбум, найман зуун ерэн таван сая, найман зуун хорин есөн мянга, гурван зуун арван долоо) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 2.374.934.309.243,00 (хоёр их наяд гурван зуун далан дөрвөн тэрбум, есөн зуун гучин дөрвөн сая, гурван зуун есөн мянга, хоёр зуун дөчин гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 518.039.332.298,00 (таван зуун арван найман тэрбум, гучин есөн сая, гурван зуун гучин хоёр мянга, хоёр зуун ерэн найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.


Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, нөхөн төлүүлэлт 24.7 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт учирсан хохирлын 47.3 хувийг нөхөн төлүүлээд байна. Хахуулийн 18,874,521.566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

Тохиолдол 1.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа иргэд, аж ахуйн нэгжээс хясан боогдуулах замаар их хэмжээний хахууль авсан “Н.Б” нарт холбогдох хэргийг УДШ 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр эцэслэн шийдвэрлэсэн. Тус хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үед эд мөрийн баримтаар “Н.Б”-ийн Хан-Уул дүүргийн Жаргалан хотхон дахь орон сууцанд нэгжлэг хийж зочны өрөөнөөс 5.1 сая төгрөг, 16.460 ам.доллар, унтлагын өрөөнөөс 17.5 сая төгрөг, сейфнээс 140 сая төгрөг, 127.117 ам.доллар, 50.000 юань, мөн түүний ажлын өрөөнөөс 10.8 сая төгрөг, 8600 ам.доллар тус тус хураан авсан нь нийт 230.8 сая төгрөг, 152.177 ам.доллар, 70.000 юань олсон бөгөөд дээрх мөнгө, валютыг шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 3, 4-т заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж үзэх үндэслэл гэж үзэн улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Хэрэг эцэслэгдэн шийдвэрлэгдсэний дараа “Н.Б”-ээс хураан авч Авлигатай тэмцэх газарт битүүмжлэгдэн хадгалж байсан 173.4 сая төгрөг, 152.177 ам.доллар, 50.000 юань, “Г.Э”-ээс хураан авсан 5 сая төгрөг, “С.Б”-ээс хураан авсан 5 сая төгрөг буюу нийт 639,244,450 төгрөгийг мөрдөгчид Сангийн яамны төрийн сангийн дансанд тушааж улсын орлого болгосон.

Мөн энэ хэргийн өөр нэг холбогдогч болох “Э.А”-д холбогдох хэргийг тусгаарлаж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Мөрдөн шалгах ажиллагааны явцад “Э.А”-йн өмчлөлийн Репид хотхон дахь орон сууцнаас 57.4 сая төгрөг, 20.000 юань эд мөрийн баримтаар хураан авсан байна.

2022 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын



орлого болгоно...” гэх зохицуулалтыг шинээр нэмж хуульчилсан. Тус зохицуулалтыг хуульчилснаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх эрх зүйн үндэслэл болох боловч гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгох боломжит зохицуулалт юм. Гэхдээ нэгэнт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусч яллагдагчаар татаж болохгүй үндэслэл тогтоогдсон учир гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд тухайн хөрөнгийг хэрхэн гэмт хэрэг үйлдэж олсон гэдгийг нотлох, яаж шалгах нь маш эргэлзээтэй зохицуулалт болохоор байна.


ЭХХШТХ-ийн 21 дүгээр бүлэгт “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ”-ний талаар зохицуулсан бөгөөд тус хуулийн 21.1 дүгээр зүйлд “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах” зохицуулалтыг тусгажээ. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “...Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна...” гэж мөн зүйлийн 3 дахь хэсэгт “...Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна...”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “...Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно...” гэж тус тус заажээ.

Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191 дүгээр зүйлд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх талаар зохицуулсан. Гэвч ЭХХШТХ, ШШГТХ-д битүүмжилсэн хураасан эд хөрөнгийг тусгай зориулалтын байранд хадгалуулна гэж заасан боловч ийм төрлийн хадгалах байртай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага манай улсад байхгүй байна. Тусгай зориулалтай байр нь онцгой бараа бүтээгдэхүүн эд зүйлсийг хадгалах тоног төхөөрөмж тоноглогдсон байх шаардлагыг дотроо агуулна. Гэвч хууль болон журмаар тэрхүү тусгай зориулалтын байрын стандартыг тогтоогоогүйгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагууд дотооддоо сул, чөлөөтэй өрөө тасалгаандаа хураан авсан хөрөнгөө хадгалж байна. Хөрөнгийг хадгалах тусгай зориулалтын байрын стандарт байхгүйгээс дээр дурдсан хөрөнгийн шинж чанар алдагдах эрсдэлийг давхар үүсгэж байна.⁷¹

Өөрөөр хэлбэл, хуульд зохицуулалт нь тусгагдсан боловч практикт тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна. Мөн албадлагын арга хэмжээ авч хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг улсын орлого болгож, улсын төсөвт оруулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна.

Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох...” гэж заажээ. Тус хуулийн 7.1.7-д “...албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх...” гэж, 7.1.8-д “...үндэслэлгүйгээр хөрөнгөжих...” гэж заажээ. Энэ нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгтэй ижил агуулгыг илэрхийлж байна. Нөгөөтээгүүр,

⁷¹ Э.Өнөболд, Э.Цэрэнханд, “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг оногдуулсан хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт өгүүлэл, <https://legalddata.mn/buteel/pdf?id=1755>



Эрүүгийн хуульд заасан дээрх 2 төрлийн гэмт хэргийн шинжийг бүрэн хангаагүй ч /тухайлбал, Үндэслэлгүй хөрөнгөжсөн тохиолдолд хохирлын хэмжээ 100.000.000 төгрөг хүрэхгүй байх/ Авлигын эсрэг хуульд зааснаар хариуцлага хүлээх боломжтой мэт харагдаж байгаа боловч практикт энэхүү зохицуулалтаар хариуцлага хүлээсэн тохиолдол байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд заасан дээрх гэмт хэрэг үйлдсэн гэж үзвэл шүүх Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийг хэрэглэн шийдвэр гаргаж байна. Нөгөөтээгүүр, Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дээрх тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан боловч гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн хангагдаагүй тохиолдолд зөвхөн Авлигын эсрэг хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх боломжгүй байна. Энэ нь тухайн хүнийг хариуцлагаас чөлөөлөх, ял завших боломжийг олгож байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоог хангах зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн, өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг эргүүлэн авахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг байна. Нөгөөтээгүүр, хөрөнгө эргүүлэн өгөх олон улсын шинжтэй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн ялгаатай байдал, мэргэшсэн техник ур чадвар хангалтгүй байх, эргүүлэн өгөх үйл явцыг удирдан зохион байгуулах улс төрийн хүсэл зориг сул байх, авлигын асуудалд нэрвэгдсэн, улс төр, эдийн засаг, нийгэм нь тогтворгүй байгаа улс оронд хөрөнгө эргүүлэн өгөхтэй холбоотой зовнил түгшүүр зэрэг техникийн болон улс төрийн янз бүрийн саад бэрхшээл тулгарч байна. Авлига, мөнгө угаах, хөрөнгө буцаан олгох ажиллагаанд хоёр өөр улсын шүүх өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах, эргүүлэн өгөх асуудалд өөр өөр өнцгөөс ханддаг нь ихээхэн бэрхшээл учруулж байгааг улс орнууд анхааралдаа авч энэхүү сорил бэрхшээлийг арилгахад хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна.⁷²

⁷² Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг буцаан авах ажиллагаа /Гарын авлага/, УЕПГ, АТГ, 2020 он.

3.2.3. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХТАЙ ХОЛБООТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Европын холбооны парламентын зөвлөлийн тайлан: (Хөрөнгө хураахтай холбогдох заалтууд)

Шийтгэх үндэслэлээр эд хөрөнгө хураах (4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

Дөрөвдүгээр зүйлийн 1-д гишүүн орнуудын хувьд гэмт хэрэг үйлдсэн нь эцсийн байдлаар хууль бусаар хөрөнгө олж авсан, хөрөнгийн үнэлгээ нь орлоготой таарч байгаа тохиолдолд хөрөнгө хураах боломжтой. Үүнийг өөр улсын шүүхээс тогтоогдсон байж болно.

Бүх гишүүн улсууд эцсийн шийдвэр гарсан тохиолдолд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг хураах боломжтой.

Ихэнх гишүүн орнуудад (Бельги, Болгар, Чех, Грек, Испани, Кипр, Франц, Итали, Латви, Люксембург, Мальта, Унгар, Австри, Польш, Португал, Словени, Словак, Финлянд, Швед) гэмт хэргийн хэрэгсэл, олсон орлоготой дүйцэхүйц үнэ бүхий бусад хөрөнгийг хураан авдаг. Зарим гишүүн орнууд (Герман, Эстони, Ирланд, Хорват, Литва, Нидерланд) хурааж авах эд хөрөнгийн үнэд дүйцэх хэмжээний мөнгийг ялтанд төлөх боломжийг олгодог.

Шийтгэх үндэслэлгүй эд хөрөнгө хураах (4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

Хэрэв 4 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу эцсийн тогтоолоор хууль бусаар олж авсан хөрөнгө гэдэг нь тогтоогдсон хэдий ч өвдсөн эсвэл оргон зайлсан буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд сэжигтэн, яллагдагч хэмээн үзэж гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг хураах боломжийг бүрдүүлэх ёстой.

Мальта, Австри улсад өвчтэй, оргон зайлсан тохиолдолд урьд нь ял шийтгэлгүйгээр эд хөрөнгийг хураах боломжтой байдаг. Румынд улсад төрийн албан тушаал хашиж буй албан тушаалтны эх үүсвэр нь тодорхойгүй хууль бус хөрөнгө, орлогыг хурааж авдаг.

Швед улсад (жишээ нь, гэмт хэрэгтэн нас барсан эсвэл хөөн хэлэлцэх хугацаа дууссан) яллагдагч, сэжигтэн этгээдэд ял оноох боломжгүй тохиолдолд хөрөнгө хураах асуудлыг хэлэлцдэг бол Грекийн мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж нь гэмт хэрэгтэн нас барсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зогссон эсвэл хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж мэдэгдсэн тохиолдолд гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах боломжтой болдог.

Өргөтгөн хураах (5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

5 дугаар зүйлд хураах хугацааг сунгах тухай заалтуудыг тусгасан гэмт хэрэгтнээс хураан авч буй эд хөрөнгө нь эдийн засгийн үр өгөөжтэй байх ёстой гэж үздэг.

Тухайлбал, Австри улсад эд хөрөнгийг хууль бусаар олсон гэж үзэх үндэслэл тогтоогдвол хөрөнгө, орлогыг хураан авах хугацааг сунгахыг зөвшөөрдөг. Эстони, Кипр, Нидерландад шүүх эд хөрөнгийг хууль бус үйл ажиллагаанаас олсон гэж "таамаглах" боломжтой байдаг бол Испанид шүүх эд хөрөнгө нь хууль бус үйл ажиллагаанаас үүдэлтэй болохыг " бодит нотолгоонд үндэслэн шийдвэрлэх" ёстой байдаг.



Хугацаа сунгах шаардлагатай эрүүгийн гэмт хэргийн хамрах хүрээ (5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)

5 дугаар зүйлийн 2-т гэмт хэргийн тодорхой жагсаалт, мөн Захирамжийн 3 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт (Европын холбооны баримт бичиг эсвэл үндэсний хууль тогтоомжийн дагуу) хорих ялаар шийтгэгдэх ёстой гэж заасан байдаг. Энэ нь хамгийн багадаа 4 жил.

Гуравдагч этгээдээс хураах (6 дугаар зүйл)

6 дугаар зүйлд сэжигтэн эсвэл яллагдагчаас гуравдагч этгээдэд шилжүүлсэн гэмт хэргийн орлогыг хураах эрхийг гишүүн орнуудаас шаарддаг. 6 дугаар зүйлд зааснаар гуравдагч этгээд хөрөнгө шилжүүлэн авахдаа нөгөө хүний зорилго нь эд хөрөнгөө хураалгахаас зайлсхийсэн явдал гэдгийг мэдэж байсан тохиолдолд гуравдагч этгээдийн эд хөрөнгийг хураах боломжтой байдаг.

Бельги, Унгар, Австри, Словак зэрэг улсад эд зүйлийг сэжигтэн, яллагдагч, гуравдагч этгээдийнх эсэхээс үл хамааран хураан авах, хууль бус гарал үүсэлтэй бол хураан авах ерөнхий дүрмийг баримталдаг.

Гуравдагч этгээд хөрөнгө шилжүүлэн авахдаа зорилго нь хураалгахаас зайлсхийж байсан гэдгийг мэдэж байсан эсвэл мэдсэн байх ёстой гэсэн шаардлагыг ихэнх гишүүн орнуудын хууль тогтоомжид тусгасан байдаг (Болгар, Чех, Герман, Эстони, Ирланд, Грек, Испани, Кипр, Литва, Мальта, Нидерланд, Польш, Португал, Словени, Финлянд, Швед).

Франц, Латви, Люксембургийн хууль тогтоомжид ял шийтгүүлсэн этгээдийн өмч хөрөнгийг хураах тухай заалт байдаг. Италийн хууль тогтоомж нь ялтны өмч барааг (бие хүн, хуулийн этгээдээр дамжуулан) хураахыг зөвшөөрдөг. Хорватын хуульд "хүний нэр дээр шилжүүлсэн эсвэл сайн санааны үүднээс олж аваагүй" хууль бус өмчийг хураах тухай зохицуулсан байдаг.


6 дугаар зүйлд зөвхөн "гуравдагч этгээдэд шууд болон шууд бусаар шилжүүлсэн буюу олж авсан орлогыг" хураах тухай заасан.

Румынд үндэсний хууль тогтоомжид гэр бүлийн гишүүд болон хуулийн этгээдийн өмч хөрөнгийг хураах тухай заасан байдаг. Болгар улсад уг заалтыг иргэний эд хөрөнгийг хураах тухай хуулиар сольсон бөгөөд энэ нь гэмт хэргийн тодорхой жагсаалтад хамаарна.

6 дугаар зүйлийн 2-т шударга гуравдагч этгээдийн эрхийг зөрчих ёсгүй гэж заасан. Гишүүн орнуудын хууль тогтоомж нь уг удирдамжийн энэ заалттай нийцэж байгаа бөгөөд гуравдагч этгээдийн шударга ёсны эрхийг хадгалахыг баталгаажуулдаг.

Царцаах (7 дугаар зүйл)

7 дугаар зүйлийн 1-д гишүүн орнуудын хувьд шаардлагатай арга хэмжээний дагуу битүүмжлэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь дараагийн шатанд эд хөрөнгийг хураан



авах зорилготой. Мөн эд хөрөнгийг үрэгдүүлэхгүйн тулд яаралтай царцаах (худалдах, шилжүүлэх, үрэх, үрэх гэх мэт) хэрэгтэй гэж үздэг.

Гишүүн орнуудад эд хөрөнгийг дараа нь хураах зорилгоор битүүмжлэх боломжтой болсон. Герман, Чех, Эстони, Ирланд, Итали, Латви, Люксембург, Унгар, Польш, Португал, Словак, Швед улсууд прокурор, хууль сахиулах байгууллагад яаралтай арга хэмжээ авч, шүүхийн зөвшөөрөл авахаас өмнө эд хөрөнгийг битүүмжлэх эрхийг олгосон байна.

7 дугаар зүйлийн 2-т гишүүн орнууд гуравдагч этгээдийн өмч хөрөнгийг дараа нь хураах зорилгоор битүүмжлэх боломжийг олгохыг шаарддаг. Энэ нь бүх гишүүн орнуудад хэрэгжих боломжтой байдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улс:

Авлига хахуулиар олж авсан хөрөнгийг хурааж авах тухай хууль тогтоомж

Гуравдугаар зүйл (Авлигын аргаар олж авсан эд хөрөнгийг хураах)

1. Авлигын аргаар олж авсан эд хөрөнгийг дараах тохиолдолд хурааж болно. Хэрэв бусад хууль тогтоомжид авлигын аргаар олж авсан эд хөрөнгийг хураах шаардлагатай тохиолдолд хууль, журмын дагуу тухайн эд хөрөнгийг хураана.
2. (1)-д заасны дагуу хураан авахаар заагдсан авлигын аргаар олж авсан эд хөрөнгө нь бусад эд хөрөнгөтэй холилдсон тохиолдолд авлигын аргаар олж авсан эд хөрөнгө болон бусад өмчийг /“нийлсэн эд хөрөнгө” гэж үзэн/ хурааж болно.

Дөрөвдүгээр зүйл (хураагдах нөхцөл)

1. 3 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө хураах нь авлигын аргаар олж авсан, эсвэл нийлсэн эд хөрөнгө нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс өөр этгээдэд хамаарахгүй тохиолдолд: Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тухайн эд хөрөнгийг өөр этгээдэд шилжүүлэн хариуцуулах тохиолдолд тухайн хөрөнгийг авлигын арга замаар олж авсан, гэмт хэргийн шинжтэй гэдгийг мэдсээр байж авсан тохиолдолд “Эрүүгийн орлого нуун дарагдуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуулийн 4 дүгээр зүйл”-д зааснаар хурааж авч болно.
2. Авлигын аргаар олж авсан эд хөрөнгө, эсвэл нийлсэн эд хөрөнгө нь гэм буруутай этгээдээс өөр этгээдэд өвлөгдсөн, үнэ төлбөргүй өгсөн буюу бэлгийн шугамаар авсан, үнэлгээнээс хямд үнээр эзэмшиж байгаа бол бүхэлд нь буюу хэсэгчлэн хурааж болно. Энэ нь тухайн хүн эдгээрийн аль нэг байдлаар эд хөрөнгө авахдаа гэмт хэргийн талаар мэдээгүй байсан тохиолдолд.
3. 3 дугаар зүйлд заасны дагуу ил тод, барьцаа зээл, хууль ёсны, үүрэг хариуцлагын хүрээнд эд хөрөнгийг хураасан тохиолдолд гэмт хэрэг үйлдэхээс өмнө болон дараа өөр этгээд авсан тохиолдолд үүрэг хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг, Эрүүгийн



хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судалсан болно. Харин практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах ажиллагааг сонгон авч Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг албадан хураахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр бүлэгт заасан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээтэй холбоотой зарим зохицуулалтыг сонгон авч хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Мөн харьцуулсан судалгаа хийж, гадаадын сайн туршлага бүхий улс, орнууд болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс гэх мэт тухайн эрх зүйн зохицуулалтын хүрээнд өөр өөр улс сонгон авч судалсан болно.


Тус судалгааны ажлыг гүйцэтгэж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн тухайд Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн шинжийг зөв тодорхойлж, нотлох ажиллагааг энэ гэмт хэргийн өөрийн онцлогт тулгуурлан явуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт энэ төрлийн гэмт хэргийн хувьд хангагдах урьдач нөхцөл болохоор байна. Манай улсын хувьд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан боловч тус хэргийн илрүүлэлт, шүүхээр шийдвэрлэгдэж буй байдал хангалттай түвшинд хүрээгүй болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Түүнчлэн, хууль хоорондын уялдаа холбоог хангах нь нэн чухал асуудал болоод байна. Ялангуяа Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн хувьд практикт үйлдэгдэж буй тоог шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоотой харьцуулахад маш бага байх магадлалтай. Учир нь авлигын гэмт хэрэг нь нуугдмал гэмт хэрэг төдийгүй, тухайн хэргийн илрүүлэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэнийг нотлох, олж тогтоох ажиллагаа нарийн ээдрээ төвөгтэй байдаг. Иймд зөвхөн Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, авлигын зарим гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялын хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохгүй байх гэх мэт зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар тухайн асуудал шийдэгдэхгүй.

Харин авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй АТГ-ын албан хаагчдыг чадавхжуулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын өөр хоорондын уялдаа холбоог сайжруулах, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг оновчтойгоор тодорхойлох гэх мэт илүү үр дүнтэй аргуудыг хэрэглэх нь зүйтэй. Хуулийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завших боломжийг олгож байгаа төдийгүй Эрүүгийн хуульд Авлигын гэмт хэргийн зохицуулалт, тэр дундаа Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалт зорилгодоо хангалттай хүрэхгүй байна.



Иймд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг зөв тодорхойлж, бусад хуулийн зохицуулалттай уялдуулах зайлшгүй шаардлагатай байна.

2. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн төрлөөс үл хамаарч, гэмт хэргийн ангилал болон гэмт хэрэгт оногдуулж буй ялын дээд хэмжээгээр тодорхойлогддог түгээмэл жишиг байна. Иймд авлигын гэмт хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг хөндөж, нийгэмд учруулах хор аюул, хохирлын хэмжээ их байдаг тул түүнд оногдуулах ялын хэмжээг хүндрүүлэн тогтоодог.

Монгол Улсад авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихээхэн удаашралтай байгаагаас хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болж, хэргийг хэрэгсэхгүй болгох явдал түгээмэл байгаа нь олон нийтийн шүүмжлэлд өртөж байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг хуульчилсан бөгөөд тус зохицуулалтад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн хийдэл бүхий асуудлыг зохицуулахыг оролдож байсан билээ. Гэхдээ өнөөдөр ч тус зохицуулалтад эрх зүйн хийдэлтэй асуудлууд байсаар байна. Иймд тухайн асуудлуудыг нэгтгэн дүгнэж, цогц байдлаар засаж сайжруулах шаардлагатай.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Албадлагын арга хэмжээг Эрүүгийн хууль тогтоомжид ялаас гадна аюулгүй байдлын арга хэмжээг оногдуулж болдог дуалист тогтолцоо бүхий улс орнуудад албадлагын гэхээс илүүтэйгээр тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн гэмт этгээдийн өөрийнх нь эрх ашигт нийцсэн арга хэмжээг давхар хэрэглэдэг бөгөөд энэ нь ял биш, гагцхүү гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж буй этгээдэд шүүхээс оногдуулсан ялтай хамтатган хэрэглэдэг жишиг гадны улс орнуудад тогтсон байна.

Монгол Улсын хувьд хөрөнгө орлогыг хураах нь Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ялаас гадна ялтанд тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоохыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан “Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”, ЭХХШтХ-ийн 21 дүгээр бүлэгт заасан “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ”-ний зохицуулалтын заримыг сонгон авч үнэлэхэд хуульд зохицуулалт нь тусгагдсан боловч практикт тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал тогтоогдож байна.

Манай улсад албадлагын арга хэмжээ авч хураан авсан хөрөнгө, орлогыг улсын орлого болгож, улсын төсөвт оруулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг



нарийвчлан зохицуулсан журам байхгүй. Мөн хууль хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас зарим зохицуулалт практикт хэрэгжих боломж хязгаарлагдаж байна.

Түүнчлэн, өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг эргүүлэн авахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг байна. Нөгөөтээгүүр, хөрөнгө эргүүлэн өгөх олон улсын шинжтэй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн ялгаатай байдал, мэргэшсэн техник ур чадвар хангалтгүй байх, эргүүлэн өгөх үйл явцыг удирдан зохион байгуулах улс төрийн хүсэл зориг сул байх, авлигын асуудалд нэрвэгдсэн, улс төр, эдийн засаг, нийгэм нь тогтворгүй байгаа улс оронд хөрөнгө эргүүлэн өгөхтэй холбоотой зовнил түгшүүр зэрэг техникийн болон улс төрийн янз бүрийн саад бэрхшээл тулгарч байна.

Авлига, мөнгө угаах, хөрөнгө буцаан олгох ажиллагаанд хоёр өөр улсын шүүх өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах, эргүүлэн өгөх асуудалд өөр өөр өнцгөөс ханддаг нь ихээхэн бэрхшээл учруулж байгааг улс орнууд анхааралдаа авч энэхүү сорил бэрхшээлийг арилгахад хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, 2003 он
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006, №35;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012, №8;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017, №24;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”;

НОМ, СУРАХ БИЧИГ, СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЭМХЭТГЭЛ

- Авлига болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж практик /гарын авлага/, УДШ, 2022 он;
- АТГ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан;
- АТГ-ын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;
- Б.Мөнгөнсүвд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, 2024 он;
- Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, 2020 он;
- Г.Халиунаа, Б.Ариунжаргал, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа” тулгамдаж буй асуудал, 2021 он;
- Д.Бадам, “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй(Тайлбар толь)” 2018 он;
- Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 2012 он;
- Ж.Батмөнх, Хууль бусаар баяжих гэмт хэргийг Монгол улсын Эрүүгийн хуульд хуульчлах шаардлага, 2011 он;
- Жан-Пьер Бран, Анастасия Сотирополу нар, Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага /Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл/, АТГ, УЕПГ, Дэлхийн банк, 2020 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСА33, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСА33, 2018 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2018, МУГХУСА33, 2019 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2019, МУГХУСА33, 2020 он;

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2020, МУГХУСА33, 2021 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2021, МУГХУСА33, 2022 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2022, МУГХУСА33, 2023 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, 1999 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он;
- Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, 2019 он;
- Э.Зууннасан, Б.Батзориг, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, 2006 он;
- Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, 2021 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2022 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он;

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ ЭХ СУРВАЛЖ

- Criminal Law of the People's Republic of China
<https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm>
- German Criminal Code https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html
- Уголовный кодекс российской федерации
http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/

БУСАД ЭХ СУРВАЛЖ

- Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.
- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim>
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1011 дугаар магадлал.
- УДШ-ийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 121 дугаар тогтоол
- ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 13-ны өдрийн 377 дугаар цагаатгах тогтоол.
- ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 2021/ШЦТ/516 дугаартай шийтгэх тогтоол.

ХАВСРАЛТ

Гадаадын улс, орнууд дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа

Д/д	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
1	Монгол Улс	Ерөнхий зохицуулалт Эрүүгийн хууль 1.10 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: 1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн; 1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн; 1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн. 1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг	Хугацааг тоолж эхлэх Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно" гэж тодорхой хуульчилсан байна.	Хугацаа тасрах, шинээр тоолох Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно." гэж зохицуулсан.	Хугацааг зогсоох, сэргээн тоолох Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ"; 8 дахь хэсэгт "Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно." гэж зохицуулсан.	Хугацааг тоолохгүй байх Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй." гэж зохицуулсан.	Хугацааг тодорхой хязгаартай тоолох Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно." гэж зохицуулсан.

		хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.					
2	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Ерөнхий зохицуулалт Эрүүгийн хууль (Strafgesetzbuch, StGB) 5 дугаар бүлэг 78-р зүйл. Мөрдөн байцаах хөөн хэлэлцэх хугацаа (МБХХХ) (1)Хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар гэмт хэрэгт ял оногдуулахгүй бөгөөд арга хэмжээ авахгүй. Энэ хуулийн 76а дугаар зүйлийн 2 дахь хэсэгт ⁷³ хамаарахгүй. (3) Мөрдөн шалгах ХХХ-г дараах байдлаар тоолно: - Бүх насаар хорих ял оноох гэмт хэргийн хувьд 30 жил - 10-аас дээш хорих ял оноох гэмт хэргийн хувьд 25 жил - 5-аас доошгүй 10 хүртэлх жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд 10 жил - 1-ээс доошгүй 5	Хугацааг тоолж эхлэх 78а-р зүйл. Тоолж эхлэх Гэмт хэрэг төгссөнөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Хэрэв гэмт хэргийн бүрэлдэхүүн болж буй үр дүн хожим бий болсон бол тэр үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Тодруулбал: ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэрэг хэзээ үйлдэгдэхээс үл хамааран хор уршиг илэрсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэхээр хуульчилсан нь ихээхэн	Хугацаа тасрах 78с-р зүйл. Тасрах (МБХХХ) (1)Дараах үндэслэлээр ХХХ тасарна: - Сэжигтнээс анхны мэдүүлэг авах, түүний эсрэг мөрдөн шалгах ажиллагаа эхэлснийг мэдэгдэх, эсвэл ийм байцаалт болон мэдэгдэл гаргах тухай шийдвэрлэсэнээр, - Мэдүүлэг авах шүүхийн бүх ажиллагаа, эсвэл түүнийг явуулах тухай шийдвэрлэсэнээр, - Сэжигтэн өмнө нь байцаагдаж байсан эсвэл түүнд мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдсэн бол шүүгч эсвэл прокурор шинжээч томилох бүрд, - Шүүх хураан авах болон нэгжлэг хийх тухай шийдвэрлэх болон шүүхийн эдгээр шийдвэрийг хэвээр үлдээх бүрд, - Баривчлах, цагдан хорих зорилгоор баривчлах, урьдчилан баривчлах тухай шийдвэрлэх болон шүүхийн эдгээр шийдвэрийг хэвээр үлдээх бүрд, - Олон нийтийн нэхэмжлэл гарснаар,	Хугацааг зогсоох, сэргээн тоолох 78b-р зүйл. Зогсох (МБХХХ) (1)Дараах тохиолдолд ХХХ зогсоно: - Энэ хуулийн 174-174с, 176-178 /бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд/, 180 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт, 188 /хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд/, 225 /хэрцгийгээр тамлах/, 226а /хүний эд эрхтнийг зэрэмдэглэх/ болон 237 дугаар зүйлд /эмэгтэй хүний хүсэл зоригийн эсрэг хүчээр гэр бүл болох/ заасан гэмт хэргүүдийн хувьд хохирогч 30 нас хүрэх хүртэл, -Хуульд заасны дагуу мөрдөн шалгалт эхлэх, эсвэл үргэлжлэх боломжгүй бол; өргөдөл, зөвшөөрөл, гадаад улсад яллах хүсэлт гаргаагүйн улмаас мөрдөн шалгах боломжгүй байгаа тохиолдолд үүнд хамаарахгүй.	Хугацааг тоолохгүй байх 78-р зүйл. Хугацаа тоолохгүй байх (2) Энэ хуулийн 211 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн (аллага) хувьд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Тодруулбал: Аллага үйлдсэн этгээдийг бүх насаар нь хорих ял шийтгэх ба уг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй. Өөрөөр хэлбэл энэ гэмт хэрэг хэдийд ч илэрсэн бай мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэрэгтэнд хуулийн харуцлага хүлээлгэх боломжтой байдаг. ⁷⁵	Хугацааг тодорхой хязгаартай тоолох 78с-р зүйл. (3)ХХХ тасрах бүрд ХХХ-г шинээр тоолж эхэлнэ. Энэ хуулийн 78а дугаар зүйлд заасан хугацаанаас хойш тухайн хугацааг <u>2 дахин нэмэгдүүлсэн хугацаа өнгөрсөн бөгөөд тусгайлсан хуулийн дагуу ХХХ 3 хүртэлх жил байгаа тохиолдолд хамгийн багадаа 3 жил өнгөрсөн бол мөрдөн шалгах ажиллагааны ХХХ дуусна.</u> Энэ хуулийн 78b дугаар зүйл үүнд хамаарахгүй. (Энэ нь ХХХ тоолохыг хязгаарласан заалтууд ба МУ-ын ЭХХШтХ-ийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй төстэй зохицуулалт юм.) Тодруулбал: Үүнээс үзвэл гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн (1) тухайн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай хамт (2) мөрдөн шалгах ажиллагаа явуулах нийт хугацаа зэрэгцэн тоологдох бөгөөд гэмт хэргийг мөрдөн шалгах нийт хугацаа нь гэмт хэрэг

⁷³ 76а (2). Гэмт хэрэг мөрдөх хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол энэ хуулийн 73, 73b дугаар зүйл болон 73с дугаар зүйлд заасан урьдчилсан нөхцлүүдийн хүрээнд гэмт хэргийн улмаас олсон орлого болон орлоготой тэнцэх мөнгөн дүнг хураан авахыг шүүх бие даан шийдвэрлэж болно. Энэ хуулийн 74b болон 74d дугаар зүйлд заасан урьдчилсан нөхцлүүдийн хүрээнд аюултай эд зүйл хураан авах, баримт бичиг хураан авах болон ашиглах боломжгүй болгоход дээрх заалт мөн адил үйлчилнэ.

⁷⁵ ХБНГУ-ын Бавари муж улсын Дээд шүүхийн дэд ерөнхийлөгч Андреас Цвергер: Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт манай орныхоос зарчмын ялгаатай байна, <https://ikon.mn/n/1oj3>

		хүртэлх жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд 5 жил - Бусад гэмт хэргийн хувьд 3 жил (4) Энэ хуулийн ерөнхий ангид зохицуулсан эсвэл онц хүнд, хүндэвтэр гэмт хэргийн хувьд заасан хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг үл харгалзан энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл хүлээхээс хамаарч хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.	онцлогтой.⁷⁴ - Хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаа эхэлснээр - XXX үндсэн ажиллагаа явуулах бүрд - Ял оногдуулах шийдвэр болон түүнд хамаарах бусад шийдвэрүүд, - Шүүгдэгч ирээгүйн улмаас шүүх хуралдааныг түр хугацаанд хойшлуулснаар, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгчийн байгаа газрыг тогтоох, эсвэл нотлох баримтыг баталгаажуулах зорилгоор шүүгч эсвэл прокурор шүүх хуралдааныг түр хугацаагаар хойшлуулах тухай шийдвэр гаргах бүрд, эсвэл - Шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох боломжгүйн улмаас шүүх хуралдааныг түр хугацаанд хойшлуулснаар, түүнчлэн шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсэхийг хянан шалгах зорилгоор шүүгч эсвэл прокурор шүүх хуралдааныг түр хугацаанд хойшлуулах тухай шийдвэр гаргах бүрд, - Гадаад улсад мөрдөн шалгалт явуулах тухай шүүх хүсэлт гаргаснаар. Урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорих ажиллагаа болон бусад бие даасан ажиллагааны үеэр энэ зүйлийн 1 дэх өгүүлбэрт заасан	(2) Гэмт хэрэгтэн Бундестагийн гишүүн эсвэл мужийн хууль тогтоох байгууллагын гишүүн учир мөрдөн шалгах боломжгүй байгаа тохиолдолд дараах байдлаар XXX-г тоолж эхлэх ба энэ хүртэл XXX зогсоно: - Прокурор, эрх бүхий байгууллага эсвэл цагдаагийн ажилтан тухайн гэмт хэрэг болон гэмт хэрэгтний тухай мэдсэн эсвэл, - Гэмт хэрэгтний эсрэг өргөдөл эсвэл гэмт хэрэг үйлдсэн тухай мэдэгдэл гарсан (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 158 дугаар зүйл) (3) XXX дуусахаас өмнө анхан шатны шүүхийн шийдвэр гарсан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүчин төгөлдөр болохоос өмнө XXX дуусгавар болохгүй. (4) Онц хүнд гэмт хэрэгт таваас дээш жилийн ял оногдуулахаар хуульд заасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаа мужийн шүүхэд нээгдсэн бол энэ хуулийг 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4-	үйлдсэн өдрөөс эхлэн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаагаар хязгаарлагдана. Тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу уг хэргийн мөрдөн байцаалтын нийт хугацаа дууссан тохиолдолд хэргийг мөрдөж шалгах хугацааг сунгахгүй. Энэ нь дурдсан хугацаанд цуглуулсан нотлох баримтын хэмжээнд хэргийг шүүхэд шилжүүлэх гэсэн давхар агуулгыг илэрхийлсэн бөгөөд уг хугацаа дууссаны дараа бэхжүүлсэн, цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах онцлогтой хууль хэрэглээний хувьд чухал ач холбогдолтой зохицуулалт болжээ.⁷⁶
--	--	--	--	--	--

⁷⁴С.Өмирбек, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа”, <https://omir.blogmn.net/116964/gemt-hergiig-huun-helelceh-hugacaa,-tuuniig-tooloh-juram,-harcuulsan-sudalgaa.html>

⁷⁶ С.Өмирбек, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа”, <https://omir.blogmn.net/116964/gemt-hergiig-huun-helelceh-hugacaa,-tuuniig-tooloh-juram,-harcuulsan-sudalgaa.html>

			үндэслэлээр дээрх ажиллагаануудыг явуулсан тохиолдолд XXX тасарна. (2) Бичгээр гаргасан шийдвэрийн хувьд шийдвэр дээр гарын үсэг зурснаар XXX тасарна. Хэрэв баримт бичиг гарын үсэг зурсны дараа шууд хэрэгжихгүй бол хэрэгжиж эхэлснээр XXX тасарна. Шинээр тоолох тухай зохицуулалт: (3)XXX тасрах бүрд XXX-г шинээр тоолж эхэлнэ. Энэ хуулийн 78а дугаар зүйлд заасан хугацаанаас хойш тухайн хугацааг 2 дахин нэмэгдүүлсэн хугацаа өнгөрсөн бөгөөд тусгайлсан хуулийн дагуу XXX 3 хүртэлх жил байгаа тохиолдолд хамгийн багадаа 3 жил өнгөрсөн бол мөрдөн шалгах ажиллагааны XXX дуусна. Энэ хуулийн 78b дугаар зүйл үүнд хамаарахгүй. (Энэ нь XXX тоолохыг хязгаарласан заалтууд ба МУ-ын ЭХХШтХ-ийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй төстэй зохицуулалт юм.) Тодруулбал: ХБНГУ-д XXX-г хэрэг үйлдсэн мөчөөс тоолж эхэлдэг. Мөрдөн шалгах ажиллагааг эхлэх, сэжигтэнд энэ талаар мэдэгдэх, сэжигтнийг байцаах, гэрчээс мэдүүлэг авах, хэргийг шүүхэд шилжүүлэх, шүүхээс нэмэлт мөрдөн шалгалт явуулах гэх мэт хэргийг илрүүлэхэд чиглэсэн алхам тус бүрд уг хугацаа дахин дахин шинээр тоологдож эхэлдэг.	т заасан тохиолдлын хувьд (1-ээс доошгүй 5 хүртэлт жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд 5 жил XXX тоолно) дээрх ажиллагаа эхэлснээс хойш 5 хүртэлх жилийн хугацаанд XXX зогсоно; энэ зүйлийн 3 дахь хэсэг үүнд хамаарахгүй. (5) Гэмт хэрэгтэн гадаад улсад оршин суудаг бөгөөд эрх бүхий байгууллага тухайн улсад шилжүүлэн өгөх тухай хүсэлт гаргавал хүсэлтийг тухайн гадаад улс хүлээн авснаас хойш дор дурдсан хугацаа хүртэл XXX зогсоно: - Герман улсын эрх бүхий байгууллагад гэмт хэрэгтнийг шилжүүлэх хүртэл, - Гэмт хэрэгтэн тухай улсын нутаг дэвсгэрийг өөр байдлаар орхих хүртэл, - Гадаад улс энэ хүсэлтэд татгалзсан тухай шийдвэрийг Герман улсын эрх бүхий байгууллага хүлээн авах хүртэл, эсвэл - Энэ хүсэлтийг бүцаан татах хүртэл. Үйлчлэхгүй байх тохиолдол: Тухайн хүсэлтийг гадаад улс хүлээн авсан огноо тодорхойгүй бөгөөд хүсэлт гаргасан эрх бүхий байгууллага тухайн хүсэлтийг огт хүлээн аваагүй буюу хожуу хүлээн авсныг мэдсэнээс бусад тохиолдолд тухайн	
--	--	--	---	--	--

				Хөөн хэлэлцэх хугацааны зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан дуусгахад оршдоггүй. Гэмт хэргийн хортой үр дагавар нь цаг хугацааны явцад шарх мэт аажмаар илаарьшдаг гэж үздэг.Иймд тухайн хэрэгт мөрдөн шалгах алхам хэрэгжүүлэх болгонд тэрхүү шарх сэдэрч, хэрэг шалгах, шийдвэрлэх хугацаа нь шинээр эхлэх ёстой гэсэн зарчим цаана нь агуулагдаж байдаг.	хүсэлтийг илгээснээс эсвэл гардуулснаас хойш нэг сарын дотор гадаад улс түүнийг хүлээж авсан гэж үзнэ. 2002 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Зөвлөлийн шийдвэрээр батлагдсан Европын холбооны гишүүн орнууд хооронд баривчилгаа явуулах болон хэрэгтэн шилжүүлэх тухай журам дээр (ABl. EG Nr. L 190 S. 1) эсвэл Эрүүгийн эрх зүйн асуудлаар улс орон хоорондын харилцан туслалцаа үзүүлэх тухай олон улсын гэрээн дээр ХХХ-ны тухай төсөөтэй зохицуулсан бол энэ зүйлийн 1 дэх өгүүлбэр үйлчлэхгүй. (6)Энэ хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1-3-т заасан тохиолдлуудын хувьд гэмт хэрэгтнийг Олон улсын эрүүгийн шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий гадаад улсруу шилжүүлэхээс эхлээд Герман улсын эрх бүхий байгууллагад буцаан шилжүүлэх хүртэл буюу Олон улсын эрүүгийн шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий гадаад улс тухайн этгээдийг ялаас чөлөөлөх хүртэл ХХХ зогсоно.			
3	Америкийн Нэгдсэн Улс	Эрүүгийн хууль нь тухайн улс орныхоо соёл иргэншил, түүхэн уламжлал, нийгэм, эдийн засаг, улс төрийн байгууламж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөр өөр байдаг. Англи-Америкийн эрүүгийн хууль тогтоомжид Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацааг заадаггүй, тэрчлэн хөөн хэлэлцэх хугацаа гэсэн институт байдаггүй. ⁷⁷ Гэхдээ Англи-						

⁷⁷ Д.Баярсайхан, “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”, УБ, 2011 он, 42 дахь тал.

Америкийн эрх зүйн бүлд хамаарах улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хязгаарлагдмал хүрээнд /зарим гэмт хэргүүдэд/ хэрэглэдэг.⁷⁸ Иймд судалгааны энэ хэсэгт АНУ-ын хууль тогтоомжид заасан гэмт хэргийн хязгаарлалт (манай хөөн хэлэлцэх хугацаатай төстэй зохицуулалт)-ыг авч үзнэ.

**АНУ-ын 18 мужийн Гэмт Хэргийн Ерөнхий хууль
/18 U.S. Code/**

**213 дугаар хэсэг
Хязгаарлалт
(3281-3301 дүгээр зүйл)**

18 U.S. Code § 3281 – Цаазын ялтай гэмт хэргийн хувьд

Цаазаар авах ялтай аливаа гэмт хэргийн яллах дүгнэлтийг ямар ч үед ямар ч хязгаарлалтгүйгээр хийж болно.

18 U.S. Code § 3282 – Цаазаас бусад ялтай гэмт хэргийн хувьд

(a)Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн гэмт хэрэг үйлдсэнээс хойш **5 жилийн** дотор яллах дүгнэлт үйлдэгдэхгүй, эсхүл мэдээлэл тогтоогдоогүй бол хэнд ч эрүүгийн хариуцлага ногдуулах ёсгүй.

(b)ДНХ-ийн профайлын яллах дүгнэлт.

(1) Ерөнхий зохицуулалт:

109А бүлэгт заасан яллагдагчийг хэн болох нь тодорхойгүй гэмт хэрэгт буруутгах, аливаа яллах дүгнэлтэд яллагдагчийг нэр нь тодорхойгүй боловч тодорхой ДНХ-ийн дүр төрхтэй хувь хүн гэж тодорхойлоход хангалттай.

(2) Үл хамаарах зохицуулалт:

109А бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш 5 жилийн дотор илэрсэн (1)-д заасан аливаа яллах дүгнэлтэд дараах зүйлс хамаарахгүй:

(А) (а) дэд хэсэгт тодорхойлсон хөөн хэлэлцэх хугацаа;

(В) яллах дүгнэлтэд тусгагдсан хэргүүдтэй холбогдуулан тухайн хүнийг баривчлах буюу зарлан дуудах хуудас өгөх хүртэл 208 дугаар бүлгийн заалтууд.

(3) Нэр томьёоны тодорхойлолт:

Энэ дэд хэсгийн зорилгын үүднээс "ДНХ-ийн профайл" гэсэн нэр томьёо нь ДНХ-ийн таних шинж чанаруудын багцыг хэлнэ.

18 U.S. Code § 3283 – Хүүхдийн эсрэг гэмт хэрэг

18-аас доош насны хүүхдэд бэлгийн болон бие махбодын хүчирхийлэл үйлдэх, хулгайлах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй.

18 U.S. Code § 3284 - Дампуурлын хөрөнгийг нуун дарагдуулах гэмт хэрэг

11 дүгээр зүйлд заасан хэрэгт хариуцагчийн эд хөрөнгийг нуун дарагдуулсан хариуцагчийг эцэслэн чөлөөлөх, эсхүл төлбөрөөс чөлөөлөхөөс татгалзах хүртэл үйлдэл нь үргэлжилсэн гэмт хэрэгт тооцогдох бөгөөд уг хэргийг эцэслэн хэрэгсэхгүй болгох хүртэл хөөн хэлэлцэх хугацаа эхлэхгүй.

18 U.S. Code § 3285 – Ял шийтгэл биелүүлэхгүй байх, шүүхийн шийдвэрийг үл хүндэтгэх

Аливаа хүн, корпорац, нийгэмлэг нь энэ хуулийн 402 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн бол буруутай үйлдлээс хойш нэг жилийн дотор хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Гэсэн хэдий ч үл хүндэтгэсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэдэг байсан ч энэ нь ижил гэмт хэрэгт тусдаа эрүүгийн хэрэг үүсгэхийг зогсоож

⁷⁸ Улсын Дээд Шүүх, “Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик (гарын авлага)”, УБ, 2011 он, 254 дэх тал.

		чадахгүй. 18 U.S. Code § 3286 - Терроризмын гэмт хэрэг (a) Найман жилийн хязгаарлалт.— 3282-р хэсгийг үл харгалзан, терроризмын гэмт хэрэг үйлдсэнээс хойш 8 жилийн дотор яллах дүгнэлт илрээгүй буюу мэдээлэл тогтоогдоогүй бол хэнд ч эрүүгийн хариуцлага ногдуулах ёсгүй. (б) Хязгаарлалтгүй.— 2332b(g)(5)(B)-д заасан гэмт хэрэг нь бусдын амь насыг хохироох, бие махбодод хүнд гэмтэл учруулах эрсдэлтэй буюу урьдчилан таамаглахуйц эрсдэлийг бий болгож байгаа бол гэмт этгээдийг яллах хугацаа байхгүй. Тодруулбал: АНУ-д хүн амины гэмт хэрэг нь цаазаар авах ялтай байдаг тул тус гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Мөн терроризмын гэмт хэрэг нь хүний амь насанд хүрэх эрсдэл өндөр байдаг тул хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, харин амь насанд хүрээгүй, амь насанд хүрэх хүнд гэмтэл учруулаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа 8 жил байна. Үүнээс гадна АНУ-д цагаан захтнуудын гэмт хэрэг (white collar crime)-ийн хөөн хэлэлцэх хугацаа мөн өөр өөр байдаг.					
4	Бүгд Найрамдах Эстони Улс	Ерөнхий зохицуулалт Эрүүгийн хууль (Penal code) 6 дугаар бүлэг 81 дүгээр зүйл Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа (1) Эрүүгийн гэмт хэрэг үйлдэж дууссанаас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл дараах хугацаа дууссан бол хэнийг ч эрүүгийн гэмт хэрэгт буруутгаж, шийтгэж болохгүй. - нэгдүгээр зэргийн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 10 жил; - хоёрдугаар зэргийн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 5 жил. Тодруулбал: Эстони улсын Эрүүгийн хуульд гэмт хэргийг нэгдүгээр зэрэг, хоёрдугаар зэрэг хэмээн ангилдаг. <u>Нэгдүгээр зэргийн гэмт хэрэг нь тус хуульд заасан гэмт хэрэгтэнд таван жилээс дээш хугацаагаар</u>	Хугацаа тоолж эхлэх 81 дүгээр зүйл (4) Хэд хэдэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн үйлдэл дууссанаар тооцно. Үргэлжилсэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг үргэлжилсэн үйлдлийг дуусгавар болгосноор тооцно. Тодруулбал: <i>Ямарваа нэгэн гэмт хэргийн үйлдлийг дуусгавар болгосноор хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлнэ.</i>	Хугацаа тасрах 81 дүгээр зүйл (5) Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд дараах байцаан шийтгэх үйлдлийг хийснээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасалдана: 1/сэжигтэн, яллагдагчид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, түүний эд хөрөнгө, мөнгө угаах гэмт хэргийн объект болох эд хөрөнгийг битүүмжлэх; 2) яллагдагчийг яллах; 3/ яллагдагч ирээгүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах; 4/шүүх хуралдаанд яллагдагчаас байцаалт авах; 5/шүүх хуралдаанд шинжээчийн дүгнэлт гаргах буюу нэмэлт нотлох баримт гаргах. (7) Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дараах тохиолдолд тасалдана: 1/ сэжигтэн, яллагдагч, байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй этгээд урьдчилан байцаан шийтгэх ажиллагаа, шүүхээс гадуурх байцаан шийтгэх ажиллагаа, шүүхээс оргон зайлсан тохиолдолд тухайн хүнийг саатуулах, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагад ирэх хүртэл; 2) гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээс хойш эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох 81 дүгээр зүйл (6¹) Рийгикогугийн гишүүдийн халдашгүй эрхтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх тухай заалтыг Рийгикогугийн гишүүдийн байдлын тухай хуулийн § 18¹-д заасан болно. Рийгикогугийн гишүүдийн байдлын тухай хууль § 18¹ дүгээр зүйл (1) Хэрэв Рийгикогу гишүүн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа бол уг хэргийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ. (2) Рийгикогу гишүүний талаар нэхэмжлэл гаргахыг зөвшөөрснөөр, эсвэл Рийгикогу гишүүний бүрэн эрх дуусгавар болсон үед хөөн хэлэлцэх хугацаа дахин үргэлжилнэ.	Хугацааг тоолохгүй байх 81 дүгээр зүйл (2) Түрэмгийллийн гэмт хэрэг, геноцидын гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, бүх насаар нь хорих ял оногдуулсан эрүүгийн гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй.	Хугацааг тодорхой хязгаартай тоолох 81 дүгээр зүйл (8) Энэ зүйлийн (7) (1), (2)-д заасан тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жилээс илүү хугацаа өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацааг сэргээж болохгүй. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас хойш 3 жилээс илүү хугацаа өнгөрсөн бол дахин сэргээж болохгүй. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа 3 жил

		хорих, эсхүл бүх насаар нь хорих ял оногдуулсан гэмт хэргийг; <u>хоёрдугаар зэргийн гэмт хэрэг</u> гэж тус хуульд заасан таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл эд хөрөнгийн ялаар шийтгэгдсэн гэмт хэргийг ойлгоно. Эстони улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа багадаа 5 жил, ихдээ 10 жил байхаар байна.		хүртэл; 3) 18 нас хүрээгүй хүний эсрэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хохирогчийг 18 нас хүртлээ эрүүгийн хэрэг үүсгэсэн шалтгаан нь хохирогч ийм насанд хүрэхээс өмнө тодорхой болоогүй бол. Шинээр тоолох (6) Эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан байцаан шийтгэх ажиллагааг гүйцэтгэснээр хөөн хэлэлцэх хугацаа дахин эхэлнэ. Гэсэн хэдий ч эрүүгийн гэмт хэрэг үйлдэж дууссанаас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаа энэ хуулийн (1) дэх хэсэгт заасан хугацаанаас таван жилээр илүү байвал тухайн этгээдийг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, шийтгэж болохгүй.			бол гэмт хэрэг дуусгавар болсноос хойш 10 жил өнгөрсөн бол түүнийг сэргээхгүй.
5	Япон Улс ⁷⁹	Ерөнхий зохицуулалт Эрүүгийн процессын хуулийн 250 дугаар зүйл. (1) Хүний амь насыг хохироосон гэмт хэрэг, хөдөлмөр эрхлүүлээгүй, эсхүл илүү хүндээр хорих ял оногдуулах гэмт хэрэг (цаазын ял оногдуулахаас бусад)-т дараах хугацаа өнгөрсний дараа хөөн хэлэлцэх хугацаа дуусна: (i) бүх насаар нь хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгт 30 жил; (ii) дээд тал нь 20 жилийн хугацаатай хорих, эсхүл хөдөлмөр эрхлэхгүй хорих ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 20 жил; (iii) өмнөх хоёр зүйлд зааснаас бусад гэмт хэрэгт 10 жил. (2) Хүний амь нас хохироосон, хөдөлмөр эрхлүүлээгүй, эсхүл илүү хүнд хэлбэрийн ял оногдуулахаас бусад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дараах хугацаа өнгөрсний дараа дуусна. (i) цаазаар авах ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 25 жил; (ii) бүх насаар нь хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүй бүх насаар нь хорих ял оногдуулсан гэмт хэрэгт 15 жил;	Хугацааг тоолж эхлэх Эрүүгийн процессын хуулийн 253 дугаар зүйл. (1) Хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг үйлдэгдсэн үеэс эхлэн тоологдоно. (2) Хамтран оролцогчтой холбоотой хэргийн хувьд, бүх хамсаатны хувьд хөөн	Хугацаа тасрах, шинээр тоолох Эрүүгийн процессын хуулийн 251 дүгээр зүйл. Хоёр буюу түүнээс дээш үндсэн ялыг хавсарч оногдуулах, эсхүл хоёр буюу түүнээс дээш үндсэн ялын аль нэгийг оногдуулах гэмт хэргийн	Хугацааг зогсоох, сэргээн тоолох Эрүүгийн процессын хуулийн 254 дүгээр зүйл. (1) Хөөн хэлэлцэх хугацаа нь холбогдох хэргийн эсрэг яллах үйл ажиллагаа явуулахаа больсон, шүүх эрх мэдлийн эрх хэмжээ хүрэхгүй гэж мэдэгдсэн эсвэл яллах ажиллагааг хэрэгсэхгүй болгосон шийдвэр эцэслэн хүчин төгөлдөр болсон үед тоологдож эхэлнэ. (2) Хамтран оролцогчийн аль нэгийг нь яллагдагчаар татсаны улмаас хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлсэн нь бусад хамтран оролцогчийн хувьд хүчин төгөлдөр болно. Энэ тохиолдолд түдгэлзүүлсэн хугацаа нь тухайн хэргийн шийдвэр эцэслэн хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоологдоно. 255 дугаар зүйл (1) Хэрэв гэмт хэрэгтэн Японоос гадуур байгаа эсвэл тухайн гэмт хэрэгтэн нуугдаж	Хугацааг тоолохгүй байх Эрүүгийн процессын хуульд энэ тухай заагаагүй.	Хугацааг тодорхой хязгаартай тоолох Эрүүгийн процессын хуулийн 252 дугаар зүйл. Эрүүгийн хуульд заасны дагуу ялыг нэмэгдүүлэх, хөнгөлөхөд 250 дугаар зүйлийн заалтыг нэмэгдүүлээгүй, хөнгөрүүлээгүй ялыг үндэслэн тоолно.⁸¹

⁷⁹ Japan's Code of Criminal Procedure (Act No. 131 of 1948) , <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3739/en>

⁸¹ Мөн тэнд .

		(iii) 15 жил ба түүнээс дээш хугацаагаар хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүй хорих ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 10 жил; (iv) 15 жилээс бага хугацаагаар хорих, эсхүл ажил хөдөлмөр эрхлүүлээгүй хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгт 7 жил; (v) 10 жилээс бага хугацаагаар хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүй хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгт 5 жил; (vi) 5 жилээс бага хугацаагаар хорих, эсхүл торгууль ногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 3 жил; (vii) баривчлах эсвэл бага хэмжээний торгууль ногдуулах шийтгэл ногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 1 жил.	хэлэлцэх хугацаа нь эцсийн үйлдэл зогссон үеэс эхлэн тоологдоно.	хувьд хамгийн хүнд ялын тухайд хөөн хэлэлцэх хугацааны заалтыг хэрэглэнэ. ⁸⁰	байгаа үед ялын хуудас өгөх, хураангуй тушаалыг мэдэгдэх боломжгүй бол тухайн гэмт хэрэгтэн Японоос гадуур байх хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ. (2) Шүүхийн журамд гэмт хэрэгтэн Японоос ирээгүй буюу нуугдаж байгаа эсэхийг нотлоход шаардлагатай заалтуудыг тусгасан бөгөөд үүнд яллагдагчаар татах тогтоол, хураангуй тушаалын талаар мэдэгдэх боломжгүй болсон байх ёстой.		
6	Бүгд Найрамдах Солонгос Улс ⁸²	Ерөнхий зохицуулалт Эрүүгийн процессын хуулийн 249 дүгээр зүйл. Улсын яллах хөөн хэлэлцэх хугацаа. (1) Улсын яллах тогтоол нь дараах хугацаа дууссаны дараа дуусгавар болно. 1. Цаазаар авах ялаар шийтгэх гэмт хэрэгт хорин таван жил; 2. Бүх насаар нь хорих ялаар шийтгэх, эсхүл бүх насаар хөдөлмөрлүүлж хорих ял оногдуулах гэмт хэрэгт арван таван жил; 3.Хорих, эсхүл арав ба түүнээс дээш жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол арван жил; 4. Хорих, эсхүл арваас доошгүй жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол долоон жил; 5.Хорих, эсхүл таван жилээс доошгүй хугацаагаар хорих ял оногдуулах, эсхүл арваас	Хугацааг тоолж эхлэх Эрүүгийн процессын хуулийн 252 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх (1) Эрүүгийн хэрэг үйлдэж дууссаны дараа хөөн хэлэлцэх хугацаа эхэлнэ. (2) Хамтран үйлдэгчийн хувьд эрүүгийн хэрэг эцэслэн	Хугацаа тасрах, шинээр тоолох Эрүүгийн процессын хуулийн 250 дугаар зүйл. Хоёр ба түүнээс дээш ялын хөөн хэлэлцэх хугацаа Хоёр буюу түүнээс дээш үндсэн ялыг хамтад нь ногдуулах, эсхүл хоёр ба түүнээс дээш үндсэн ялаас нэгийг нь оногдуулах гэмт хэргийн хувьд хамгийн хүнд ялыг	Хугацааг зогсоох, сэргээн тоолох Эрүүгийн процессын хуулийн 253 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх, түүний үр нөлөө (1) Улсын яллах ажиллагааг хэрэгсэхгүй болгосон, шүүхийн харьяаллыг зөрчсөнийг нотолсон шийдвэр эцсийн байдлаар хүчин төгөлдөр болмогц хөөн	Хугацааг тоолохгүй байх -Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалах гэмт хэргийг шийдэх тухай хуулийн 6 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй байх. Геноцидын төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй. (Геноцидын төрлийн гэмт хэрэг гэдэгт геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргүүд хамаарна.) - Хүчингийн гэмт хэрэг, хүн амины хэрэг үйлдэгдсэн бол хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй. (Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шийтгэх тухай тусгай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Хүүхэд, өсвөр насныхны бэлгийн хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг) - Хүний амь насыг хөнөөсөн хэргээр цаазаар авах ял оногдуулах гэмт хэрэг	Хугацааг тодорхой хязгаартай тоолох Эрүүгийн процессын хуулийн 249 дүгээр зүйл. Улсын яллах ажиллагаа явуулж, эцсийн шийдвэр гаргаагүй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн улсын ялласан өдрөөс хойш хорин таван жил байн. Эрүүгийн процессын хуулийн 251 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд заасны дагуу ялыг нэмэгдүүлэх, хөнгөлөх тохиолдолд 249 дүгээр зүйлийн заалтыг нэмэгдүүлэх, хөнгөлөхөөс өмнөх ялыг харгалзан үзнэ. Хүчингийн болон танхайрлын гэмт хэргийн хувьд гэмт хэргийг нотлох шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримт, тухайлбал ДНХ-ийн нотлох баримт байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг 10 жилээр сунгадаг. (Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шийтгэх тухай тусгай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд, өсвөр үеийнхний бэлгийн харилцааг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг зөрчсөн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа санал хураалт явуулснаас хойш гурван сарын дараа дуусна. Харин гэмт хэрэгтэн оргон зайлсан тохиолдолд хугацаа нь нэг жил байна. (Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 122 дугаар зүйл) Төрийн албан хаагчийн тухай хууль, орон нутгийн төрийн албан хаагчийн тухай хуулийг зөрчсөн гэмт хэргүүдийн дотроос улс төрийн үйл ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байна. (Үндэсний төрийн албан хаагчийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Орон нутгийн төрийн албан хаагчийн тухай

⁸⁰ Мөн тэнд.

⁸² Criminal Procedure Act of Korean, Expand Act No. 9765, jun. 9, 2009, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535

		доошгүй жилээр мэргэшүүлэхийг түдгэлзүүлэх, эсхүл торгох шийтгэл оногдуулсан гэмт хэрэгт таван жил; 6.Мэргэжлийн эрхийг дээд тал нь таваас доошгүй жилээр хасах шийтгэл оногдуулах гэмт хэрэгт гурван жил; болон 7.Мэргэжлийн эрхийг таваас доошгүй жилээр хасах, эсхүл сахилгын шийтгэл ногдуулах, хөнгөн торгох, эд хөрөнгө хураах шийтгэл оногдуулсан гэмт хэрэгт нэг жил. (2) Улсын яллах ажиллагаа явуулж, эцсийн шийдвэр гаргаагүй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн улсын ялласан өдрөөс хойш хорин таван жил байна.	зогссон үеэс хөөн хэлэлцэх хугацаа эхэлнэ.	харгалзан өмнөх зүйлийн заалтыг хэрэглэнэ.⁸³	хэлэлцэх хугацаа нь улсын яллах ажиллагааг зогсоож, тоологдож эхэлнэ. (2) Өмнөх хэсэгт дурдсан хэд хэдэн хамтран оролцогчийн аль нэгнийх нь эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг бусад хамтран оролцогчдын хувьд түдгэлзүүлж, холбогдох хэргийн шийдвэр эцэслэн гарсны дараа дахин яллаж эхэлнэ. (3) Гэмт этгээд эрүүгийн ялаас мултрах	(Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 253-2, Цэргийн шүүхийн 295-2-р зүйл)-д хөөн хэлэлцэх хугацаа (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 253-2, Цэргийн шүүхийн 295-2-р зүйл)-д хөөн хэлэлцэх хугацаа	хуулийн 82 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) Энэхүү тусгай заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Цэргийн гэмт хэргийн тухай хууль, Үндэсний тагнуулын албаны тухай хуулийг зөрчсөн гэмт хэргүүдийн дотор улс төрийн оролцооны хөөн хэлэлцэх хугацаа мөн 10 жил байна. (Цэргийн гэмт хэргийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Үндэсний тагнуулын албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) Төрийн албаны сонгуулийн тухай хуулийг зөрчсөн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа сонгуулийн өдрөөс хойш 6 сарын дараа (сонгуулийн өдрөөс хойш үйлдсэн гэмт хэргийн хувьд, үйлдэл гарсан өдрөөс хойш 6 сарын дараа) дуусна. (Төрийн албаны сонгуулийн тухай хуулийн 268 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) Гэсэн хэдий ч зарим үл хамаарах зүйлүүд байдаг. Цэргийн албыг хаасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байдаг ч тухайн алба бүрийн штабын дарга хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө буцах тушаал гаргадаг тул 10 жилийн дараа ч гэсэн тушаал зөрчсөн тохиолдолд шийтгэгдэг. . Даалгавар зөрчсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байдаг ч хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө ажилд эгүүлэн тогтоолгох тушаал удаа дараа гарсан тохиолдолд энэ нь мөн зогсдог. Цэргийн албан тушаалаас цэргээ тэтгэвэрт гарах насанд хүрмэгц буцаж ирэх сүүлчийн тушаалыг арми тус бүрийн штабын дарга гаргадаг тул цэргээс цэргээ орхих шийтгэл хүлээхээс зайлсхийхийн тулд та цэргийн цолны тэтгэвэрт гарах нас + 5 жил өнгөрөх хүртэл хүлээх хэрэгтэй⁸⁵.
--	--	--	---	--	---	---	--

⁸³ Мөн тэнд .

⁸⁴ 공소시효, <https://namu.wiki/w/%EA%B3%B5%EC%86%8C%EC%8B%9C%ED%9A%A8>

⁸⁵ Мөн тэнд.

					зорилгоор гадаадад байх хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлн э.		
7	Оросын Холбооны Улс	Ерөнхий зохицуулалт Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар анх 1775 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Екатерина II хатан хааны зарлигийн 44 дүгээр зүйлд тусгагдсан. ЗХУ-ын хууль тогтоомжуудад хөөн хэлэлцэх хугацааны талаар 1922 оны Эрүүгийн хуулийн 21-22 дугаар зүйлүүдэд орчин үед хэрэглэгдэж байсан уг агуулгаар нь анх зохицуулсан. ⁸⁶ Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1996 оны Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг зохицуулсан. ⁸⁷ ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил, хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил, онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил хөөн хэлэлцэх хугацаатай байхаар	Хугацааг тоолж эхлэх Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг <u>эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс</u> эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолно" гэж заасан. ⁸⁹	Хугацаа тасрах, шинээр тоолох Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хөөн хэлэлцэх хугацаанд шинэ гэмт хэрэг үйлдсэн бол хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо гэмт хэрэг тус бүрээр тусад нь тоолно гэж зохицуулсан байна. ⁹⁰	Хугацааг зогсоох, сэргээн тоолох Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь зүйлд зааснаар мөрдөн шалгах ажиллагаа эсхүл шүүх хуралдаанаас оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. ⁹¹	Хугацааг тоолохгүй байх Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар бусад улс орнуудын жишгээр хүн төрөлхтний эсрэг, түрэмгий дайн төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх, төрлөөр устгах, экосистемийг сүйтгэх зэрэг гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй гэжээ. Мөн хуулийн 78.4 дэх хэсэгт зааснаар бүх насаар хорих эсхүл цаазаар авах ял оноох гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв хөөн хэлэлцэх хугацаа дууссантай холбоотойгоор уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжгүй гэж үзвэл шүүх бүх насаар хорих эсхүл цаазаар авах ялыг хэрэглэхгүй гэжээ.	Хугацааг тодорхой хязгаартай тоолох Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолно" гэж заасан нь хөөн хэлэлцэх хугацааг тодорхой хугацаатайгаар тоолох онцлогтой зохицуулалт юм.

⁸⁶ С.Өмирбек, Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа, <https://omir.blogmn.net/116964/gemt-hergiig-huun-helelceh-hugacaa,-tuuniig-tooloh-juram,-harcuulsan-sudalgaa.html>.

⁸⁷ ОХУ-ын Эрүүгийн хууль, <https://www.legal-tools.org/doc/8eed35/pdf/>

⁸⁹ Мөн тэнд.

⁹⁰ Мөн тэнд.

⁹¹ Мөн тэнд.

		хуульчилсан. ⁸⁸					
8	Шведийн Хаант Улс ⁹²	Ерөнхий зохицуулалт Тус улсын Эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж нь 1962 оны Эрүүгийн хууль бөгөөд тус хуулийн 35 дугаар бүлэгт хөөн хэлэлцэх хугацааг зохицуулсан. Яллагдагчаар татсан тухай мэдэгдлийг хүргүүлээгүй эсхүл баривчлагдаагүй бол хөөн хэлэлцэх хугацааг дараах 5 төрлөөр тогтоосон байна. Үүнд, гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээ 1 жилээс ихгүй бол 2 жил, 2 жилээс ихгүй бол 5 жил, 8 жилээс ихгүй бол 10 жил, 8 жилээс их бол 15 жил, бүх насаар хорих ял ногдуулах бол 25 жил байхаар тус тус заажээ.⁹³	Хугацааг тоолж эхлэх ЭХ-ийн 35 бүлгийн 4 дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс тооцно. Гэвч гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд хор уршиг байхыг шаардсан бол хор уршиг илэрсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тооцно. Эрүүгийн хуулийн 35 дугаар бүлгийн 4 дэх хэсэгт зааснаар дараах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хохирогч 18 нас хүрсэн эсхүл хүрэх өдрөөс эхлэн тоолно гэжээ. Үүнд:⁹⁴ 6-р бүлгийн 4-6, 8, 9 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх, түүнд завдах 6-р бүлгийн 1-3, 10, 12 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх, эсхүл 6-р бүлгийн 1, 2, 12 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт завдах (18 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн байх) 16 бүлгийн 10а хэсгийн 1 болон 6 дахь заалтад заасан гэмт хэргийг үйлдсэн эсхүл түүнд завдсан (хүүхэд оролцуулж порнограф бүтээсэн бөгөөд 1 дэх заалтыг хэрэглэх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг дараа нь тоолохгүй) - Эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх гаж зан үйлийн эсрэг хуулийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг 18 насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол; Нягтлан бодох бүртгэлийг санаатайгаар өөрчилсөн, нуусан хөнгөн бус гэмт хэргийн хувьд тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дампуурал зарласан өдрөөс эсхүл компанийн бүтцийг өөрчлөх хурлаар зээлдэгчээс өрийг тодорхой хэмжээгээр тооцож дуусгавар болгох санал ирсэн эсхүл ийм санал хүлээж авсан өдрөөс тооцно. (Гэвч дээрх нөхцөл байдлууд нь гэмт хэрэг үйлдсэнээс 5 жилийн дотор бий	Хугацаа тасрах, шинээр тоолох Хөөн хэлэлцэх хугацааны явцад дахин шинэ гэмт хэрэг үйлдэх тохиолдлыг нарийвчлан зохицуулаагүй. Гэвч ЭХ-ийн 35 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт зааснаар үйлдэл нь хэд хэдэн гэмт хэргийн шинжийг хангаж байх тохиолдолд тэдгээрийн аль нэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохоор бол 35.1 дэх хэсгийг үл харгалзан тэдгээрийн тус бүрд нь эрүүгийн хариуцлага ногдуулж болно гэжээ.	Хугацааг зогсоох, сэргээн тоолох Хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, сэргээн тоолох зохицуулалт нарийвчлан тусгагдаагүй.	Хугацааг тоолохгүй байх Эрүүгийн хуулийн 35 дугаар бүлгийн 2 дахь хэсэгт зааснаар дараах тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй. Үүнд: - ЭХ-ийн 3-р бүлгийн 1, 2 дахь хэсэгт заасан хүнийг санаатай болон болгоомжгүй алах гэмт хэрэг үйлдсэн; - ЭХ-ийн 6-р бүлгийн 1 дэх хэсгийн 1 болон 3 дахь заалт дахь хүчиндэх гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон эсхүл эрхшээлдээ байсан хүнийг хүчиндсэн гэмт хэрэг (Гэвч хохирогч нь 18 нас хүрээгүй байх) үйлдсэн бол; - ЭХ-ийн 6-р бүлгийн 4 дэх хэсэгт заасан 15 нас хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн бол; - Эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх гаж зан үйлийн эсрэг хуулийн 2 дахь хэсгийн 1 болон 3 дахь заалтад заасан гэмт хэргийг 18 насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол; - Зарим төрлийн олон улсын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуульд заасан төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, дайн өдөөх гэмт хэрэг үйлдсэн бол - Терроризмын гэмт хэргийн тухай хуулийн 4 дэх хэсэгт заасан террорист үйлдэл үйлдсэн бол - Энэ хэсгийн 1, 5, 6 дахь гэмт хэрэгт завдсан бол. Гэвч дээрх гэмт хэргийг 18 насанд хүрээгүй хүн үйлдсэн бол хөөн хэлэлцэх хугацаа үйлчилнэ.	Хугацааг тодорхой хязгаартай тоолох Эрүүгийн хууль бөгөөд тус хуулийн 35 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт яллагдагчаар татсан тухай мэдэгдлийг хүргүүлээгүй эсхүл баривчлагдаагүй бол хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор тогтоосон байна. Өөрөөр хэлбэл яллагдагчаар татсан тухай мэдэгдлийг хүргүүлэх эсхүл баривчлах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалт нь хөөн хэлэлцэх хугацааг тодорхой хугацаатайгаар тоолох онцлогтой

⁸⁸ Мөн тэнд.

⁹² Шведийн Эрүүгийн хууль, <https://www.government.se/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf>

⁹³ Мөн тэнд.

⁹⁴ Мөн тэнд.

			болсон байх).					зохицуулалт юм.
9	Норвегийн Хант Улс ⁹⁵	Ерөнхий зохицуулалт Тус улсын 2005 оны Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тогтоожээ. Үүнд: а. Хорих ялын дээд хэмжээ 1 жилээс ихгүй бол 2 жил б. Хорих ялын дээд хэмжээ 3 жилээс ихгүй бол 5 жил в. Хорих ялын дээд хэмжээ 10 жилээс ихгүй бол 10 жил г. Хорих ялын дээд хэмжээ 15 жилээс ихгүй бол 15 жил д. Хорих ялын дээд хэмжээ 21 жилээс ихгүй бол 25 жил Торгох ялтай гэмт хэргийн хувьд торгох ялыг хорих ялд шилжүүлж хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлно. 89 дүгээр зүйлд хуулийн этгээдтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон байх бөгөөд түүнд холбогдох гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцохдоо эрх бүхий албан тушаалтанд оногдуулах хорих ялын дээд хэмжээг үндэслэнэ гэжээ.	Хугацааг тоолж эхлэх ЭХ-ийн 87 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тооцно. ЭХ 87 дугаар зүйлд зааснаар ЭХ-ийн 253, 257, 282, 284, 299 болон 302 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хохирогч 18 нас хүрснээс тоологдоно. Цаашлаад гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд хор уршиг байхыг шаардсан бол хор уршиг илэрсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тооцно. ЭХ-ийн 90 дүгээр зүйлд зааснаар ЭХ 392, 394 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дампуурлын ажиллагаа эсхүл өр тооцох ажиллагааны явцад тоолохгүй гэжээ.	Хугацаа тасрах, шинээр тоолох Хөөн хэлэлцэх хугацааны явцад дахин шинэ гэмт хэрэг үйлдэх тохиолдлыг нарийвчлан зохицуулаагүй. Гэвч ЭХ-ийн 86 дугаар зүйлд зааснаар нэг үйлдлээр хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол аль урт хөөн хэлэлцэх хугацааг бүх гэмт хэрэгт хэрэглэнэ гэжээ.	Хугацааг зогсоох, сэргээн тоолох ЭХ-ийн 88 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхийг тооцохдоо мөрдөн шалгах ажиллагааны хугацааг оруулж тооцно. Гэвч мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлснаас үүдэн мөрдөн шалгах ажиллагаа түдгэлзсэн хугацааг үүнд оруулж тооцохгүй гэжээ. ⁹⁶	Хугацааг тоолохгүй байх ЭХ-ийн 91 дүгээр зүйлд зааснаар дараах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. Үүнд, төрлөөр устгах, дайны гэмт хэрэг болон 15 болон түүнээс дээш хорих ял ногдуулах террорист гэмт үйлдэл хамаарна. ⁹⁷ ЭХ-ийн 275, 291, 299 болон 302 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. Мөн 355 дугаар хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний	Хугацааг тодорхой хязгаартай тоолох ЭХ-ийн 88 дугаар зүйлд зааснаар сэжигтэн яллагдагчаар татагдсанаар 86 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаа зогсоно. ЭХ-ийн 88 дугаар зүйлд зааснаар мөрдөн шалган ажиллагааг үргэлжлүүлэх тухай дээд шатны прокурорын шийдвэр гараагүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоох зохицуулалтын үйлчлэл зогсоно. Мөн мөрдөн шалгах ажиллагааг хугацаагүйгээр түдгэлзүүлсэн тохиолдолд дээрх зохицуулалт хэрэглэгдэнэ. ⁹⁹	

⁹⁵ Norwegian Penal Code, https://lovdata.no/dokument/NLE/lov/2005-05-20-28/KAPITTEL_1#KAPITTEL_1

⁹⁶ Мөн тэнд.

⁹⁷ Мөн тэнд.

⁹⁹ Мөн тэнд.

						амь нас хохирсон бол хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. ⁹⁸	
10	Олон улсын гэрээ, конвенцийн зохицуулалт	“Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”-ийн 29 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх Шүүхийн харьяалалд хамаарах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй¹⁰⁰. НҮБ-ын 1970 онд батлагдсан “Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай конвенц” I дүгээр зүйл. Дараах гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс үл хамааран хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй. (а) 1945 оны 8-р сарын 8-ны өдрийн Нюрнберг дэх Олон улсын цэргийн шүүхийн дүрэмд тодорхойлсон дайны гэмт хэрэг, 1946 оны 2-р сарын 13-ны өдрийн 3 (I), 1946 оны 12-р сарын 11-ний өдрийн 95 (I) тогтоолоор батлагдсан Олон улсын цэргийн гэмт хэрэг. Нэгдсэн Үндэстний Байгууллага, ялангуяа 1949 оны 8-р сарын 12-ны Женевийн конвенцод дайнд нэрвэгдэгсдийг хамгаалах талаар дурдсан “ноцтой зөрчлүүд”; (б) 1945 оны 8-р сарын 8-ны өдрийн Нюрнберг дэх Олон улсын цэргийн шүүхийн дүрэмд тодорхойлогдож, 1946 оны 2-р сарын 13-ны өдрийн 3 (I) ба 95-р тогтоолоор батлагдсан дайны үед эсвэл энх тайвны үед үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг. (I) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12-р сарын 11-ний өдрийн 1948 оны Конвенцид заасан апартеидын бодлогын үр дүнд бий болсон зэвсэгт халдлага, эзлэн түрэмгийлэл, хүнлэг бус үйлдлээр нүүлгэн шилжүүлэх, геноцидын гэмт хэрэг. Геноцид гэмт хэрэг (ийм үйлдэл нь үйлдэгдсэн улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчөөгүй ч гэсэн хамаарна) II дугаар зүйл Хэрэв I зүйлд дурдсан гэмт хэргүүдийн аль нэг нь үйлдэгдсэн бол эдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд гол үүрэг гүйцэтгэгч, хамсаатнаар оролцсон, эсхүл бусдыг шууд турхирсан төрийн эрх бүхий байгууллагын төлөөлөгчид болон хувь хүмүүст энэхүү конвенцын заалт хамаарна. Эсхүл гүйцэтгэсэн зэрэглэлээс үл хамааран тэдгээрийг үйлдэхээр тохиролцсон хүмүүс, мөн тэдний хийсэн ажлыг хүлээн зөвшөөрсөн төрийн байгууллагын төлөөлөгчдөд хамаарна. III дугаар зүйл Энэхүү конвенцод оролцогч улсууд энэхүү конвенцын II зүйлд дурдсан хүмүүсийг олон улсын эрх зүйн дагуу шилжүүлэн өгөх боломжийг бүрдүүлэхийн тулд хууль тогтоомжийн болон бусад шаардлагатай дотоодын бүх арга хэмжээг авах үүрэгтэй. IV дүгээр зүйл Энэхүү конвенцод оролцогч улсууд өөрсдийн үндсэн хуульд заасан журмын дагуу I, II зүйлд дурдсан гэмт хэргийг мөрдөн мөшгөх, шийтгэхэд хуулийн болон бусад хязгаарлалт үйлчлэхгүй байхын тулд шаардлагатай аливаа хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээг авах үүрэгтэй. Энэхүү конвенцид хамаарах бөгөөд хэрэв байгаа бол эдгээр хязгаарлалтыг цуцална¹⁰¹. Европын зөвлөлөөс 1974 онд батлагдсан “Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт хуулийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай Европын конвенц” 1 дүгээр зүйл Хэлэлцэн тохирогч улс бүр дараах гэмт хэргийн мөрдөн байцаалтад хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх, эсхүл тухайн гэмт хэрэгт оногдуулсан ялыг хэрэгжүүлэхэд дотоодын хууль тогтоомжийн дагуу шийтгэгдэх боломжтой байхаар шаардлагатай арга хэмжээг авах үүрэг хүлээнэ. 1. 1948 оны 12 дугаар сарын 9-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Геноцид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенцод заасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг; 2 Дайны талбай дахь зэвсэгт хүчинд шархадсан болон өвчтэй хүмүүсийн байдлыг сайжруулах тухай 1949 оны Женевийн конвенцын 50 дугаар зүйл, 1949 оны Шархадсан, өвчтэй, хөлөг онгоцны сүйрсэн гишүүдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенцийн 51 дүгээр зүйлд заасан зөрчлүүд. Тэнгис дэх Зэвсэгт хүчний тухай, Дайны					

⁹⁸ Мөн тэнд.

¹⁰⁰ Rome Statute of the International Criminal Court, <https://www.icc-cpi.int/sites/default/files/Publications/Rome-Statute.pdf>

¹⁰¹ Convention on the Non-Applicability of Statutory Limitations to War Crimes and Crimes Against Humanity Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2391 (XXIII) of 26 November 1968, https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtidsg_no=IV-6&chapter=4&clang=en

		олзлогдогсодтой харьцах тухай 1949 оны Женевийн конвенцийн 130 дугаар зүйл, Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенцын 147 дугаар зүйл, энэ конвенц хүчин төгөлдөр болох үед хүчин төгөлдөр болсон дайны хууль тогтоомж болон Женевийн конвенцын дээр дурдсан зүйл заалтад тусгагдаагүй тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан дайны ёс заншилтай харьцуулж болох аливаа зөрчил, (бодит болон санаатай шинж чанар, эсвэл урьдчилан таамаглаж болох үр дагаврын цар хүрээний хувьд онцгой ноцтой шинж чанартай) 3. 6 дугаар зүйлд заасан мэдэгдлийн дагуу холбогдох Хэлэлцэн тохирогч улс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсантай харьцуулж болохуйц шинж чанартай гэж үзсэн, цаашид тогтоогдож болох олон улсын эрх зүйн дүрэм, заншлыг зөрчсөн бусад аливаа зөрчил¹⁰².
--	--	---

¹⁰² European Convention on the Non-Applicability of Statutory Limitation to Crimes against Humanity and War Crimes Strasbourg, 25.I.1974, <https://rm.coe.int/168007617f>



Харьцуулсан лавлагааны дүгнэлт:

Харьцуулсан лавлагааны хүрээнд нийт Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улс гэх 8 улсын хүрээнд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг Монгол Улстай харьцуулан судалснаас гадна олон улсын гэрээ, конвенцын зохицуулалтыг судалсан болно. Тус харьцуулсан лавлагааны хүрээнд дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Монгол Улсын хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлээр зохицуулж байна. Судалсан гадаадын улс, орнуудын тухайд ихэвчлэн Эрүүгийн хуулиар зохицуулж байх хэдий ч Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын тухайд Эрүүгийн процессын хуулиар зохицуулж байгаа нь ажиглагдлаа. Мөн хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалтыг авч үзэхдээ өөр өөрийн онцлогтой буюу Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал, ялын төрөл, интервалыг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг тогтоож байна. Мөн тусгайлсан зохицуулалтуудыг ч хуульчилсан байна. Жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улсад яллах ажиллагаа явуулж, эцсийн шийдвэр гаргаагүй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 25 жил байхаар тусад нь тогтоосон; Америкийн Нэгдсэн Улсад тусгайлсан гэмт хэргүүдэд хязгаарлагдмал байдлаар тогтоосон байна.

- Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Монгол Улс, бусад судалсан гадаадын улс, орнуудын тухайд ихэвчлэн гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс тоолж эхэлж байна. Гэсэн хэдий ч зарим улс, оронд онцлог зохицуулалтыг тусгажээ. Тодруулбал, Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Шведийн Хаант Улсад гэмт хэргийн бүрэлдэхүүн болж буй үр дүн хожим бий болсон буюу хор уршиг илэрсэн цаг үеэс хөөн хэлэлцэх хугацааг тооцохоор зохицуулжээ. Мөн Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улсын тухайд хохирогчийг 18 нас хүрснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолох, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хэрэг бол дампуурлын үеэс тоолох зэрэг зохицуулалтыг тусгасан байна. Түүнчлэн судалсан улс, орнуудын хүрээнд хэд хэдэн гэмт хэрэг, үргэлжилсэн үйлдэлтэй гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолж эхлэх, хамтран оролцогчтой гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолж эхлэх тухай зохицуулсныг анхаарах нь зүйтэй.

- Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолох тухайд Монгол улсынхтай адил дахин гэмт хэрэг үйлдсэн, ял оногдуулсан тохиолдолд үйлчлэх зохицуулалтуудтай улс, орнууд байна. Тухайлбал, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улсын тухайд ижилхэн зохицуулалттай хэдий ч гэмт хэрэг тус бүрд хөөн хэлэлцэх хугацаа тооцох, хүнд ялтай, илүү урт хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэргийг сонгох зэргээр өөр өөрөөр зохицуулсан байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын тухайд хөөн хэлэлцэх хугацаа тасрах 13 үндэслэлийг, Бүгд Найрамдах Эстони Улсын тухайд 7 үндэслэлийг тусгасан ба шинээр тоолох зохицуулалтыг ч нарийвчилж авч үзжээ.



- Монгол Улсын Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоохтой холбоотой зохицуулалттай адил үндэслэлээр хөөн хэлэлцэх хугацааг зогсоох үндэслэл бусад судалсан гадаадын улс, орнуудад ажиглагдаж байна. Гэхдээ өөр өөрийн онцлог байдлаар авч үзжээ. Тодруулбал, Оросын Холбооны Улс, Норвегийн Хант Улсын тухайд мөрдөн шалгах ажиллагааны үед оргон зайлбал хөөн хэлэлцэх хугацааг зогсоохоор тусгасан. Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын тухайд гадаад улсад байгаа тохиолдолд болон хамтран оролцогчтой хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг зогсоохыг болон хугацааг сэргээн тоолох талаар нарийвчлан авч үзсэнийг анхаарах шаардлагатай. Мөн Холбооны Бүгд Найрамдах Герман улс нь тодорхой төрлийн гэмт хэргүүдийн тухайд хохирогчийг 30 нас хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тооцдог байна. Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Эстони Улсад парламентын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд түүний хөөн хэлэлцэх хугацааг тооцох зохицуулалтыг нарийвчлан авч үзжээ.

- Монгол Улс болон бусад судалсан гадаадын улс, орнуудыг мөн авч үзвэл түрэмгийллийн гэмт хэрэг, геноцидын гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байгаа нь нийтлэг жишиг болж байна. Энэ нь НҮБ-ын 1970 оны “Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай конвенц” болон бусад олон улсын гэрээ, конвенцын агуулгатай нийцэж байна. Гэхдээ улс, орнуудын онцлогоос хамаарч хүнийг алах, бага насны хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэх, терроризм үйлдэх гэх мэт хүнд, ноцтой гэмт хэргүүд болон бүх насаар хорих ял оногдуулах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байна.

- Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хязгаартайгаар тоолох тухайд судалсан гадаад улс, орнуудад хөөн хэлэлцэх хугацааг сэргээх боломжгүй тохиолдол, хөөн хэлэлцэх хугацааг сунгах, ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх тохиолдолд тооцох, зарим төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг өөрөөр тоолох зэргийг тусгасан байгаа нь Монгол Улсын зохицуулалтаас онцлогтой байна.